



unesco

International Institute
for the Study of
Nomadic Civilizations
under the auspices
of UNESCO

Тогтвортой ноолуурын ёсзүйг тайлах нь

Хээрийн судалгааны тайлан

С.Мижид (НСИСОУХ)

Ч.Мөнхтуул (НСИСОУХ)

Эрик Трифт (Виннипегийн Их Сургууль)

Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн

Энэхүү тайланг Канад Улсын Нийгэм, Хүмүүнлэгийн Шинжлэх Ухааны Хорооны санхүүжилтээр ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, Канадын Виннипегийн их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “ТОГТВОРТОЙ НООЛУУР: ЁС ЗҮЙГ ТАЙЛАХ НЬ” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Улаанбаатар хот

2024 он

| | |
|---|----|
| Өмнөх үг | 1 |
| Товч тайлан | 2 |
| Ажлын зорилго | 2 |
| Судалгааны арга зүй | 2 |
| Судалгааны тоног төхөөрөмж | 2 |
| Судалгааны санхүүжилт | 3 |
| Судалгааны багийн бүрэлдэхүүнд | 3 |
| Хээрийн судалгааны нэгдүгээр ээлж | 3 |
| Судалгааны үр дүн | 3 |
| Судалгааны ажлын үндэслэл | 7 |
| Нэгдүгээр бүлэг: Цагаан Алт | 15 |
| Удиртгал: Цагаан Алт | 15 |
| Малчны бүтээмж, зохион байгуулалт | 18 |
| Малчдын тухай | 18 |
| Малчдын эдийн засгийн бүтээмж | 23 |
| Архангай аймгийн Өндөр уулын бүсийн эдийн засгийн нөхцөл байдал | 24 |
| Тулгарах бэрхшээл | 26 |
| Ноолуурын эдийн засгийн үр ашиг /жишээ/ | 32 |
| Ноолуурын үйлдвэрлэлийн соёлын үнэ цэнэ | 38 |
| Малын буян хишиг | 38 |
| Ямаа буяны аргамж болох тухай | 41 |
| Сэтэр: Малын буян хишиг тогтоогч | 44 |
| Улаан ямааны өвчүүгээр гал тахих зан үйл | 47 |
| Ямааны бөөрний өөх нь тосон урлалын түүхий эд болох тухай | 50 |

| | |
|---|----|
| Ямааны махны тухай | 51 |
| Ноолуурын шууд бус оролцоотой мал аж ахуйн соёлын өвд үзүүлж буй хувь нэмэр | 52 |
| Шар эдэлгээнд сургах тухай | 54 |
| Үхэр тэрэгний тухай | 56 |
| Үхэр тэрэг ачих тухай | 60 |
| Ноолуур бэлтгэх | 61 |
| Ямаа самнах хугацаа | 62 |
| Ямааны сам | 63 |
| Ямаа самнах | 65 |
| Ноолуурын ченж | 70 |
| Нэгдүгээр бүлгийн дүгнэлт | 74 |
| Хоёрдугаар бүлэг: өмнөговь аймгийн номгон суманд хийсэн хээрийн судалгааны тайлан | 76 |
| Удиртгал | 76 |
| Судалгаанд хамрагдсан малчдын ерөнхий мэдээлэл | 79 |
| Номгон сумын бэлчээр, түүнд хандах малчдын хандлага | 79 |
| Номгон суман дахь ямааны үүлдэр, түүнийг маллах арга ажиллагаа | 82 |
| Номгон сумын хоршоо | 85 |
| Дүгнэлт: Байгаль, нийгэм соёлын үнэ цэнэ | 87 |
| Гуравдугаар бүлэг: баянхонгор аймгийн шинэжинст, баянговь суманд хийсэн хээрийн судалгааны тайлан | 89 |
| Удиртгал | 89 |
| Цагаан Ямаа | 91 |
| Малчдын Хоршоо | 92 |
| “Цармын цагаан сувд” хоршоо | 93 |

| | |
|--|-----|
| “Цагаан Ямаат” хоршоо | 98 |
| Цагаан ямаат хоршооны бүтэц бүрэлдэхүүн | 101 |
| Малын үүлдэр угсаа, эрүүл мэндийн үйлчилгээ | 106 |
| Ноолуурын баяр: Малчидад чиглэсэн урамшуулал | 107 |
| Бүлгийн дүгнэлт | 110 |
| Дүгнэлт | 111 |
| Ном зүй | 115 |

Өмнөх үг

“Тогтвортой ноолуур: ёс зүйг тайлах нь” сэдэвт судалгааны ажлыг илтгэл хүлээлгэн даалгаж, бүх талаар дэмжиж тусалсан ЮНЕСКО-гийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн захирал, доктор Ч.Мөнхтуул болон хүрээлэнгийнхээ хамт олонд талархал илэрхийлье. Судалгааны бүхий л шатанд өөрсдийн үнэтэй зөвлөгөө, зөвлөмж, бүх л талын дэмжлэг үзүүлж байсанд нь баярлалаа.

Мөн судалгааны тайлан боловсруулахад аргагүйгээр тусалсан тус судалгааны ажлын монгол талын удирдагч доктор И.Бямбабаатар, Канадын талын удирдагч доктор Эрик Трифт (Eric Thrift) нарт, мөн хээрийн судалгаанд хамтран оролцож, хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Зулбаатар, Б.Бумбаяр, Г.Содбаяр, С.Мөнх-очир, гэрээт эрдэм шинжилгээний ажилтан М.Пагмадулам, Б.Наранбаатар, Б.Ариунзаяа, Г.Хонгорзул, З.Бадамцэцэг нарт талархал илэрхийлж байна.

Судалгааны хүрээнд судалгаа хийхэд бүх талын дэмжлэг үзүүлсэн Архангай аймгийн Ихтамир сум, Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Баянговь сум, Өмнөговь аймгийн Номгон сумын удирдлагуудад чин сэтгэлийн талархал илэрхийлье!

Хамгийн гол нь монголын бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэгэн чухал эх ундарга болсон ноолуур, ноолуурын үйлдвэрлэлийг тойрсон малчидын ахуй амьдрал, монгол нүүдлийн соёл, соёлын олон талт байдал, ёсзүйн асуудлыг тодруулах зорилго бүхий энэхүү судалгаанд маань өөрсдийн ахуй амьдрал, мал аж ахуй эрхлэх арга ухаан, амьдралын хэв маяг, ноолуурын үйлдвэрлэлийн эргэн тойронд өрнөж буй харилцаа, хамтын ажиллагааны талаар харамгүй сэтгэлээр тус хүргэсэн нутгийн иргэд, малчид, албан хаагчид, өндөр настан та бүхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна.

Товч тайлан

Ажлын зорилго

2022 онд Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгээс хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрүүд болох Нүүдлийн соёл иргэншилт Монгол хүний сэтгэлгээний онцлог, Нүүдэлчдийн идээ ундаа зоог хүртэх ёс заншил, Нүүдлийн соёл дахь хүндлэл, харилцааны урлаг, зан заншил, Нүүдлийн соёл иргэншилт улсуудын оюун санааны нэгдмэл үнэт зүйлс мөн Канадын Виннипэгийн Их сургууль, Нийгэм хүмүүнлэгийн судалгааны зөвлөлийн хамтын ажиллагааны хүрээнд “Тогтвортой” ноолуурын ёс зүйг тайлах нь төсөл, зэрэг сэдэвт төслүүдийн хүрээнд судлаачдын багийн гишүүд судалгааны материал цуглуулах, уулзалт ярилцлага хийх, дуу дүрс бичлэг хийж, монгол соёлын өв, нүүдлийн соёл иргэншил, тогтвортой ноолуур, зорилготой судалгааны ажил хийж гүйцэтгэнэ.

Судалгааны арга зүй

Үндсэн судалгааны арга нь чанарын судалгааны арга буюу антропологийн оролцон ажиглах (participant observation) арга зүй байна. Мөн судалгааны баг уг үндсэн арга зүйн хамт бусад судалгааны арга болох тухайлбал, бүтэцтэй болон бүтэцгүй ярилцлагын арга, баримт бичгийн судалгаа зэргийг судалгаандаа өргөн ашиглах болно.

Судалгааны тоног төхөөрөмж

Гэрэл зургийн багажууд, микрофон, таблет, зөөврийн компьютер, цахилгаан үүсгэвэр мотор, дуу хураагуур (5 ширхэг) зөөврийн хард (2) гэх мэт багажуудыг уг хээрийн судалгааны ажилд хэрэглэв.

Судалгааны санхүүжилт

Монгол Улсын Соёлын Яам, Канадын Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны Хороо

Судалгааны багийн бүрэлдэхүүнд

Канадын Виннипегийн Их сургууль (The University of Winnipeg)-ийн доктор Эрик Трифт, НСИСОУХ-ийн талаас Эрдэм шинжилгээ, хөтөлбөрийн зохицуулагч Г.Зулбаатар, Эрдэм шинжилгээ ажилтан С.Мижид, Мэдлэгийн төвийн ажилтан Б.Бумбаяр, Эрдэм шинжилгээний ажилтан Г.Содбаяр, Гадаад харилцаа, эрдэм шинжилгээний ажилтан С.Мөнх-очир, гэрээт судлаач М.Пагмадулам, Б.Ариунзаяа, Д.Наранбаатар Ц.Баяртогтох, З.Бадамсүрэн нар оролцов.

Хээрийн судалгааны нэгдүгээр ээлж

Архангай аймгийн Ихтамир сум, Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст суманд 2022 оны 07-р сарын 24-аас 08-р сарын 14 хүртэл нийт 22 хоногийн хугацаанд 2585 км замыг туулж ажиллав. Тус судалгаанд Mitsubishi L200 маркийн ХЭА-9045 улсын дугаартай авто машин, Nissan X-trial T-30 маркийн авто машинтай хоёр баг болон ажиллалаа. Ярилцлага авах малчин өрхийг сумын төвөөс алслагдсан орон зайг харгалзан, кластер түүврийн аргаар сонгов.

Судалгааны үр дүн

- Архангай аймгийн Ихтамир суманд 2022 оны 07-р сарын 24-өөс 2022 оны 07-р сарын 31 хооронд хоёр баг 7 хоногийн хугацаанд 28 өрхөөс ярилцлага авч, 1200 орчим минутыг аудио ярилцлага, 130 орчим хуудас бичвэр ярилцлагын эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэн ажиллав. Үүнээс аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ченж-1, сумын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулдаг ченж-1 тус тус хамруулан ярилцлага авав.
- Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст суманд 2022 оны 08-р сарын 01-ээс 2022 оны 08-р сарын 14 хүртэлх 15 хоногийн хугацаанд 32 өрхөөс ярилцлага авч, 1280 орчим минутын аудио эх хэрэглэгдэхүүн, 160 орчим

хуудас бичвэр эх хэрэглэгдэхүүн тус тус бүрдүүлэв. Мөн зураг, видеогоор судалгааны ажлын явцыг баримтжуулж ажиллав.

- Өмнөговь аймгийн Номгон суманд 2022 оны 9 сарын 19 ний өдрөөс 9 сарын 27-ны өдөр хүртэл 8 хоногийн хугацаанд хоёр машинтай судалгааны баг ажиллав. Улаанбаатар хотоос нэг машинтай явж, Өмнөговь аймгийн Номгон суманд очсон бөгөөд орон нутгаас нэг машин хөлсөлж, судалгааны хоёр баг болж хуваагдан ажиллав. Өмнөговь аймгийн Номгон сумын Дэрсэнэ-ус, Хармагтай, Төхөм зэрэг багийн 2022 оны 9 сарын 19-ний өдрөөс 9 сарын 27 өдөр хүртэл 08 хоногийн хугацаанд 20 өрхөөс ярилцлага авч, 700 гаруй минутын яриа, 100 орчим хуудас бичвэр хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн тус тус бүрдүүлэн ажиллав.

Хүснэгт 1. Судалгааны үр дүн

| № | Хээрийн судалгааны байршил | Ярилцлагын тоо | Туулсан км | Текстэд буулгаж Кодолсон бичвэр | Аудио эх хэрэглэгдэхүүн |
|------|--|----------------|------------|---------------------------------|--------------------------|
| 1 | Архангай аймгийн Ихтамир сум | 28 | 2585 км | 130 хуудас | 1200 орчим минутын аудио |
| 2 | Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст сум | 32 | | 160 хуудас | 1280 орчим минутын аудио |
| 3 | Өмнөговь аймгийн Номгон сум | 20 | 1740 км | 100 хуудас | 700 орчим минутын аудио |
| Нийт | | 80 | 4325 км | 390 хуудас | 3180 минут |

Хүснэгт 2. Судалгааны судалгаанд оролцогчдын тухай

| Архангай аймгийн Ихтамир сум | | | | |
|----------------------------------|-----------------------|--------------|-----|--|
| № | Судалгаанд оролцогчид | | Тоо | Харьяалал |
| 1 | Малчид | | 22 | Архангай аймгийн Борт, Бугат баг |
| 2 | Сумын ченж | | 1 | Архангай аймгийн Ихтамир сумын Тайхар баг |
| 3 | Аймгийн ченж | | 1 | Архангай аймгийн Эрдэнэбулган сумын уугуул |
| 4 | Хоршооны дарга | | 1 | Архангай аймгийн “малчин” зочид буудлын эзэн, Архангай аймагт уул уурхай түшиглэсэн малчдын хоршоо үүсгэн байгуулагч |
| 5 | Аймгийн ИХТ | | 1 | Архангай аймаг |
| 6 | Багийн дарга | | 2 | Борт, Бугат багийн дарга |
| Нийт | | | | 28 |
| Баянхонгор аймгийн Баянговь сум | | | | |
| № | Судалгаанд оролцогчид | | Тоо | Харьяалал |
| 1 | Малчид | Отрын | 1 | Өмнөговь аймгийн Гурвантэс сумын харьяат |
| | | Орон нутгийн | 1 | Баянхонгор аймгийн Баянлиг |
| | | | 9 | Баянхонгор аймгийн Баянговь |
| 4 | Хоршооны дарга | | 1 | Цагаан ямаат хоршооны дарга |
| 5 | Хоршооны гишүүн | | 4 | Цагаан ямаат хоршооны гишүүн |
| Нийт | | | | 16 |
| Баянхонгор аймгийн Шинэжинст сум | | | | |
| № | Судалгаанд оролцогчид | | Тоо | Харьяалал |
| 1 | Малчид | Отрын | 1 | Архангай аймгийн Булган сум |
| | | | 1 | Баянхонгор аймгийн Баян-өндөр сум |
| | | Орон нутгийн | 12 | Баянхонгор аймгийн Баянговь |

| | | | | |
|----------------------------------|--|--------------|-----|--|
| 4 | Хоршооны дарга | | 1 | Цармын цагаан сувд хоршооны дарга |
| 5 | Хоршооны гишүүн | | 1 | Цармын цагаан сувд хоршооны тэргүүлэгч |
| Нийт | | | | 16 |
| Баянхонгор аймгийн Шинэжинст сум | | | | |
| № | Судалгаанд оролцогчид | | Тоо | Харьяалал |
| 1 | Малчи | Отрын | 1 | Архангай аймгийн Булган сум |
| | д | | 1 | Баянхонгор аймгийн Баян-өндөр сум |
| 2 | | Орон нутгийн | 11 | Баянхонгор аймгийн Баянговь |
| 3 | Хоршооны дарга | | 1 | Лусын-сэрчим хоршооны дарга |
| 4 | Хоршооны гишүүн | | 3 | Лусын-сэрчим хоршооны гишүүн |
| 5 | Багийн дарга | | 1 | Номгон сумын Хармагтай багийн дарга |
| 6 | Засаг даргын орлогч | | 1 | Номгон сум |
| 7 | Мал аж ахуй асуудал эрхэлсэн мэргэжилтэн | | 1 | Номгон сум |
| Нийт | | | | 20 |
| Бүгд дүн | | | | 80 |

Канад-Монголын хамтарсан “Тогтвортой ноолуурын ёс зүйг тайлах нь” сэдэвт судалгааны ажлын хээрийн судалгааны үйл явцад Архангай аймгийн Ихтамир сум, Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст, Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгаагаар нийт 80 өрх айлаас ярилцлага авч, 3200 орчим минутын аудио эх хэрэглэгдэхүүн, 380 гаруй хуудас бичвэр ярилцлага, мөн видео, фото эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэн ажиллав.

380 орчим хуудас ярилцлагыг “Zotero” програмд байршуулж, ярилцлага тус бүрийг кодлох ажил хийв. Нийт 1200 орчим код хийсэн бөгөөд 50 сэдэвт багцлан ангилах ажил хийв.

Судалгааны ажлын үндэслэл

“Тогтвортой ноолуур” гэсэн нэр томъёо нь тогтвортой хөгжлийн шалгуурыг хангасан ноолуур буюу байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох гэсэн утгатай бөгөөд энэ нэр томъёог Монгол Улс төдийгүй олон улсын хэмжээнд өргөн хэрэглэдэг. Тухайлбал, Францын “AVSF - Agronomes et Vétérinaires Sans Frontières” мал эмнэлгийн байгууллага, Английн Тогтвортой ноос ноолуурын эвсэл, “Aid by Trade” буюу Худалдаа-тусламж сан зэрэг байгууллагын тус тус гаргасан стандарт, гэрчилгээг Монгол Улс, БНХАУ-д дэлгэрүүлсэн байна.¹ Эдгээр стандарт, гэрчилгээ нь эцсийн дүндээ Монголын малчид, үйлдвэрлэгчдэд ашигтай байж болох бөгөөд учир нь олон улсын хэрэглэгчид “хариуцлагатай худалдаа” гэсэн баталгаа олгосон бараа бүтээгдэхүүнийг авахдаа илүү үнэ төлөхөд бэлэн байдаг.² Гэтэл олон улсын

¹ Даваагийн Баасандорж et al., *Монголын ноос ноолуурын салбарын тогтвортой үйлдвэрлэлийн гарын авлага* (Улаанбаатар: Европын Холбооны Монголын текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко-тэмдэг төсөл, 2020), https://cdn.greensoft.mn/uploads/users/2708/files/A_2_1_4%20Sus%20production%20handbook%20MO%20print.pdf; Тогтвортой ноос ноолуурын эвсэл, *Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал* (SFA, 2022), https://sustainablefibre.mn/wp-content/uploads/2022/05/MN_C001-Animal-Husbandry-and-Cashmere-Fibre-Harvesting-Code-of-Practice-1.pdf; Aid by Trade Foundation, *The Good Cashmere Standard by AbTF*, Version 1.2, 2022, https://thegoodcashmerestandard.org/wp-content/uploads/2022/03/The-Good-Cashmere-Standard-by-AbTF_v1.2_EN.pdf.

² Tagbata Didier & Sirieix Lucie, “Measuring consumer’s willingness to pay for organic and Fair Trade products”, *International Journal of Consumer Studies* 32, no 5 (2008): 479–90; P.H. Howard & P. Allen, “Consumer willingness to pay for domestic „fair trade“: Evidence from the United States”, *Renewable Agriculture and Food Systems* 23, no 3 (2008): 235–42; Faruk Anil Konuk, “Consumers’ willingness to buy and willingness to pay for fair trade food: The influence of consciousness for fair consumption, environmental concern, trust and innovativeness.”, *Food research international (Ottawa, Ont.)* 120 (2019): 141–47, <https://doi.org/10.1016/j.foodres.2019.02.018>.

хэрэглэгчид бүтээгдэхүүн авахдаа үйлдвэрлэсэн тухайн нутгийн соёл, заншил, уламжлалт арга ухааныг дэмжих бас хүсэлтэй байдаг учир энэ хүрээнд “соёлын үнэ цэнэ” буюу “соёлын нэмүү өртөг” гэж ярих нь зүйтэй. Иймд Дэлхийн шударга худалдааны байгууллага (World Fair Trade Organization)-аас гаргасан стандартад тэмдэглэхдээ:

[Гишүүн байгууллага нь] соёлын ондоошил, орон нутгийн түүхий эд, ур чадвар зэргийн үнэ цэнийг хүндэтгэн үзнэ (бүтээгдэхүүнийг зохион бүтээх, сонгох, хаяглах явцад гэх мэт). Боломжтой бол орон нутгийн уламжлалт арга ухаан, түүхий эд, зүйлсийг аливаа бүтээгдэхүүний шинэ хэв загварт ашиглана эсвэл оруулна.³

Соёлын хэмжүүрийг тогтвортой бүтээгдэхүүний стандартад тусгах арга замыг хайх явдал нь Монгол Улсад соёлын өвийг хамгаалах хүчин чармайлтыг Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 12 – “Хариуцлагатай хэрэглээ, худалдаа”-тай хэрхэн уялдуулах талаар бид судалж байна. ТХЗ-ууд нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм гэсэн тогтвортой хөгжлийн гурван “тулгуур багана”-ыг агуулж байдаг боловч соёлыг дөрөв дэх гол тулгуур багана гэж тооцох хэрэгтэй юм.⁴

Энэ хүрээнд соёлын тогтвортой байдлын үзүүлэлтийг Соёлын яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисстой хамтран боловсруулсан Монгол Улсын Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт, Яаралтай хамгаалах өвийн жагсаалттай уялдуулах боломжийг судалж байна.⁵ Төрийн эдгээр баримт бичигт монголчууд өөрсдийн ахуй соёлд чухал ач холбогдолтой, ирээдүйд хамгаалахад

³ World Fair Trade Organization, “The WFTO Fair Trade Standard”, 2020, https://wfto.com/sites/default/files/WFTO_Standard_November%202020_print.pdf.

⁴ Jon Hawkes, *The Fourth Pillar of Sustainability: Culture’s Essential Role in Public Planning* (Common Ground, 2001); Katriina Soini & Joost Dessen, “Culture-Sustainability Relation: Towards a Conceptual Framework”, *Sustainability* 8, no 2 (Хоёрдугаар сар 2016): 167, <https://doi.org/10.3390/su8020167>; United Cities and Local Governments - Committee on culture, “Agenda 21 for culture” (Ajuntament de Barcelona, Institut de Cultura, 2008), https://agenda21culture.net/sites/default/files/files/documents/multi/ag21_en.pdf.

⁵ БСШУС-ын сайд, “Монгол Улсын Соёлын Биет Бус Өвийн Төлөөллийн Үндэсний Бүртгэл. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2019 Оны 11 Дүгээр Сарын 29-Ны Өдрийн А/759 Дугаар Тушаалын 1-р Хавсралт” (2019), <http://ncch.gov.mn>.

зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон зүйлсийн жагсаалтыг үндэсний хэмжээнд баталсан гэсэн үг юм. Тиймээс соёлын тогтвортой байдлын тухай ярихдаа тэдгээр өвөрмөц соёлын зүйлсийн эрч хүчийг Монголын нүүдэлчдийн соёлыг цаашид хадгалж үлдэх чадварын үзүүлэлт гэж ойлгох нь зүйтэй юм. Хувийн хэвшлийн үйлдвэрлэгчид, худалдаачдад зориулсан соёлын тогтвортой байдлын стандартыг боловсруулах нь мөн эдгээр жагсаалтаас орон нутгийн соёлын зүйлсийг хамгаалах, сурталчлах тодорхой арга хэмжээг дэмжих нэг хэрэгсэл байж болно. Ойрын хугацаанд “нүүдэлчдийн зан үйл, мал маллах арга ухаан” гэсэн зүйлийг ЮНЕСКО-д бүртгүүлэх зорилгоор Монгол Улс ажиллаж байна. Тэгвэл энэ хүрээнд, ноолуурын жишээн дээр, нүүдэлчдийн зан үйл болон монголын уламжлалт мал маллах арга ухаан гэж яг юуг хэлэх вэ? Бид ямаа маллахтай шууд холбоотой олон төрлийн дадлыг дурдаж болно. Жишээлбэл, чих имнэх, хонь ямааны бэлчээрийн ургамлыг таньж тодорхойлох, мал бэлчээрлэх тохиромжтой газар нутгийг сонгох, ямаа самнах, ямаа сонгон үржүүлэх, төл авах, нүүдэл хийх, отроор явах, ямаа саах, ямааны сүүг төрөл бүрийн цагаан идээ болгон боловсруулах, ган зудтай тэмцэх арга хэмжээ авах, малын нэмэлт тэжээл, ханд бэлтгэх, уламжлалт аргаар малын өвчнийг эмчлэх, янз бүрийн авиа дуудлагаар малтай харилцах гэх мэт олон жишээг хэлж болно.⁶

Монголд нүүдлийн мал аж ахуй, мал маллах арга ухаан, тэр дотор ялангуяа тогтвортой ноолууртай холбоотой хэд хэдэн стандарт байдаг. Үүнд, “Текстилийн тогтвортой үйлдвэрлэл” (MNS 692: 2021); AVSF-аас байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай мал аж ахуйг тодорхойлсон 25 шаардлагад тулгуурласан удирдамж, малчдын ажлын дэвтэр, гарын авлага, “Тогтвортой ноолуур”-ын гэрчилгээ; малын эрүүл мэндийн зохицуулалт хөтөлбөр, бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөөтэй байхыг шаарддаг. Тогтвортой ноос, ноолуурын эвслийн гэрчилгээ бас байдаг.⁷ Харин зах зээлд суурилсан иймэрхүү стандарт, баталгаажуулалтын арга хэмжээний томоохон шүүмжлэл нь бол “тогтвортой

⁶ М. Даш, *Монгол орны билчээрийн мал маллагааны арга туршлага* (УБ: УХХЭХ, 1966).

⁷ Стандарт, хэмжил зүйн газар, “Текстилийн тогтвортой үйлдвэрлэл – Удирдамж”, 2021, <https://old.estandart.gov.mn/standart/v/6778>; Тогтвортой ноос ноолуурын эвсэл, *Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал*.

байдал” гэсэн тодорхойлолтыг орон нутгийн гэхээсээ илүүтэйгээр гаднаас нь тусгах хандлагатай байдаг.⁸ Бидний жагсаасан бичиг баримтын аль нь ч соёлын тодорхой үзүүлэлтийг агуулдаггүй, түүнчлэн тогтвортой байдлын стандартууд нь зарим талаараа монголчуудын уламжлалт нүүдлийн зан үйл, мал маллах арга ухаан нь хоцрогдсон тул гадны дэмжлэгээр өөрчлөх шаардлагатай гэсэн сөрөг үзлийг бодитоор бий болгох талтай. Тухайлбал, гадаадын зарим брэндүүд ямаанаас эхлээд эцсийн үйлдвэрлэл хүртэл ноолуур бэлтгэх явцад хэдий хэмжээний ус, ургамал, түлш болон бусад нөөцийг зарцуулж байгааг тооцоолж, байгаль орчны хяналт, тооцооны үнэлгээ гаргана. Хэрэв нөөц ашиглалтын тэнцэл тодорхой босго хэмжээнээс доогуур байвал бүтээгдэхүүнийг тогтвортой хэмээн үзэж болно.

Хувцас загварын брэнд Стелла Маккартни “Байгаль орчны ашиг, алдагдал”-ын үнэлгээнд үндэслэн 2016 онд Монголын ноолуурын үйлдвэрлэл нь өөрийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд ноолуурын хэрэглээг нийт материалын хэрэглээний дөнгөж 0,1%-ийг эзэлдэг мөртөө байгаль орчинд үзүүлж буй нийт нөлөөллийн 28 хувийг бүрдүүлдэг тул тогтворгүй буюу байгаль орчинд халтай гэж дүгнэсэн.⁹ Тиймээс тус компани дахин боловсруулсан ноолуурыг өөрийн үйлдвэрлэлдээ ашиглах чиглэл рүү шилжиж, Монголын зах зээлээс бүрэн татгалзсан. Бусад зарим аж ахуйн нэгж, байгууллагуудаас ямааны тоо толгой хэт олширсноос бэлчээрийн доройтол, цөлжилт бий болсон тул шинэ ноолуур худалдан авахаа бүрмөсөн зогсоохыг хэрэглэгчдэд уриалсан.¹⁰ Стелла Маккартни өөрийн цахим хуудаснаа Монголын бэлчээрийн 70% нь доройтож, цөлжиж байгаа нь хямд ноолууртай зах

⁸ Josh Fisher, “In Search of Dignified Work: Gender and the Work Ethic in the Crucible of Fair Trade Production”, *American Ethnologist* 45, no 1 (2018): 74–86,

<https://doi.org/10.1111/amet.12600>; Lindsay Naylor, *Fair Trade Rebels: Coffee Production and Struggles for Autonomy in Chiapas* (U of Minnesota Press, 2019); Mark Moberg, “Fair Trade and Social Justice: Global Ethnographies”, in *Fair Trade and Social Justice* (New York University Press, 2010), <https://doi.org/10.18574/nyu/9780814796207.001.0001>.

⁹ Stella McCartney, “Recycled cashmere | Stella McCartney US”, Stella McCartney, 2022, <https://www.stellamccartney.com/us/en/sustainability/recycled-cashmere.html>.

¹⁰ Matthew Dalton, “From H&M to Gucci, Fashion Rethinks Cashmere, Citing Environmental Harm”, *The Wall Street Journal*, 13 Тавдугаар сар 2019, sec Business, <https://www.wsj.com/articles/fashion-companies-rethink-cashmere-11557749119>.

зээлийн нөхцөл, малчид өөрсдөө бэлчээрийн даац хэтрүүлсэнтэй холбоотой гэж бичжээ.¹¹ Энэ төрлийн тогтвортой байдлын үнэлгээ нь орчин үеийн нөхцөлд уламжлалт нүүдлийн мал аж ахуй өөрөө тогтворгүй болсон, уламжлалт мал маллах арга ухаан хангалтгүй болсон бөгөөд малчид байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтвортой түвшинд хүргэхийн тулд мал аж ахуйн шинэ арга ухаанд шилжих ёстойг илтгэж байгаа тул Монголын малчдын хувьд хүндрэлтэй байж болох юм.

Эдгээр хандлагын эсрэг бид нүүдлийн мал аж ахуйн уламжлалт арга ухааныг орчин үеийн нөхцөлтэй нийцэхгүй гэж үзэхийн оронд өнөөгийн зах зээлийн нөхцөл байдал, улс төрийн нөхцөл байдал нь малчдын уламжлалт арга ухаанд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхлэх чадварыг хангаж байгаа эсэхийг дүгнэх нь илүү тустай гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, уламжлалт нүүдлийн мал аж ахуйг экологи, эдийн засгийн хувьд угаасаа тогтвортой буюу ээлтэй, гэхдээ энэ үйлдвэрлэлийн тогтолцооны тогтвортой байдалд малчдын өөрсдийнх нь шууд хяналтаас гадуур гаднын хүчин зүйлс заналхийлж болзошгүй. Зарим малчид бидэнтэй ярилцахдаа, тухайлбал, уул уурхайгаас үүдэн бэлчээр, ус бохирдож, доройтож байгааг хэлж байсан. Эсвэл эрэлттэй тохиромжтой бэлчээр, сумын төвийн ойролцоо, зам дагуу, худаг усны ойролцоо зэрэг газруудад малчдын нягтаршил ихтэй, тэр дундаа бусад нутгаас ирсэн отроор явж буй айл өрхүүд орсон тул нүүх боломж хязгаарлагдмал гэж зарим малчид тайлбарлаж байна. Эдгээр нь нүүдлийн мал аж ахуйг шинэ, илүү эрчимтэй хэлбэрт шилжих замаар шийдвэрлэх техникийн асуудлаас илүү үндсэндээ улс төр, засаглалын асуудал юм.

Тогтвортой байдлын гэрчилгээ олгох дахиад нэг арга нь Өвөрмонголд хэрэглэгдэж буй Сайн ноолуурын стандарт, AVFS Тогтвортой ноолуурын стандарт, Тогтвортой ноос, ноолуурын эвслийн үйл ажиллагааны дүрэм зэрэг баримт бичигт тусгагдсан болно. Эдгээр стандартууд нь ЮНЕСКО-д бүртгүүлэхийг хүсэж буй нүүдэлчдийн зан үйл, мал маллах арга ухаантай заримдаа нийцэх, заримдаа эс нийцэх нарийн, техникийн үзүүлэлтийг ашиглана. Жишээлбэл, “Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх зохистой дадал” стандартад бид уламжлалт мал маллагааны зарим арга ухааныг кодчилсныг харж болно, үүнд: усны тэвшийг цэвэр байлгах; бохирдсон эсвэл муудсан тэжээлийг зайлуулах; малын

¹¹ Stella McCartney, “Recycled cashmere | Stella McCartney US”.

хашааг мод гэх мэт цэвэр байгалийн материалаар бүтээх; ямааг хяргах биш самнаж ноолуурыг нь авах; өнчин болон гологдсон төлийг зохицуулах арга барилтай байх; мөн ямааг бүрэн тэжээлээр биш бэлчээрт гаргах ёстой гэж байна.¹² Малчдын нүүдэллэх аргын тухайд “ургамлын төрөл, нарны туяа, салхины хурд, цасны хэмжээ” зэргийг харгалзан буух газраа сонгохыг заасан. Энэ утгаараа Монголын нүүдлийн мал аж ахуйг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд тогтвортой, ээлтэй аж ахуйн үйлдвэрлэлийн хууль ёсны хэлбэр мөн гэдгийг уг стандартад эергээр хүлээн зөвшөөрсөн байна.

Үүний зэрэгцээ, Тогтвортой ноос, ноолуурын эвслийн зохистой дүрэм болон AVSF-н Тогтвортой ноолуур стандарт нь бэлчээрийн ашиглалтыг байгалийн нөөц болон зэрлэг ан амьтдын үнэлгээ, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, хяналт-үнэлгээний судалгаа зэрэг бичиг баримтыг бүрдүүлэн, бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) зэрэг малчдын сайн дурын байгууллагаар зохицуулахыг шаардаж, монголчуудын нүүдэллэх ёсыг албан ёсны зохион байгуулалттай хэлбэрт оруулахыг мөрдлөг болгож байна. Өөрөөр хэлбэл, малчдын нутаг бэлчээр сонгох түгээмэл арга болох зар түгээх, сураг сонсох, газар үзэх, тухайн нутгийн малчидтай аман зохицуулалт хийхийг “цэгцгүй зохицуулалт” гэж үзээд, тодорхой нутаг дэвсгэр дэх өрхүүдийн дунд албан ёсоор бүлэг үүсгэж зохицуулах, баримт бичиг бүрдүүлснээр ямар ч гадна дотнын хүнд ил тод, ойлгомжтой хэлбэрт оруулах төлөвтэй байна.

Эдгээр зохицуулалтын шинэ арга туршлага нь уян хатан байдал, тодорхойгүй нөхцөлд дасан зохицох чадвараас илүү мал маллах нөхцөл байдлыг өөрсдөө тогтворжуулах чадварыг чухалд үздэг. Энэхүү үзэл нь нүүдэлчдийн сэтгэлгээнд ихээхэн өөрчлөлт оруулах хандлагатай байгааг бидний хээрийн судалгаа харуулсан. Бидний зүгээс нүүдэлчдийн сэтгэлгээг тодорхойгүй нөхцөлд дасан зохицож, хариу үйлдэл үзүүлэх арга ухаан хэмээн тодорхойлж болмоор байна. Нэгт, эдгээр стандартад шаардагдах менежментийн төлөвлөгөө нь отор гэх мэт хариу арга хэмжээ авахаас илүү бэлчээрийн тогтмол сэлгээ нүүдэлд давуу эрх олгодог. БАХ-ын удирдагчид сэлгээ нүүдлийг “хэвийн”, отор нүүдлийг “онцгой байдлын” хөдөлгөөн гэж тодорхойлсон бөгөөд ингэж ялгаж үзэхэд отроор явах шаардлага нь ямар нэг хэвийн бус байдлын шинж тэмдэг гэсэн тайлбар илэрхийлж байна,

¹² Тогтвортой ноос ноолуурын эвсэл, *Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал*.

тухайлбал магадгүй бэлчээрийн даац хэтэрсний улмаас бэлчээрийн доройтол, эсвэл уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ган гачиг үүссэн тул хэвийн бус нүүдэл хийнэ гэж үзэж байх юм. Цаашилбал энэхүү зарчмаар отор нүүдлийг шаардлагагүй болгохын тулд малын үүлдэр угсааг сайжруулан мал аж ахуйг эрчимжүүлэх, сүргийн бүтцийг өөрчлөх, малын тоог цөөрүүлэх, хадлан тэжээл бэлдэхэд хөрөнгө оруулалт хийх ёстой зүйл гэж үзнэ. Харин түүний эсрэгээр, монгол нүүдлийн зан үйлийн томоохон хэлбэр болох отор нүүдлийг чухалд үзвэл, төр засаг болон албан ёсны бусад зориулалтын арга хэлбэрт отор хийх нөхцөлийг сайжруулж, отор хийх малчдыг илүү дэмжих, зохицуулах шаардлагатай. Хоёрт, эдгээр бэлчээр, малын зохицуулалтууд нь тодорхой нэг газар нутгийн мал сүрэг, өрх, айлын бүрэлдэхүүн нь ерөнхийдөө тогтвортой байна гэсэн ойлголт агуулсан боловч үнэндээ, нэг хот айл, нэг өрхийн бүрэлдэхүүн жилийн жилд тогтмол өөрчлөгддөгийг анзаарч болно. Хангай нутгийн харьцангуй суурьшмал малчдын гэр бүлд ч хүүхдүүд сумын төвд хичээлдээ явах өвөл, хавар, зуны амралтаараа буцаж ирэх, бага насны ач зээ нараа өвөө эмээ дээр аваачих, өндөр настан, өвчтэй хүн хөдөө очих зэргээр өрх айлын бүрэлдэхүүнд байнга өөрчлөлт орж байдаг. Аль эсвэл хүүхдүүдээ гэрлэхэд, ахмад хүн нас барсны дараа өрх тасална, нэгдэнэ. Мөн тухайн цаг үеийн хэрэгцээнээсээ хамааран зуслан, өвөлжөөнд өөр өөр өрх айл болж бууна, тухайлбал мал сүрэг өссөн үед туслах малчин, нэмэлт тусламж авчрах шаардлагатай, харин ган зудтай жилд сүргээ хувааж холын оторт тус тусдаа явах шаардлагатай, эсвэл үр хүүхдээ гэр бүл болоход сүрэг тасалж өгсөн, олон мал борлуулах хэрэг гарсан бусад үед олон хүн мал дээр байх шаардлагагүй учир малаа цөөнөөр, эсвэл ээлжилж хариулах жишээтэй. Эдгээр уян хатан зохицуулалтыг Монголын нүүдэлчдийн соёлд шингэсэн нүүдэлчдийн харилцах ёс болон төрөл төрөгсөд (ах дүү) хоорондын харилцан туслалцах байдлыг агуулсан эдийн засгийн харилцааг илэрхийлж байна. Үүнээс үзэхэд малчин өрх нь бие даасан эдийн засгийн нэгж биш, харин нутаг, төрөл садны өргөн сүлжээний нэг хэсэг юм.

Бид соёлын үүднээс тогтвортой бүтээгдэхүүнийг тодорхойлохдоо соёлын олон төрлийн үйл ажиллагааг дэмжсэн бүтээгдэхүүн гэж үзмээр байна. Гадаадын олон харилцагчид монголын малчдыг зүгээр л “ноолуур нийлүүлэгч” гэж төсөөлдөг, өөрөөр хэлбэл малчид ноолуураас орлого олохын тулд ямаа өсгөх зэрэг эдийн засгийн мэргэшсэн үүргээс цаашгүй хэмээн үздэг. Гэвч үнэн хэрэгтээ ямаа нь

нүүдэлчдийн зан үйлийн олон талт тогтолцооны нэг чухал хэсэг болдог. Нүүдлийн соёлын амьд байдал нь малчид зөвхөн ямаа үйлдвэрлэгч биш, харин цагаан идээ үйлдвэрлэгч, айраг үйлдвэрлэгч, эсгий үйлдвэрлэгч, байгалийн баялаг хураагч, уул, ус, овооны харуул, уяачид гэх мэт олон ажил үүрэгтэй, өргөн мэдлэг, арга ухаантай байдгаас шалтгаална. Тиймээс ноолуур зэрэг бүтээгдэхүүний эдийн засгийн үнэ цэнэ нь зөвхөн бодит чанар, тухайлбал, эслэгийн микрон чанараас хамаарахгүй, харин тухайн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгчдэдээ буюу нүүдлийн малчиддаа соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалахад хэр сайн тусалж байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, Монголын биет бус соёлын өвийн жагсаалтаас бид нүүдлийн мал аж ахуйгүйгээр оршин тогтнох боломжгүй маш олон чухал үнэт зүйлсийг бас харж байна.¹³ Үүнд, хурдан морины хүүхдийн гийнгоо, шинэ гэр барих зан үйл, мал хөнгөлөх зан үйл, гүүний үрс гаргах зан үйл, унага тавих зан үйл, адуу тамгалах зан үйл, мал сэтэрлэх зан үйл, айраг сархдын холбогдолтой зан үйл, шагай харвах зан үйл, шагайгаар наадах зан үйл, монгол нүүдлийн зан үйл, тэмээн поло, тэмээн уралдаан, мал аж ахуйн ач холбогдолтой уриа дуудлага гэх мэт. Иймд, дэлхийн соёл иргэншил, нүүдлийн мал аж ахуйн соёлд ноолуурын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, түүнийг тайлан тайларлах шаардлага байна.

¹³ БСШУС-ын сайд, Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалын 1-р хавсралт.

Нэгдүгээр бүлэг: Цагаан Алт

Удиртгал: Цагаан Алт

Монголчууд газар тариалан эрхлэхэд тохиромж муутайхан байгаль, цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицсон мал аж ахуйг эрхлэн, адуу, үхэр, сарлаг, хонь, ямаа, тэмээ, цаа буга зэргийн сүү, махыг хот, хөдөөгийн аль ч нөхцөлд амьдрал ахуйдаа өргөн ашиглаж байна. Сүүлийн үеийн судалгаагаар энэхүү бүс нутагт МЭӨ 3000-аад оны үед сүү, цагаан идээ хэрэглэж байсан тухай хамгийн эртний нотолгоог эртний хүний шүдний чулуужсан уургаас олсон байна.¹⁴ Өнө эртний уламжлалтай мал аж ахуйн түүхий эдээс энэ цаг үед оч болон гялалзаж, дэлхийн сонорт хүрсэн бүтээгдэхүүн бол ноолуур юм.

Монголын тэгш өндөрлөгт үйлдвэрлэж буй ноолуур нь ямар хэмжээний бүтээмж буй болгож буй тухай олон талын судалгаа бий. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээгээр 2019 онд 32,26 сая хонь, 29,26 сая ямаа, 472.38 мянган тэмээ, 4,75 сая үхэр (үүнд 877.7 мянган сарлаг), 4,21 сая адуу, нийтдээ 70,96 сая мал тоологдсон ба ямаан сүргийн тоо толгой өмнөх оноос 2136.96 мянган толгойгоор өссөн байна.

Дэлхийн хэмжээний ноолуурын нөөцийн 40 хувийг Монгол, 48 хувийг Хятад, 12 хувийг Иран, Афганистан зэрэг улсууд бэлтгэдэг. Ноолууран ширхэгт нь байгалиас нано бүтэцтэй учраас дээд зэргийн зөөлөн, хөнгөн, дулаан, уян хатан, бөх бат, амьсгалдаг, агаар шүүдэг, галд тэсвэртэй, байгальд задардаг зэрэг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй үзүүлэлтээрээ ноолууран бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн түвшний дундаас дээш болон тансаг хэрэглээний бүлгийнхний хэрэгцээг бүтээгдэхүүн болж, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд эрэлттэй хэвээр байна.

¹⁴ Shevan Wilkin et al., “Dairy Pastoralism Sustained Eastern Eurasian Steppe Populations for 5,000 Years”, *Nature Ecology & Evolution* 4, no 3 (Гуравдугаар сар 2020): 346–55, <https://doi.org/10.1038/s41559-020-1120-y>.




Зураг 1. Ноолууран бүтээгдэхүүний үнэ цэнэ, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Аж үйлдвэрийн салбар 2019 он

2019 оны байдлаар ноолууран бүтээгдэхүүн 481,6 \$ долларын үр ашиг бүтээжээ. Ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулж, угаасан ноолуурыг Хятад, самнасан ноолуурыг Хятад, Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолж байна. Энэ салбарт МУ-ын 230 орчим мянган малчид хөдөлмөрлөж, үр ашиг шууд хүртэж байна. Энэ утгаараа ноолуур бол МУ-ын мал аж ахуйн бүтээгдэхүүнээс олон улсад үнэлэгдсэн тансаг зэрэглэлийн брэнд бүтээгдэхүүн юм. Мөн дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд бодит хувь нэмэр оруулж чадах салбар хэмээн үзэж болмоор байна. Бид энэ хэсэгт ноолуурын малчдын ахуй амьдрал ямар үр ашиг, мал аж ахуйн соёлд хэрхэн хувь нэмэр оруулдаг тухай онцлон авч үзэхийг хичээв.

Урьдаар тус судалгааны ажлын хүрээнд цуглуулсан эх хэрэглэгдэхүүнийг танилцуулъя. Бид Монгол улсын Хангай, Говийн бүсийн 4 сумын 81 ноолуур үйлдвэрлэгч өрх, ноолуурын үйлдвэрлэлд оролцогч талуудыг хамарсан санамсаргүй түүврийн аргаар мэдээлэл цуглуулсан юм. Үүнд, 61 малчин өрхийн төлөөлөл, Аймгийн түвшинд бодлого тодорхойлогч нэг, Ноолуурын ченж (аймаг, сум) төлөөлөл хоёр, Ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршооны

дарга дөрөв, Хоршооны гишүүн тав буюу нийт 81 төлөөлөлтэй уулзан судалгааны эх хэрэглэгдэхүүн бүрдүүлж ажиллаа. Дээрх судалгаанд хамрагдсан нийгмийн төлөөллийг ажиглахад судалгааны зорилгоо хангасан үзүүлэлт болсон хэмээн үзэж байна.



Зураг 2. Судалгаанд оролцогчид нийгмийн бүлгээр

Иймд, Бид Монгол улсын хангай, говь, хээрийн бүсэд мал маллан аж төрж буй малчидтай уулзан ярилцах “дундардаг шар алтнаас ундардаг цагаан алт илүү дээр” хэмээн олзуурхан ярьж байна. Иймд, бид энэхүү хэсэгт тусгайлан малчдын ахуй амьдрал, мал аж ахуйн соёлд үзүүлж буй ноолуурын үнэ цэнийг тодруулахыг хичээв. Судлаачид ихэнх тохиолдолд “ноолуур” хэмээх түүхий эдийн эдийн засгийн үнэ цэнийг чухалчилж байна. Харин бид ноолуурын соёлын үнэ нь алтнаас дутуугүй болох тухай, зарим талаараа хавь илүү болох тухай дараах гувван бүлэг сэдвийн хүрээнд ярилцана. Нэгт, Малчдын бүтээмж ба ноолуурын орлого. Хоёрт, Ноолуурын салбар дахь ченж нар, тэдний үзэл баримтлал. Гуравт, Ноолуурын үйлдвэрлэл ба малчдын ноолууран бүтээгдэхүүний хэрэглээ. Дээрх гурван сэдвийн хүрээнд бид “ноолуур” хэмээх бүтээгдэхүүний соёлын үнэ цэнийг тодруулахыг хичээнэ. Дээрх гурван асуудлыг багцлан бид Монгол тэгш өндөрлөгт “цагаан алт” хэрхэн буй болж, нийгэм, соёлын ямар ямар үр ашиг буй болж байгааг тайлбарлах болно.

Малчны бүтээмж, зохион байгуулалт

Малчдын тухай

Монголын малчдын ахуй амьдралын түвшин, өрх, хот айлын бүтэц, хэмжээ, үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалт, нүүдэл суурьшлын онцлогийн талаар зориуд хийсэн судалгаа шинжилгээний бүтээл цөөнгүй байна. Мөн Монголоор аялсан жуулчид, эрдэмтдийн тэмдэглэл үнэтэй эх хэрэглэгдэхүүн болж байна. Судалгаа бүр судалж байсан нийгэм-эдийн засгийн байгуулал, улс орны болон өрхийн амьдралд үзүүлж байсан гадаад дотоодын хүчин зүйлийн нөлөөг харгалзан өрхийн амьдралын түвшин, мал хөрөнгийн бүтэц, орлого, зарлагын судалгааг өөр, өөр арга хэлбэрээр хийж, янз бүрийн үзүүлэлтээр тодорхойлсон байдаг. 1919 онд Оросын эрдэмтэн И. М. Майский таван хүний бүрэлдэхүүнтэй экспедицийг ахлан 16 сар судалгаа хийхдээ Монголын албан ёсны байгууллага, сүм хийд хошууны удирдлага, малчид, Орос Хятадын худалдаачид, Монголд байсан Оросын консулын газар зэргээс янз бүрийн мэдээ материал цуглуулан боловсруулж, тэр үеийн дундаж нэг өрхийн хүн ам, мал, хөрөнгийн бүтэц, жилийн орлого, зарлага, хэрэглээ, хүнсний хэрэглээний бүтэц, хангамж зэргийг тодорхойлсон байна.¹⁵ А. Симуков 1933 онд Архангай аймгийн Ихтамир, Өмнөговь аймгийн Хонгор-овоо, Ноён сумуудад явуулсан ажиглалтын материалын үндсэн дээр “хотоны” гэсэн өгүүлэл бичсэн нь социализмын өмнөх үеийн малчдын ахуй байдлыг тодорхойлж болох ач холбогдол өндөртэй судалгааны өгүүлэл болжээ.¹⁶ Тэрээр малчин өрхийн зохион байгуулалт нь өрхүүдийн малын тооноос хамааран мал ихтэй, чинээлэг малчид нь ядуу малчдынхнаа хөдөлмөрийг хэрхэн завшдаг тухай өгүүлсэн байна. Эрдэмтэн, судлаач А. Симуков хот айлын эдийн засаг, хөрөнгө, санхүү, амьжиргаанд гол анхаарал хандуулсан тул хот айлын бүтцэд нөлөөлж буй нийгмийн тогтолцооноос хамааралтай өөрчлөлтийг орхигдуулжээ.

¹⁵ ИМ Майский, “современная монголия” (Иркутск, 1921).

¹⁶ А Симуков, “Хотоны”, “Современная Монголия”, по 3 (1933).

1930-1950-иад оны үед Оросын судлаачид С. Азаров, Н. Болодон, Н. Денисов, В. Масленников, И. Шульженко, А. Мелешко, В. Грайворонский нар Монголын малчдын тухай судалгаа хийж, нийгэм-эдийн засаг мал маллах арга ажиллагааны цөм нь хот айл хэмээх дүгнэлтийг гаргасан байна.¹⁷

1950-аад оны үед Зөвлөлт холбоот улсын (хуучнаар) шинжлэх ухааны Академийн хөдөө аж ахуйн экспедицийн бүрэлдэхүүнд Монголын эрдэмтэн, эдийн засагч Н. Жагравал оролцон Монгол орны аймаг, сумуудаар явж, тэр үеийн мал аж ахуйн зохион байгуулалт, ажиллах хүчний хангамж, малын хашаа байр, мал сүргийн бүтэц, малчдын ажил хөдөлмөрийн байдал, өрх хот айлын хөдөлмөрийн зарцуулалт, зохион байгуулалтанд үнэлэлт, дүгнэлт өгсөн судалгаа хийсэн нь Монголчуудын оролцсон системтэйгээр мал аж ахуй, малчдыг судалсан анхны судалгаа болсон байна.¹⁸ Малчдын мал хөрөнгийг харгалзан ядуу, дунд, том аж ахуйтан гэсэн үндсэн 3 хэсэгт ангилан тус бүрд нь мал, мах, сүү, ноос, газар тариалангийн бүтээгдэхүүн болон мөнгөн орлого зарлагын тооцоог гаргаж ирсэн байна. Эдийн засгийн ашиг орлого, зарлагад гол анхаарал хандуулан судалсан бөгөөд малчдын хөдөлмөрийн оролцоо, цагийн хуваарилалтыг судлан үзээгүй байна.

1978 онд эрдэмтэн Д. Гонгор “Халх товчоон” хэмээх бүтээлийнхээ нэгдүгээр анги, хоёрдугаар бүлэг буюу нийгмийн бүтэц, өрх гэр гэрлэлт бүлэгтээ “хот (котон)”, гуравдугаар анги, нэгдүгээр бүлэгтээ “хот айл бол газар эдэлбэрлэх үндсэн нэгж мөн” хэмээх хоёр өгүүлэл бичсэн байна.¹⁹ Энэхүү өгүүлэлд XI-XVII зууны үеийн малчдын тухай үзэл ойлголт, хэв шинжийг чухалчлан үзсэн байна.

Малчдын хөдөлмөр зохион байгуулалт, шинж чанарын тухайд 1951-1952 онд С. Жадамба Архангай аймгийн Чулуут сумын “шинэ амьдрал” нэгдэлд нэг жил

¹⁷ С Азаров, “животноводческая техника кочевого хозяйства”, *“Современная Монголия”*, 1933, 2; И.Б Болодон, “К вопросу о хотонах”, *“Современная Монголия”*, no 2 (1938): 27; Н Денисов, *Животноводство МНР* (Уб, 1946); В. Масленников, *Монгольская Народная Республика на пути к социализму* (М, 1951); И Шульженко, *Животноводство Монгольской народной Республики* (Москва, 1953); А Мелешко, “Вопросы кочевничества”, *Журн соврем монг*, 1935; В Грайворонский, *От кочевого образа жизни к оседлости*, М, 1979.

¹⁸ Н Жагравал, *Аратство и аратское хозяйство* (Уб, 1974).

¹⁹ Д Гонгор, *Халх товчоон* (= *Краткая история Халхи*) (Улаанбаатар, 1978).

суурин судалгаа хийхдээ өрхийн доторх хөдөлмөрийн зарцуулалтыг ажил багатай өвлийн улиралд, ажил ихтэй хаврын улиралд тус бүр 10 айл дээр ажлын зураг авалтаар гүйцэтгэсэн нь судалгааны шинэлэг арга хэрэглэсэн судалгаа болсон байна. Энэхүү судалгаагаар өрхийн гишүүдийн өдөрт ажиллах дундаж цагийг 55 тооцож гаргасан байна. Тухайлбал “эрэгтэйчүүд хоногт 8-9 цагийн ажил хийж, 5-5,5 цагийг үргүй зардаг. Эмэгтэйчүүд хоногт 11-11,5 цаг ажиллаж, 3-3,5 цагийг үр ашиггүй зардаг. Хүүхдүүд дунджаар 4 цаг 30 минутаас 9 цаг 30 минут ажил хийж, 5 цаг 30 минутаас 9 цаг “үргүй” (бодит бүтээмжгүй) зардаг” хэмээн үзсэн байна.

1983 онд эрдэмтэн Л. Бат-Очир “Хот айлын тухай зарим асуудал” сэдэвт өгүүлэл хэвлүүлсэн байна. Энэхүү өгүүллийг эрдэмтэн Л. Бат-Очир малчдын хөдөлмөр зохион байгуулалтын үндсэн нэгж “хот айл”-ын зохион байгуулалт юм хэмээн үзжээ. Тэрээр 1921 оны ардын хувьсгалаас хойших үеийн хот айлын бүтэц, нийгэм-эдийн засгийн шинж чанар, түүнд гарсан өөрчлөлттэй холбоотой зарим асуудлыг авч үзэхийг урьтал болгосон байна. Энэхүү өгүүлэл хот айлын өөрчлөлт ба бүтцийн үндсэн цөм нь эдийн засаг, хөрөнгө гэж тодорхойлоод нийгмээс нөлөөлж буй хүчин зүйлийг орхигдуулсан байна.

1996 онд Б. Болд Монголын нийгэм-эдийн засгийн хуваарилалт, хот айлын мал маллагаа өгүүлэлдээ “хот-айл гарч ирсэн хугацаа нь 19-р зууны дунд үе” хэмээн үзээд “хот айл”-ын хөгжлийг XVIII-XX зуун, 1921-1960 он, 1960-1990, 1991 хойш хэмээн он цаг хугацаанд дахь хувьсал өөрчлөлтийг авч үзсэн байна.²⁰ Хот айлын бүтэц зохион байгуулалт социализмын үед суурь, суурь айл хэмээх нэр томъёогоор нэрлэгдэх болж бүтэц мөн чанар, агуулгын хувьд эрс өөрчлөгдсөн бөгөөд социализмын дараа хот айл дахин сэргэн гарч ирж мал аж ахуйд чухал ач холбогдолтой болж байна гэж үзжээ. Энэхүү өгүүлэлд хот айлын нийгэм-эдийн засгийн байдал, ураг төрөл зэргийг чухалчилж үзсэн болж хот айлын бүтцийн өөрчлөлт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж гаргаагүй байна.

Г. Цэрэнханд Монголчуудын угсаа-соёл, зан заншил /2005/ хэмээх бүтээлдээ хот айл, нутагшил, хот (хот айл), түүний хувьсал хэмээх өгүүлэл бичжээ. Эрдэмтэн Г. Цэрэнханд тус оронд хувийн аж ахуйтан зонхилж байсан үед хот айлын тухай

²⁰ Bat-Ochir Bold, “Socio-economic segmentation — „Khot-Ail“ in nomadic livestock keeping of Mongolia”, *Nomadic Peoples*, no 39 (1996): 69–86, <https://www.jstor.org/stable/43123494>.

ойлголт ямар агуулгыг илтгэн байгаад хөдөө аж ахуйд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсны дараа түүнд ямар хувьсал гарч, агуулгын хувьд хэрхэн өөрчлөгдсөнийг угсаатны зүйн судлалын үүднээс өгүүлсэн байна. Хот айлаар нүүдэллэн аж төрж байсан малчид бригад, суурь, тасаг, өргөн айлсалтын хэлбэрт шилжиж хөдөлмөрийн зохион байгуулалтын талаар нэлээд өөрчлөгдөж байна гэж тодорхойлжээ. Японы эрдэмтэн К. Ито Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэр багт 1992 оны намраас 1993 оны намар хүртэл хийсэн суурин судалгаа болон 3 жилийн 1996 оны зун явуулсан хээрийн судалгаандаа үндэслэн “Говь нутгийн хот айл, түүний бүтэц ба онцлог” (Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэрийн жишээн дээр) хэмээх өгүүлэлдээ 1990 оноос хойших говь нутгийн малчдын мал маллагааны тогтолцоог судалсан байна.²¹ Энэхүү судалгаандаа монгол мал аж ахуй социализмын дараа уламжлалт зохион байгуулалтдаа шилжсэн бөгөөд мал аж ахуйн зохион байгуулалтад хот айл ихээхэн чухал нөлөөтэй байна хэмээн дүгнэсэн байна. 1999 онд Ц. Цэвээн Монголын хээр, ойт хээр, өндөр уул, говийн бүсүүдийн 11 аймаг, 35 сумын 139 “хот айл”, 302 малчин өрхийн аж ахуйд хийсэн судалгаандаа тулгуурлан “Байгалийн бүс бүслүүр дэх хот айлын бүтэц” хэмээх өгүүлэл бичжээ.²² Байгалийн бүс, бүслүүрийн онцлогоос хамаараад хот айлын бүтэц өөрчлөгдөж байна хэмээн үзсэн байна. И. Ганболд “Малчдын бэлчээр ашиглах уламжлал ба орчин үе” түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээлдээ “хот айл”-ын шинж үүрэг үйл ажиллагаа, нутагшил, орчин үеийн байдлыг авч үзсэн байна.²³

Ноолууран бүтээгдэхүүний эх ундраг нь малчид юм. Иймд, малчин өрх, түүнийг дагасан нийгэм соёлын асуудлыг цугласан хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан дор сийрүүлье!

Монголын малчид ямар зохион байгуулалттай байсан тухай сурвалж бичгүүдэд харилцан адилгүй тэмдэглэгджээ. Эрдэмтэн Д. Гонгор Малчдын хөдөлмөр зохион

²¹ К. Ито, “Говь нутгийн хот айл, түүний бүтэц ба онцлог”, in *Олон улсын монголч эрдэмтэдийн VII хурал*, vol VIII (Уб: “Чойлжил” ХХК-д хэвлэв, n.d.).

²² Ц. Цэвээн, *Байгалийн бүс бүслүүр дэх хот айлын бүтэц* (Уб, 1999).

²³ И. Ганболд, “Монгол малчдын бэлчээр ашиглах уламжлал ба орчин үе” (Түүхийн ухааны докторын зэрэг горилсон судалгааны ажил, МУИС, 2013).

байгуулалтын үндсэн нэгж, хэлбэр нь хот айлын бүтэц зохион байгуулалт юм хэмээн үзсэн байна.

Монголын нүүдэлч малчид дан ганц өрхөөр бус хэд хэдэн айл гэрийн жижиг бүлэг нэгдлээрээ тодорхой хэмжээний газарт нүүдэллэн амьдарна. Энэхүү бүлгийн өрх гэр, хүн малын тоо, бүрэлдэхүүний тогтмол ба тогтмол бусыг үл харгалзан “хот айл” хэмээн нэрлэнэ²⁴

Өөрөөр хэлбэл “хот” хэмээх нь айл өрхийн тухайд шууд нэр болохын хамт тэдгээр гэр өрхүүдийн нэгэн дор хамтран орших газар “өтөг бууц”-ыг хэлнэ. Иймээс “хот айл” хэмээх нь “айл өрхөө” хотлуулан буй малтай нь хамтдан нэрлэж буй хоёр зүйлийн нэгдлийн зангилааг илэрхийлсэн ухагдахуун мөн юм. Хээрийн судалгааны явцад ажиглахад малчид уламжлалт ахуй хэвшилдээ дасан зохицсон амьдралын хэв маяг, зохион байгуулалтаар аж төрж байна.

Бидний хээрийн судалгаа хийсэн Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дэвсгэр нь Хангайн нурууны тусгай хамгаалалттай газарт хамаарах Хангайн гол ноён нурууны төв хэсгийн уулсын зүүнээс Тамир, Хануйн голыг дагаж зүүн тийш сунаж, хангай-гал хээрийн өвөрмөц хослол үүсгэсэн газарзүйн онцлог тогтоцтой. Нутгийн баруун зах нь уулархаг (нутгийн 40 хувийг уул нуруу эзэлдэг), ой хөвчтэй иймд тус бүс нутагт хоёр, гурван гэрээрээ бүлэглэн мал маллаж байна. Сумын хэмжээнд 2022 оны байдлаар 380,080 толгой мал тоологдсон байна. Мал тооллогын үр дүнгээс үзэхэд Ихтамир сумын хувьд ямаа үхрийн тоо толгой бараг ойролцоо байна. Тухайлбал, үхэр сүрэг 76,400 толгой, ямаан сүрэг 85,620 толгой тоологджээ. Харин адуу 32270, хонь 185,780 тоологдсон байна. Хээрийн судалгааны үеийн ажиглалтаас үзэхэд Борт, Бугат багийн нутаг уужим, тавиу тул бог мол голлон өсгөж байсан бол Хөхнуур, Хан-өндөр багийн малчид үхэр сүрэг голлон өсгөж байв. Сумын төвийн баг буюу Тайхар багийн иргэд хамгийн бага мал тоолуулсан бол Эрдэнэ-толгой баг хамгийн их хонин сүрэг тоолуулжээ.

Ер нь малчин өрхийн хүн хүчний бололцооноос хамаарч сүргийн бүтцийг тогтоох байдал нэн өндөр байна. Тухайлбал, Ихтамир сумын Борт, Бугт багийн иргэдийн хувьд хүн бүл багассан эсвэл эрүүл мэндийн шалтгаанаар сүргийн бүтэцдээ өөрчлөлт хийсэн тохиолдол цөөнгүй байна. Малчин Боржгин овогт

²⁴ Гонгор, *Халх товчоон* (= *Краткая история Халхи*).

Нарангэрэлийн Алтантуяа нь 2000 оноос мал маллаж эхэлсэн. Ам бүл тавуулаа аж төрдөг. 20 гаруй жил мал малласан. Малчид өрхийн гишүүдийн эрүүл мэнд, ажиллах хүчин, сургуулийн хүүхдийн боловсролд хамрагдах үйл явцаас шалтгаалан Их тамир зэрэг хангайн бүс нутгийн сумын малчид бог малаа бод руу шилжүүлэх байдал ажиглагдаж байна. Архангай аймгийн Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэлээс:

[Тэрээр] Бид хоёр үнэхээр бүл чадал хүрэхгүй учраас дахиж бог мал маллахгүй гэж шийдсэн. Бүх малаа 1000 хүргээд л зарсан. Бүл чадалтай айлд бол ямаа шиг сайхан мал байхгүй л дээ. Их тэсвэр тэвчээртэй, сэргэлэн амьтан. Манайх бог малаа зардаг үед манай хүний бие нь муудаад аргагүй мал харах хүнгүй байсан. Хоёрдугаарт, манайх хүүхдээ 1-р ангиас нь хотод сургадаг учраас орон гэр хэрэгтэй болсон. Тэгээд хонь, ямаагаа бүгдийг нь зараад 2 өрөө байр болгочихсон. Тэрнээс бол залхаад зарсан юм биш л дээ....²⁵

Ийнхүү нутгийн онцлогоос хамаарч тухайн бүс нутгийн малын тоо, толгой өөрчлөгдөхийн хирээр мал аж ахуй эрхлэгч өрх айлын гишүүд, мал аж ахуй хэв маяг өөр өөрийн гэсэн хэв маягтай байна. Их тамир сумынхан хэд хэдэн өрхөөр нэгдэн нийлж, бог малаа нэгтгэн ээлжлэн маллаж, үхэр (сарлаг) сүргийнхээ сүү саалийг зэхэх зэрэг хувь өрхөд хамаарах ажлыг тус тусдаа хийх нь түгээмэл байв. Тухайлбал, ямааны ноолуур самнах, хонь хяргах, мал тарих, хадлан өвс бэлтгэх зэрэг ажлыг хамтран гүйцэтгэх нь түгээмэл байна.

Малчдын эдийн засгийн бүтээмж

Монголчууд амьдрахуйн хэв маягийн үндэс нь нүүдэллэхүй бөгөөд Төв Азийн эрс тэрс уур амьсгалд дасан зохицсон мал аж ахуй, нүүдлийн өвөрмөц соёлыг бий болгожээ.²⁶ Энэхүү соёлоо өнөө үед ч хадгалсаар байгаа нь эрдэмтэн судлаачдын

²⁵ Н. Алтантуяа, Бүх ямаагаа зарсан айлын эзэгтэй. Архангай аймаг, Ихтамир сум, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/WZG8ZNRH>.

²⁶ Кэролин Хамфри. & Дэвид Снит, *Нүүдэллэхүйн ёсон эцэслэх үү?*, (Өвөр азийн нийгэм, төр, хүрээлэх орчин (Улаанбаатар: Интерпресс хэвлэлийн үйлдвэр, 2006), 5.

анхаарлыг татсаар байна. Судлаачид малчдын эдийн засаг, түүний зарцуулалтыг тодруулахдаа малчдаас асууж бөглүүлж тооцсон байдаг. Тэдний судалгааны үр дүнгээс харахад ямааны ноолуур дараах гурван зүйлд хамгийн их зарцуулагдаж буй үр дүн гарчээ (эшлэл). Нэгт, банкны өр, хоёрт, ахуйн хэрэглээ, гуравт машин, мотоцикл зэрэг зарцуулсан тухай үр дүн гардаг. Бидний судалгаанд хамрагдсан хүмүүс мөн л дээрхтэй адил хариулт өгч байв. Гэвч үнэн хэрэгтээ, судлаачийн хувьд ч, малчны төрж, өссөн хүний хувьд ч, мөн туршлага, ажиглалтаас үзэхэд дээрх үр дүн худлаа үзүүлэлт хэмээн үзэж байна. Учир нь аргачлал нь буруу юм. Ядаж л малчдын жилийн орлого, зарлагын зарцуулалт дээр харьцуулалт хийх, эсвэл нэг малчин айлын ядаж жилийн санхүүгийн үр ашгийн тооцоолол дээр дүн шинжилгээ хийхгүй бол жинхэнэ үр дүн гарахгүй. Мөн мал аж ахуй бол урт хугацааны хөрөнгө оруулалт, хөдөлмөр шаарддаг болохоор нэг жилийнх нь үр ашгаар тооцоолоход бас л учир дутагдалтай санагддаг. Бэлчээрийн мал аж ахуйд 10-20 жилийн хөдөлмөр орж байж үр ашиг хүртэх боломжтой байдаг. Ихэнх тохиолдолд хэдэн үе дамжин уламжилж ирсэн буурь бууцнаас малын нэр төрөл, малын тоо шууд хамаарах байдал ажиглагддаг. Бидний судалгаа хийсэн сумын дунджаас дээгүүр буюу 500-аас дээш богтой (говийн бүс), 100-аас дээш (хангай) бодтой айл өрхүүд ихэнх нь үе дамжсан өвөлжөө бууцтай байх нь түгээмэл байв. Мөн дээр нь мал маллах арга туршлага, хөдөлмөрч байдал зэрэг нь малчдын амьдрал ахуйд ихээхэн нөлөөтэй байна. Бидний дэвшүүлж буй гол санал бол малчдын жилийн нийт орлогын тооцоог гаргах явдал юм. Нийт орлогын хэдэн хувийг ноолуурын орлого эзэлж буйг тооцох нь нэн чухал юм. Тэндээс бид малчдын ахуй амьдрал дахь ноолуур эдийн засгийн үнэ цэнийг тооцох боломжтой. Гэхдээ тухайн бүс нутгийн онцлогийг ямагт анхаарах шаардлагатай.

Архангай аймгийн Өндөр уулын бүсийн эдийн засгийн нөхцөл байдал

Архангай аймгийн өндөр уулын бүс нь зах зээлийн хүртээмж нь үндсэндээ алслагдсан, бусад хөдөө орон нутагтай ижил нөхцөлтэй. Хатуу хучилттай замын нөхцөл нь ерөнхийдөө сайн. Гол замаас салаалсан шороон замаар зорчино. Гэвч тухайн замын нөхцөлөөс үүдэн бороо, цастай үед зорчиход хүндрэлтэй. Ихэнх өрхүүд ойролцоо зах зээлд мотоциклоор эсвэл машинаар явж хүрдэг. Хэрэгцээт

зүйлсээ худалдан авахдаа сарын хэрэглээний хэмжээгээр нь сумын захаас худалдан авдаг. Бороо их орсон үед голууд үерлэн, зах зээлдээ хүрэхэд хүндрэлтэй болдог байна. Амьжиргаа сайтай чинээлэг болон дунд орлоготой өрхүүдийн ихэнх нь машинтай тул зах зээлд хүрэхэд тэдэнд харьцангуй хялбар байх ба мотоциклоос өөр унаагүй ядуу, нэн ядуу өрхүүд хязгаарлагдмал тооны бараа бүтээгдэхүүн нэг удаад худалдан авахаас өөр сонголт байхгүй. Бороо хур ихтэй улиралд гол үерлэх (6-9 дүгээр саруудад) эсвэл өвөлдөө цас орсны улмаас зам хаагдах (12-2 дугаар сар) тохиолдолд эдгээр өрхүүдэд хүрч очих нь хүндрэлтэй байдаг. Тиймээс зарим өрх өвөл эхлэхээс өмнө (11-12 сард) хүнсний зүйлс болон бусад шаардлагатай зүйлсээ худалдан авч нөөцөлдөг.

Тухайн бүсийн малчин өрхүүдийн үндсэн, хамгийн үнэ цэнтэй бүтээгдэхүүн нь мал бөгөөд түүнийгээ бүх төрөл дээр өсгөн үржүүлж, зарж борлуулдаг. Эдгээр нь сарлаг, ямаа, хонь болон бусад мал багтана. Худалдааны гол маршрут нь тухайн борлуулж буй бүтээгдэхүүнээс (мал, бусад бүтээгдэхүүн) хамаардаг. Ихэнх худалдаа нь ченжүүдээр дамжин хийгддэг. Амьд малын худалдааны хувьд малчид өөрсдөө аймаг, сум дээрээ авчран ченжүүдэд худалдаалдаг байна. Борлуулсан бүх мал, малын гаралтай бүтээгдэхүүн Улаанбаатар хотод хүргэгдэж борлуулагдах бөгөөд тус зах зээлийн эрэлт нь аймаг дээрх малын үнийг тогтоодог. Ноос хяргах, ямаа самнах ажлыг малчид өөрсдөө хийж (зарим тохиолдолд хүн хөлсөлнө), бүтээгдэхүүнээ ченжид (сум, аймаг, явуулын ченж) нийлүүлнэ. Улмаар тухайн ченжүүд нь Улаанбаатар хотод авчран зардаг. Зарим тохиолдолд сумын ченжээс шууд Улаанбаатар хотын зах зээлд зарим бүтээгдэхүүн нийлүүлэгдэнэ. Энэ нь тухайн сумын ченжийн санхүүгийн боломжоос ихээхэн хамаардаг. Архангайн сарлагийн хөөврийг малчид хоршоонд нийлүүлэн, тэндээс боловсруулах үйлдвэрүүдэд хүргэгдэн, улмаар экспортын зах зээлд нийлүүлэгдэж байна.

Амьжиргааны энэ бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэл хязгаарлагдмал. Цаг уур хүйтэн сэрүүн учраас ногоо тарьж ургуулах хүндрэлтэй. Хамгийн их тариалдаг хүнсний ногоо нь төмс бөгөөд орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Иргэдийн хэрэглэж буй хүнсний ногооны ихэнхийг импортоор авдаг бөгөөд аймгийн төв дээр зарагдаж буй ногооны дийлэнх нь Хятад, Оросоос импортлон авчирсан хүнсний ногоо байна. Хөдөө орон нутагт олдож байгаа ур чадвар бага шаардах ажлын байрны дийлэнх (90%) нь түр ажлын байр байдаг байна. Дундаж

болон чинээлэг өрхүүд нь мал маллах, хонь хяргах, ямаа самнах зэрэг ажилд түр хугацаагаар бусдыг хөлслөн ажиллуулдаг байна. Эмзэг бүлгийн зарим малчид “туслах малчнаар” ажиллаж бэлэн мөнгө эсвэл бусад бараа бүтээгдэхүүнээр (жишээ нь мал, малын гаралтай бүтээгдэхүүнээр) цалинждаг.

Тулгарах бэрхшээл

Тус бүс (Ихтамир сум)-ийн оршин суугчид тулгарч буй гол аюулыг буурах дарааллаар нь нэрлэхэд нэгдүгээрт зуд, дараа нь ган болон бэлчээрийн доройтол орж байна. Мөн малчин өрхүүдийн хувьд бас ойн түймэр тодорхой аюул учруулдаг байна. Амьжиргааны бүсийн мал сүрэгт сөргөөр нөлөөлж буй олон тооны малын өвчин, шимэгч буйн дотор үхрийн цусан халдвар, боом, селенийн дутагдал, шимэгч хорхой зэрэг нь түгээмэл байдаг аж. Энэ төрлийн өвчнөөр үндсэндээ сарлаг, ямаа, хонь түлхүү өвчилдөг байна. Вакцинжуулалт, угаалга, туулга нь түгээмэл хийгддэг эмчилгээ бол боом, цусан хавдрын вакциныг төрийн зүгээс үнэ төлбөргүй хийдэг. Малын өвчин нь жилийн тодорхой улиралд тогтмол дэгддэггүй ч малчдын хувьд ихээхэн архагшсан асуудал болжээ.

| | Өвөл | | | Хавар | | | Зун | | | Намар | | |
|-------|--------|--------|------------|------------|------------|--------------|--------------|-------------|-------------|-------------|--------------|--------|
| | 12 | 01 | 02 | 03 | 04 | 05 | 06 | 07 | 08 | 09 | 10 | 11 |
| Цас | Blue | Blue | Light Blue | Light Blue | Light Blue | Light Orange | Light Orange | Dark Orange | Dark Orange | Dark Orange | Blue | Blue |
| Бороо | | | | | | Light Orange | Light Orange | Dark Orange | Dark Orange | Dark Orange | Light Orange | |
| Салхи | Yellow | Yellow | Yellow | Yellow | Yellow | Yellow | | | | | | Yellow |
| Үеэр | | | | | | | Light Green | Light Green | Light Green | | | |
| Нар | Yellow | Yellow | Yellow | Yellow | Yellow | Dark Yellow | Dark Yellow | Dark Yellow | Yellow | Yellow | Yellow | Yellow |

Зураг 3. Байгалийн дундаж үзэгдэл /сараар/

| | | Өвөл | | | Хавар | | | Зун | | | Намар | | |
|-------------------|------------------|------------|----|----|------------|-------------|-------------|-------------|-------------|------------|-------------|-------------|----|
| | | 12 | 01 | 02 | 03 | 04 | 05 | 06 | 07 | 08 | 09 | 10 | 11 |
| Мал төллөлт | Адуу | | | | | | Dark Green | Dark Green | | | | | |
| | Хонь, ямаа | | | | Yellow | Dark Yellow | Dark Yellow | | | | | | |
| | Үхэр/Үхэр сарлаг | | | | Light Blue | Dark Blue | Dark Blue | Dark Blue | | | | | |
| Малын ороо орох | Адуу | | | | | | | | | | | | |
| | Хонь, ямаа | | | | | | Dark Orange | Dark Orange | Dark Orange | | Light Green | Light Green | |
| | Үхэр/Үхэр сарлаг | | | | | | | Light Blue | Light Blue | Light Blue | | | |
| Мал борлуулалт | Dark Green | Dark Green | | | | | | | | | | Dark Green | |
| Сүүний үйлдвэрлэл | | | | | | | | Blue | Blue | Blue | Blue | Blue | |

Зураг 4. Мал, мал аж ахуйн хуваарьт ажлууд /сараар/

Цаг агаарын байдлын хувьд өндөр уулын бүсийн цас, хур бороо, салхи, үеэр ээрэг нь мал аж ахуйн эдийн засгийн бүтээмжид шууд нөлөөлж байдаг. Эдийн засгийн суурь бүтээмжид нөлөөлж буй байгалийн нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай юм.

| Үйл ажиллагаа | Өвөл | | | Хавар | | | Зун | | | Намар | | |
|----------------------------|------|----|----|-------|----|----|-----|----|----|-------|----|----|
| | 12 | 01 | 02 | 03 | 04 | 05 | 06 | 07 | 08 | 09 | 10 | 11 |
| Мал маллах | | | | | | | | | | | | |
| Мал зарах | | | | | | | | | | | | |
| Мах борлуулах | | | | | | | | | | | | |
| Ноолуур борлуулалт | | | | | | | | | | | | |
| Ноос | | | | | | | | | | | | |
| Ямаа самнах | | | | | | | | | | | | |
| Цагаан идээ борлуулалт | | | | | | | | | | | | |
| Хонь хяргах | | | | | | | | | | | | |
| Аргал түлш зарах | | | | | | | | | | | | |
| Хот/суурин газар ажил хийх | | | | | | | | | | | | |

Зураг 5. Малчин өрхийн орлогын эх үүсвэр /сараар/

| Үйл ажиллагаа | Өвөл | | | Хавар | | | Зун | | | Намар | | |
|--------------------------|------|----|----|-------|----|----|-----|----|----|-------|----|----|
| | 12 | 01 | 02 | 03 | 04 | 05 | 06 | 07 | 08 | 09 | 10 | 11 |
| Машин/мотоцикл | | | | | | | 06 | 07 | | | | |
| Ахуйн хэрэглээний зардал | | | | | | | | | | | | |
| Баяр наадам, найр | | | | | | | | | | | | |
| Цагаан сар | | | | | | | | | | | | |
| Хичээлийн шинэ жил | | | | | | | | | | | | |
| Зээл авах хугацаа | | | | | | | | | | | | |

Зураг 6. Малчин өрхийн эдийн засгийн зарцуулалт /сараар/

Бог малын төллөлт, үржлийн нь хугацааг малчид цаг агаарын мэдээ, уламжлалт мэдлэгтээ тулгуурлан зохицуулж байна. Бод малын төдийлөн зохицуулалт хийдэггүй. Тийм ч учраас “азарга, бухыг кийрлэн гэх биш” хэмээн ярилцах бөгөөд ихэнхдээ тухайн малын тарга хүчээс хамаарч эрт орой хээл авах нь тодорхойлогддог байна. Сүүний гарц зуны улирал хамгийн дээд хэмжээндээ хүрнэ. Энэ нь мөн зуны дэлгэр цагтай холбоотой. Их тамир сумын саалийн хугацаа сүүлийн хоёр жил 07-р сараас эхэлсэн. Зун өвсний гарц сайнгүй байснаас үүдсэн болов уу? Малчдын үндсэн орлогоо бүрдүүлэх хоёр гол хугацаа байдаг. Эхний хугацаа нь хавар, зуны (4-8 дугаар сарууд) улирал буюу ноолуур, ноос, сүүн бүтээгдэхүүний борлуулалт энэ бүс нутгийн малчдын өрхийн эдийн засагт бодит хувь нэмэр оруулж байна. Биднийг судалгаа хийх явцад ихэнх өрх цагаан идээ хийж борлуулдаг тухай ярьж байсан бөгөөд 5,000,000-50,000,000 төгрөгийн бодит хөрөнгө оруулалт буй болгож байна. Дараагийн хугацаа нь намрын улирал буюу 10-11 дүгээр сард малчид өвлийн бэлтгэл болгон мал нядлах ажлаа эхэлдэг. Түүнчлэн амьд малын худалдаа нь 8 болон 9 дүгээр саруудад хичээлийн шинэ жил эхлэхийн өмнө, малчин өрхүүд хүүхдийн сургалтын төлбөр төлөх хугацаатай

давхацдаг. Өрхийн хөдөлмөрийн бид шууд эрэгтэй эмэгтэйгээр ялгах бололцоо бага байна. Учир нь үнээ мал саах ажлыг гэрийн эзэгтэй, охид бүсгүйчүүд голдуу хийж буй мэт харагддаг. Гэвч тус ажилтай хамааралтай тугал татах, мал хурааж бөөгнүүлэх, түлээ түлш дөхүүлэх гэх мэт ахуйн шинж чанартай маш олон ажлыг өрхийн гишүүд нэг нэгийнхээ цаг завьг нөхөж хамтарч хийнэ. Зарим тохиолдолд эрчүүд үнээ сааж, тараг буцалгаж байх тохиолдол ч элбэг байна. Мөн эмэгтэйчүүд малынхаа арьс шир, түүхий эдийг голлон борлуулдаг. Гэвч нөгөө талд эрчүүд тэдгээр хүмүүс тухайн ажлыг хийх боломжоор хангаж, бусад ахуйн хүрээний туслах ажлуудыг амжуулдаг онцлог ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн хувьд бог, бод малаа маллахын зэрэгцээ мал, мах зах зээлд эсвэл ченжүүдэд аваачин борлуулах ажлыг хариуцдаг. Сарлаг саах гол хугацаа нь зун, намар (6-11 дүгээр сар) байна. Зарим малчид зундаа хонь, ямаагаа (6-7 дугаар саруудад) саадаг буюу өвөл саадаггүй. Сарлагийн сүүтэй хонь, ямааны сүүтэй хольж ааруул, тараг, цөцгийн тос үйлдвэрлэдэг байна. Малчид жилд дөрвөнтөө нүүж, зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржаандаа буудаг ба аймаг дотроо 30 километрээс хэтрэхгүй зайд нүүдэллэдэг. Зуны улиралд малчид малаа авч, нам доор газарт, худаг устайгаа ойр зусдаг бол өвлийн улиралд салхины нөмөртэй, цас багатай уул руу нүүнэ. Өвөлжилт хүндрэх үед эрэгтэйчүүд, залуучууд эр, сувай малаа авч оторлон нүүдэллэдэг бол өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүд нь хээлтэй, сул дорой малтайгаа өвөлжөөндөө үлддэг байна.

Нэн ядуу, ядуу малчин өрхүүд ихэнхдээ өвс тэжээлээ өөрсдөө бэлдэхгүй, орон нутгийн хадлан бэлтгэж зардаг хүмүүсээс худалдан авч өвөлжилтийн бэлтгэлээ хангадаг. Амьжиргааны дундаж болон дээд түвшний малчид нь өөрсдөө хадлангийн тоног төхөөрөмж, тээвэрлэх унаатай учраас байгалийн хадлангаа өөрсдөө дангаараа болон хамтран бэлтгэж авдаг. Зуны улиралд малын усан хангамж нь гол, горхи болдог. Зарим малчин өрх нь малын усан хангамжийн асуудлаа худгаар шийдвэрлэдэг. Өвлийн улиралд ихэвчлэн цас мөсийг ашигладаг. Ихэвчлэн хүн, малын усны эх үүсвэр нэг байх нь бий.

Нийтэд нь аваад үзвэл тус бүс нутгийн малчин өрхүүдийн үндсэн орлогоо олдог хоёр гол улирал (дээр дурдсанчлан 4-8 дугаар сар болон 10-11 дүгээр сар) байна. Энэ хугацааны дундуур өмнөх орлогоо зөв зохистой зарцуулан дараагийн орлогын хугацааг хүргэх шаардлага малчдад тулгарч байна. Нэн ядуу өрхүүдээс бусад бүхий

л бүлгүүд нь банкнаас зээл авдаг ба ялангуяа 2 дугаар сард (Цагаан сар тэмдэглэх зорилгоор) болон 8 дугаар сард (сургалтын төлбөр) илүү ихээр зээл авч байна.

Улирал бүрийн орлогын томоохон хэсэг нь зээлийн эргэн төлөлтөд зарцуулагддаг. Баяр наадам нь мөн өрхүүдийн хувьд ихээхэн зардал гаргадаг чухал үйл явдал байна. Ихэнх ядуу өрх банкнаас зээл авах боломжгүй тул зардал өндөртэй саруудад дэлгүүрээс хэрэгцээт зүйлсээ зээлээр худалдан авах замаар өр тавьж байна. Энэ тохиолдолд хүү тооцогдохгүй ч зээлийн хэмжээ нь хязгаартай байдаг. Энэ бүсийн тарчиг/хүнсний хомсдолд нэрвэгдэх хугацаа нь 3-5 дугаар сарууд бөгөөд энэ үед дөнгөж мал төллөж дуусаад сүү цагаан идээ гарч байдаг, мөн сүүний гарц бага, төл малд үлдээх шаардлагатай байдаг. Эрчүүд намар 10 дугаар сараас эхлэн түлээ, түлш бэлтгэн зарах ажил хийдэг ба энэ нь мөн тусгай зөвшөөрөл (Гоожин) авахыг шаарддаг байна.

Хүснэгт 3. Орлогын эх үүсвэр, бүсээр

| Өндөр уулын бүс | | | |
|-----------------|-------------------------|--------------------------------|--|
| № | Орлогын эх үүсвэр | | Тайлбар |
| 1 | Мал | Адуу | Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс нь үндсэндээ Архангай аймгийн баруун хэсгийг хамран оршдог. Тухайн бүс нь уур амьсгалын хувьд Баруун Монгол болон Хангайн нурууг дагасан эрс тэс уур амьсгалтай юм. Тухайн бүс нь мөн хагас цөлжсөн, ойт хээрийн бүс, дов толгодоор бүрхэгдсэн байдаг. Амьжиргааны энэхүү бүс нь эдийн засгийн хувьд мал аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүнд суурилсан бөгөөд сарлаг, адуу, хонь, ямаа голлон өсгөдөг. Мөн орон нутгийн гол эдийн засгийн суурь нь амьд малын арилжаа, малын гаралтай бүтээгдэхүүн болох сүү, ааруул, шар тос, тараг, айраг, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн юм. |
| | | Үхэр | |
| | | Сарлаг | |
| | | Хонь | |
| | | Ямаа | |
| | | Тэмээ | |
| | Малын түүхий эд | Ноолуур | |
| | | Мах | |
| Ноос | | | |
| Сүү | | | |
| 2 | Орлогын бусад эх үүсвэр | Төрөөс олгох, халамж, тэтгэвэр | Амьд малын арилжааны хувьд сарлаг, адуу өндөр үнэлгээтэй байсан бол мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс ямааны ноолуур нь хамгийн өндөр үнэлэгддэг байна. Хонины ноосыг дотоодын боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн тохиолдолд |

| | | | |
|--|--|------|--|
| | | Зээл | <p>малчид ноосны нөхөн олговор авдаг ба энэ нь өөр бусад орлого олохуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэх сэдлийг бууруулж байна. Бүх бүлгийн хувьд өрхийн орлого нь мал аж ахуй болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтаас бүрэн хамаардаг бөгөөд хамгийн багадаа нийт орлогынх нь гуравны нэг хувь байдаг байна. Амьжиргааны түвшин доогуур бүлэг нь айлын мал хариулах, хонь ноослох, байгалиас жимс самар түүж, зарж борлуулах, түлшний мод бэлтгэж зарах зэргээр нэмэлт орлого олдог байна.</p> |
|--|--|------|--|

Дээр бид малчдын ерөнхий нөхцөл байдлыг өндөр уулын бүсийн жишээгээр товч үзэв. Харин үргэлжлүүлэн Малчдын орлогын эх үүсвэрт үзүүлж буй ноолуурын үр ашгийг доор өгүүлэхийг хичээе!

Ноолуурын эдийн засгийн үр ашиг /жишээ/

Малчид сүүлийн жилүүдэд мөнгөтэй харилцах, удирдах ур ухаан их чухал болж байгаа тухай ярьж байв. Тэд олохоосоо зарцуулах чадвар чухал хэмээн ярьж байна. Ингээд бид малчид чухам юу бүтээж буй тухай авч үзье!

“Монголчууд тарган мал тал бүрийн ашигтай” хэмээн хэлэлцдэг. Энэ ойлголт нь ширхэгтийн хаан хэмээгдэх ноолуурт хамааралтай. Их тамир суманд нэг ямаанаас дундаж нь 300 гр, борлон 200 грам, эм ямаа 300 грам, эр ямаа 500-700 грамм ноолуур гардаг байна. Зарим тохиолдол 1 кг хүртэлх ноолууртай ямаа байдаг ч тийм олон биш ажээ.

Архангай аймгийн Ихтамир сум нь Монгол үүлдрийн ямааг голлон өсгөж байна. Энэ тухай Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Өндөр уулын бүсийн захирал Ч.Мөнхбат дараах тайлбар хийв.

Архангай аймгийн Ихтамир сумын Борт, Бугат, Эрдэнэтолгой багийн малчид бог мал голлон өсгөж байна. Үүлдэр угсааны хувьд Монгол хэв шинжийн ямаа өсгөж байна. Тус үүлдрийн онцлог нь Төв Азийн байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд бэлчээрээр маллахад бүрэн зохилдсон ялангуяа говь, цөлөрхөг болон өндөр уулын бэлчээрийг чадамгай

ашигладаг, биологи-аж ахуйн өвөрмөц онцлогтой. Монгол үүлдрийн ямаа 1,5 нас хүртэл эрчимтэй өсөж эхийн жингийн 73,8%-д хүрч, цаашид түүний өсөлт 4,5 нас хүртэл үргэлжилж нас гүйцсэн ямааны амьдын жингийн 97,4%-д хүрнэ. Монгол ямаа зун, намрын улиралд дээд зэргийн тарга хүч авч, өвөл, хаварт намрын жингийнхээ 25-27%-ийг алдаж онд ордог. Нутгийн ямаа тус орны аль ч бүс нутагт янз бүрийн зүстэй байдаг. 1958 оноос хойш нутгийн ямааг гадаадын үүлдрүүдтэй эрлийзжүүлсний улмаас 30-аад жилийн дараа 60 гаруй хувь нь бараан зүстэй болсон боловч сүүлийн жилүүдэд шилмэл омгийн улаан ямааг үндсэн сайжруулагчаар эрчимтэй ашигласны дүнд монгол ямааны зүс өөрчлөгдөж, цайвар ноолуурын үйлдвэрлэл нэмэгдэж байна.²⁷

Ийнхүү мал аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж буй малчид тарган ямаанаас сайн ноолуур авахаас гадна, ямааг жилийн дөрвөн улирал зохистой бэлчээрт хариулж таргалуулснаар малчид ноолуураас гадна төрөл бүрийн ашиг хүртэж байна.

Ихтамир сумын Борт багийн тухайд өрх бүр дөрвөн төрлийн мал өсгөж байна. Тэд үхэр, адуу, хонь ямаа зэргийг голлон өсгөж буй бол тэмээ харьцангуй цөөн юм. Бид энд хангайн бүсийн малчид нэг жилийн ажил хөдөлмөрийг тоймлон өгүүлэхийг зорив.

Архангайн Их тамир сум Борт багийн малчин Баттулга нь 1975 онд төрсөн, 47 настай. Тэднийх дөрвөн төрөл (үхэр, хонь, ямаа, адуу)-ийн мал өсгөдөг. Тэрээр,

Манай нутгийн онцлог гэвэл байгаль, цаг уур сайхантай, өвөлдөө нөмөртэй мал ер нь мууддаггүй, мал тарга хүч сайн авдаг, өвс ургамал сайн ургадаг тийм онцлогтой газар. Одоо ерөнхийдөө газрын гарц, ургамлын бүтэц өөрчлөгдөөд аягүй муу болж байгаа. Гэхдээ манай энд харьцангуй гайгүй байгаа. Ер ган болоод байгаа шүү дээ. Урдуур хойгуураа ургамал муудаад ус нь ширгээд л яг манай энд бол булаг шанд нь өвөлдөө, хавартаа, зундаа гараад байдаг...²⁸

²⁷ Ч.Мөнхбат, МААЭШХ-ийн салбар, Өндөр уулын бүсийн захиралтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

²⁸ Баттулга & Саранцэцэг Баасансүрэн, Ноолуур:"Цагаан алт". Архангай аймаг, Ихтамир сум, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/ZZA2YIUJ>.

Тэднийх Жаргалантын аманд өвөлжөөтэй. Өвөлжөөнөөсөө 5 км орчим зайд хаваржиж, дахиад 5 км зайд зусна. Намрын цагт хаваржааныхаа ойролцоо бууж намаржаад цас орж хүйтрэх үед өвөлжөөндөө буудаг. Уг бүс нутаг нь өвс ургамал жигд тул төдийлөн нүүдэл хийгээд байдаггүй аж. Тэднийх 200 гаруй сарлагтай, 80 орчим ямаатай, 300 гаруй хоньтой, 50 орчим адуутай. Эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг. Хүүхдүүд нь намар сургуульд орох үед эхнэртэйгээ хоёулаа хамт малаа маллана. Тэрээр,

Ямаа бол 5 сар хээлээ тээдэг мал. Бид Хөвсгөл аймгаас “эрчмийн хар” гэх омгийн тэхээр сүүлийн жилүүдэд ямаагаа сайжруулж байна. Намар 10 сарын 20 орчим тэхээ сүрэгт нийлүүлдэг. 80 ямаанд нэг тэх хангалттай. Хавар 03 дугаар сарын 20-оос 04 дүгээр сарын 10 хооронд төллөдөг. Ямаа төллөх үеэр ишигний хашлага зэхэж бэлдэнэ. Шөнө гарч хоёр удаа эргэхгүй бол хүйтэнд хөлдчих гээд байдаг. Манай нутагт 03 дугаар сарын 20 гэдэг бол цаг тавих болоогүй үе л дээ. Ишиг их бээрэг амьтан юм. Шувууны сүүдэр дайрахад хөлдчих гээд байдаг талтай. Ямаагаа тусад нь битүү хашаанд оруулдаг. Хоньтой хамт хашаалбал малын үс ноос гишгэчээд байдаг талтай. Ишигтэй ямааг 7 хоног гардаж асрах хэрэг гарна шүү. Хургатай харьцуулахад туниа муутай юм. Ноолуур сайтай ямааны төл харьцангуй туниа муутай гарах нь бий. Нусаа гоожуулсан юм л гардаг. Ингэж ямаагаа төлүүлсний дараа 14 хоногтойд ялгаж сургана даа. Ээжээс нь ялгаж өөр жижиг хашлагт оруулна. Байнга тэвэрч зөөнө гэж барахгүй их ажил болно. Ялгаад сургачихвал их амар байдаг юм. Сүүтэй ямааны ишиг сүүлээ өргөж явдаг юм. Сүү муутай бол сүүлээ хавчиж явдаг. Ер нь төл мал андашгүй л дээ. Сүүтэй бол ноос нь гялтганаад сэргэг байдаг юм. Заа сүү хөхсөн ишигний хошинг баасандаа бөглөрнө гэж юм бий. Үүнийг цэвэрлэх ажил бас хийнэ шүү дээ. Ухаандаа, сүү хөхсөн ишигний цаас гэдэг чинь наалдсан шар юм байдаг юм. Тэр нь сүүлнийх нь үсэнд наалдсаар байгаад бүтчихэж байгаа нь тэр. Түүнийг сайхан цэвэрлэх хэрэгтэй. Хурганы хошног ч бас ялгаагүй бөглөрнө. Өглөө гаргаж хөхүүлнэ. Орой бас хөхүүлнэ. Ингээд, 10 орчим хоног болоод ирэхэд нь намар бэлдэж авсан төлийн ногоон өвснөөсөө тавьж өгнө. Ус өвс шамшсаар байгаад идэж сурдаг юм. Ээжтэй нь бас ойр

бэлчээрт гаргах хэрэгтэй. Төл малыг өдөр нь ялгаж авч үлдээх их чухал. Өдрийн наранд сайхан унтана шүү дээ. Өвсөнд аль болох хурдан оруулбал эхэд нь ч илүү амар байдаг. Ишгэндээ илүү амар...²⁹

Баттулга гуайн ямаан сүргээ сайжруулсан “эрчим” үүлдрийн ямаа нь манай орны өндөр уул, ойт хээрийн бүсийн байгаль, цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохицсон, сахлаг хар хүрэн өнгийн хялгастай, бараан саарал, цайвар саарал өнгийн ноолууртай. Гэдэс хөлийн ноолууржилт хангалттай, хялгас ноолуураа давж ургасан байна. Бусад үүлдэр, омгийн ямаанаас 1,8-5,9 кг-аар илүү жинтэй бөгөөд амьдрах чадвар сайтай, урт ноолууртайгаараа онцлог юм. Ойт хээрийн бүс дэх Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нөхцөлд ардын уламжлалт селекцийн үр дүнд бий болсон ямаан сүргийг түшиглэн Горно-Алтай үүлдрийн ямаагаар сайжруулах ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулсны үр дүнд ноолуур-мах сүүний ашиг шимийн чиглэлийн Эрчим хар ямааг бий болгожээ.

Ийнхүү ямааны үржлийн ажлаас гадна түүнийг бойжуулах, маллах арга ажиллагаа нь ихээхэн хүч хөдөлмөр шаардсан ажил болдог байна. Ямаа ишиглэсэн цагаас 14 орчим хоногийн дараа ишиг бие дааж, нүүдэл дагах хэмжээнд хүрдэг ажээ. Малчдын дунд эхдээ гологдсон юм уу, сүүгүй болсон ишгийг зохицуулах уламжлалт хэд хэдэн арга бий аж.

Мал маллахад арга буюу эхгүй болсон ишгийг зохицуулах шаардлага гарах нь бий. Мэдээж малчин хүн болсон хойно амьдруулахыг хичээнэ. Ишгээ цатгаж чадахгүй, эх нь голоод байгаагийн цаад шалтгаан нь тарга тэвээрэг муу байгаагаас л болдог. Иймд, мал төллөх үе гэдэг бол тухайн малчны нэг жилийн хөдөлмөр, бэлтгэлийг шалгаж буй шалгалт гэж ойлгож болно. Ишиг эхгүй болох хэд хэдэн шалтгаан байна. Төрөхийн хүндрэлээр эх нь эндэж болно. Гэнэтийн эрсдэл (чоно хазах, бэртэж гэмтэх, өвчин ирэх), хүч тарга муу, ааш аяг муутай (анхны төрөл буюу нэмж буй ямаа) зэрэг шалтгаанаар эхгүй болсон ишгийг нэгдүгээрт эхэд нь авхуулахыг хичээнэ. Үүнд, “чүүглэж” авахуулах арга бий. Хөдөлгөөнгүй барьж байгаад ишгийг нь хөхүүлээд “чүүг чүүг” гэж уянгалаг дуугаар дуулна. Боломжгүй бол өөр ямаанд дээрх аргаар

²⁹ Баттулга & Баасансүрэн.

хөхүүлж авахуулна. Боломжгүй бол угжиж тэжээнэ. Угжиж тэжээхэд хүндрэлтэй, мал болгох боломжгүй бол гэрийн бүсэд хавчуулаад гэрээнийхээ бүсийг чангалж, эхгүй ишгийг амраадаг ёстой.

Дээрх өгүүлэмжээс үзэхэд хаврын улиралд малчны хотонд төлийн дуу цангинаж байдаг. Тэр олон дууны зөвхөн нэг нь л ишиг юм. Гүү унагалж, үхэр тугаллаж, хонь хургалж, ямаа ишиглэж байдаг. Иймд, малчид тун завгүй байх тул зарим тохиолдолд эхгүй ишгийг онцгой нөхцөлд гэрийн бүсэд хавчуулаад бүсээ чангалж, амраах ёс бий ажээ. Энэ тухайд, гэрийн бүсэд бог малын төлийг хавчуулж амраах ёс бий. Үндсэн санаа нь төл малыг алж буй хэрэг биш гэрийн бүсээ чангалсан л хэрэг болж байна хэмээн үзэж болмоор байна. Өөрөөр хэлбэл, Өөрийнхөө үйлийг төөрүүлж буй хэлбэр бөгөөд энэ амьтны амь тасалж буй хэлбэр болохгүй ажээ. Малчдын хувьд ажиглаж байхад зудтай жилийнхээ өнгийг ярилцахдаа *“хэрэг байхгүй ээ. гэрийн бүсэд хавчуулаад дууслаа”* гэж уулга алдаж байдаг. Энэ нь жил хэцүү болсны үрээр төл сайн авч чадсангүй ээ гэсэн санаа юм. Мал маллах аргын тухайд,

Дээрх өгүүлэмжид тулгуурлан бид малчдын арга туршлага гэдэг бол тарган мал өсгөж, үр өгөөжийг нь хүртэхийн тулд дагаж, суралцах нь хамгийн шилдэг арга хэмээн үзэж болмоор байна. Энэ нь малчин хүн ноолуураас гадна өөр олон зүйлийн соёлын болоод эдийн засгийн үр ашгийг бүтээж байдаг гэсэн санаа юм. Үүний нэг тод илрэл нь Монгол улсын хангайн бүсийн малчдын нэгэн өвөрмөц баялаг бол цагаан идээ боловсруулах уламжлал юм. Ялангуяа Ихтамир сум бол цагаан идээний үйлдвэрлэлээр Монгол улсад дээгүүрт ордог газар юм. Иймд бид, тэдний цагаан идээ хийх арга ажиллагаа дор сийрүүлэв.

Үнээг эхнэр, охин хоёр саана. Би үнээгээ хурааж ирнэ. Үнээгээ хашаанд хашиж өгнө. Мөн үнээгээ ивэлгэж өгдөг. Тугал татах гэдэг ч бас хөөрхөн ажил шүү. Мөн манай зээ нарыг манай бага охин хардаг. Аль эсвэл би харна. Мөн хүргэн энэ хооронд хонио дагах, адуу малаа харах зэрэг ажил амжуулж байдаг...Зуны өглөө 6 цагаас 09.30 орчимд гээд дуусчихна шүү. 3 цаг гаруй саана. Намарт арай хурдан саана. Учир нь үхрийн сүү багассан байдаг. Саасан сүүгээ их дүүргэхгүйгээр юүлэх сав саалийнхаа хажууд авч очдог. Үнээгээ саагаад дүүрээд ирэхээр нь нөгөө сав руугаа шүүгээд юүлчихдэг. Сүү шүүх алчуур, маарил бэлдэж очдог. Саасан

сүүгээ оруулж шүүнэ. Шүүлтүүр дээр дөрвөн давхар маарилаар шүүдэг. Маарилаа солихгүй. Өдөр өдөрт нь угаагаад хатаачихдаг... Дараа нь хөөрүүлнэ. Эхлээд ширүүн галаар, дараа нь зөөлөн галаар хөөрүүлнэ. Ер нь зөөлөн галаар хөөрүүлдэг. Сойлттой тогоон дээрээ сүүгээ хийдэг. Халсан тогоон дээрээ сүүгээ хийвэл сүү хайрагдана. Түлэнхий амт орчихвол их муухай. Хөөртөл хүлээж байгаад хөөсөртөл самарна. Хөөртөл сүүгээ хутгахгүй. Хөөсөртөл сайн самарна. Өмнөх галаасаа зөөлөнө. Галаа тааруулахгүй бол хөөсрөхгүй. Тэгээд тогоондоо загсаана. Хөөс нь дарагдаад өрөм нь шарлаад гарч иртэл галыг нь тааруулж байлгана. Загссаны дараа сэрүүн газар тавина. Сүүдэр газар тавина. Өрөм зузаан гарна. Халуудахаар цөцгий суучихдаг. Хувинд хийх бол хувиндаа самарна. Хувинд байгаа бол халууныг алдуулахгүйгээр хучиж, цуглана. Сүүнийхээ өрмийг хамж авна. Тэгээд сүүгээ гал дээр тавиад тарганы хөрөнгө хийнэ. 20 л сүүнд хоёр амны халбага тарга хийж самарна. Хүйтэн сүүн дээр хөрөнгөө хийж самардаг. Хуруунд “час” халуун мэдрэгдэх үест саванд хийж хучиж тавина. Хоёроос гурван цагт тараг бүрэлдэнэ. Хөрсөн таргаа айраг руугаа хийгээд сайтар бүлнэ. Дараа нь иссэн айргаа нэрнэ. Таргаа исгэж, чангалаад айраг болгодог. Айргаа гурван усаар авч болно. Архи чанга бол гурван усаар авч болно. Айргаа хөргөөд болсон сүүгээр (8-10л) ээдүүлнэ. 5 орчим л сүү авч үлдэх ёстой. Ээдүүлсэн аарцаа шүүнэ. Баадан даавуунд шүүнэ. Нэг давхраар шүүнэ. Цагаан ямбуу гэхээр хүмүүс мэднэ. Шүүсэн аарцаа баадагнаад гаргаж гадаа дарна. Дарж шимийг нь авна. Дээр үед чулуугаар дардаг байсан. Одоо бэлэн төмрөөр дарна. Дарсан ааруулаа нэг хонуулаад маргааш зүснэ. Дарсан ааруул бороонд асуудалгүй. Наранд ч ажрахгүй. Нэг хонуулаад дарсан ааруулаа зүснэ. “Хурууд ааруул” гэж нэрлэнэ. Үйл оёдог нарийн утсаар зүснэ. Оо утас бүдүүднэ. Хурууд ааруулаа ааруулын дэлгэц дээр гадаа наранд хатаана. Норгож болохгүй. Төмөр дэлгэж дээр хурдан хатна. Модон дэлгэц дээр их удахаараа хөгцрөх гээд байдаг...³⁰

³⁰ Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Ийнхүү хийсэн цагаан идээгээр Ихтамир сумын өрх бүр тодорхой хэмжээний орлого олдог. Бидний тооцож үзсэнээр жилд нэг өрх айл багадаа 5 орчим сая төгрөг, хамгийн дээд хэмжээ нь 50 сая төгрөг олж байна. Тэд дараах нэр төрлийн цагаан идээг зах зээлд борлуулж байна. Үүнд,

| | |
|--|-------------------------------|
| 1 кг энгийн чихэртэй ааруул | 16.000-22.000 |
| 1 кг хорхой ааруул | 18.000-22.000 |
| 1 кг сүүн ааруул | 20.000-25.000 |
| 1 кг чихэргүй ааруул | 20.000 |
| 1 кг дээжийн ааруул /нэг тавгийн идээний ааруул/ | 200.000-350.000 |
| 1 кг тогооны өрөм | 2500-15.000 |
| 1 кг ээзгий | 12.000 |
| 1 кг шар тос | 5000-15.000 |
| 1 кг тос | 15.000 |
| 1 кг хайлмаг | 6000-10.000 |
| 1 кг бор тос | 15.000 |
| 1 кг сарлагийн сүү | 3000 |
| 1 кг аарц | 3000 төгрөгийн ханштай байна. |

Энэ бүхнийг энэ хэсэгт дурдсан нь Монголын ноолуур үйлдвэрлэгчид энэ мэт олон төрлийн ажил хөдөлмөрийг давхар эрхэлж байна. Энэ хэмжээгээрээ тэдний нийгмийн сүлжээ зөвхөн нутаг, гол усаар үл хязгаарлагдаж байна. Тэд Улаанбаатар, аймгийн төвийнхөнтэй нягт харилцаа холбоо үүсгэж, олон талт харилцааг идэвхтэй ашиглаж байна. Ингээд үндсэн сэдэв болох ямаа самнах арга ажиллагааны тухай ярилцъя!

Ноолуурын үйлдвэрлэлийн соёлын үнэ цэнэ

Малын буян хишиг

Мал аж ахуйн соёлыг судлахад эн тэргүүнд “малын буян хишиг” хэмээх ойлголт нэн чухал үүрэгтэй байна. Иймд, Тогтвортой ноолуурын ёс зүйг “малын буян

хишиг” хэмээх ойлголтоор дамжуулан монгол соёлын гүн дэх хүн, байгаль, мал-амьтан хоорондын харилцааны үндсэн мөн чанар, баримтлах зан заншлыг тодруулахыг зорив.

Эрдэмтэд “Fortune” буюу “Хишиг” хэмээх ойлголтод ерөнхий утгаараа “амны хишиг, буян хишиг, хишиг, хэсэг, буян заяа, заяа буян” зэрэг олон ойлголтыг нэгтгэн ойлгож байна. Р.Эмпсоноор хишиг хэмээх үгийн үндэс нь эртний түрэг хэлний “kezig” хэмээх нэгд, шугам (line), давтамж (sequence), ажиллах, эргэх (a turn/ shift), хоёрт, урам зориг (courage) гэх утгатай үгээс гаралтай гэж зарим эрдэмтэд үзжээ. Харин сурвалж бичгийн хувьд МНТ-д “хишигтэн” хэмээн тэмдэглэсэн нь хамгийн эртний тохиолдол аж. Тодорхой цаг үеүдэд олон янзаар (кешиг-keshig, кесиг-kesig, кесэг-keseg) бичигддэг уг нэр томъёог англи хэлний “fortune” хэмээх үгээр ихэнх тохиолдолд оноон нэрлэж, олон газрын монголчууд (Өвөр Монгол, Ойрад Монгол, Буриад, Халимаг), Өвөр Ази, Төвөдийн бүс нутгийн хүмүүсийн өдөр тутмын ярианы хэлбэр дэх аз жаргалын олон төрлүүдэд хамаарах ойлголтуудыг заан нэрлэж байна. Тус аз жаргалын олон төрөл гэдэгт хүний биед эргэлддэг, тухайн хүний зан чанар, үйлдлээс хамааран өсөж, буурдаг ч хэзээ ч алга болдоггүй зүйлийг хамаатуулан үзжээ. Тийм ч учраас “хишиг” хэмээх ойлголтыг англи хэлнээ олон янзаар орчуулсан байдаг. Тэд тухайн нэр томъёоны түүх, соёлын утгыг илэрхийлэхийн тулд “bestowing”, “blessings”, “capturing”, “harnessing”, “beckoning”, “distributing”, “receiving/descending from above”, “accepting from a senior” гэх мэт үгийг ашигласан байна.³¹

Монголчуудын хишгийн тухай ойлголтыг тусгайлан судалсан Английн антропологич Рэбэка Эмпсон монголчуудын хувьд хишиг нь дундуурыг дүүргэж, дутууг нөхөж байгаа үйл явдлаар дамжин ойлгогдох амьдралын хүч, эсвэл амилуулагч мөн чанар гэх сэтгэлгээ хэмээн тодорхойлсон байдаг.

“Хишиг” хэмээхийг маш энгийнээр ойлгохын тулд бид тоосгоор байшин барьж байна хэмээн төсөөлөх хэрэгтэй. Нэг л тоосго авбал байшин тэр чигтээ нурж болзошгүй. Тиймээс та тоосго авахаас өмнө урьдчилан

³¹ Rebecca M. Empson, *Harnessing Fortune: Personhood, Memory and Place in Mongolia*, British Academy Postdoctoral Fellowship Monographs (Oxford, New York: Oxford University Press, 2011).

сэргийлэх арга хэмжээ авч болно. Энэ нь “хишиг” буурахаас сэргийлсэн зан үйл юм. Харин барьж буй байшингаасаа тоосго авах хэрэг гарвал та бүхэл бүтэн тоосго авахгүйгээр тоосго бүрээс жаахныг зорж авч болно. Гэтэл тэр хусаж буй зүйл хишиг байж болно³²

хэмээн тайлбарлажээ. Түүний уг санааг дүйлгэн үзвэл, хүн хүндтэй хүнээсээ “буян хишиг” авдаг, харин малаас “малын хишиг” авдаг, мөн хэн нэгний танд хэлсэн, санамсаргүй сонссон чухал мэдээлэл нь аз завшаантай хэрэг байж болно. Энэ нь “амны хишиг” болно. Хүүхэдтэй холбоотой зан үйлийн үеэр хүмүүсийн өгдөг зүйл (мялаалга) болох амттан, эмээл, хазаар, морины ташуур зэрэг нь “хишигтэй юм” болно. Тэдгээр зүйлс аз дагуулж болно. Мөн тухайн гэр бүлийн эрүүл энх, мал идээ, ажил үйлс бүтэмжтэй байгаа нь айлын хишиг болох бөгөөд тэр нь хүнд тогтдог. Мөн улс оронд сүр хүч хуралдаж, түүнийг түгээх нь “төрийн хишиг” болно. Тухайлбал, төрийн шагнал, төрийн бэлэг зэргийг хамруулан ойлгож болох тухай дурджээ. Тэрээр монголчууд энэ мэт олон зүйлсийг “хишиг” гэх ойлголтод хамаатуулан хэлэлцэж, ихээхэн ач холбогдол өгдөг хэмээн үзжээ.

Иймд, хишиг хэмээх ойлголт нь аливаа нэгэн бүтэн, цогц зүйлийн тодорхой хэсэг болно. Тус хэсэг нь бүхэл зүйлээ төлөөлж байдаг аж. Антропологич Мэттэ Мэри Хай хишгийг малчдын ахуй амьдралыг тэтгэн бий болгогч хүрээлэн буй орчны бүхий л зүйл хэмээн үзсэн бөгөөд зөвхөн нэг л гэрт аж төрж байгаа хүмүүст хамаараад зогсохгүй, айл аймаг суух, шүтлэг бишрэлээр нэгдэж байгаа (spiritual unit) үзэгдэл ч болдог гэжээ.³³ Иймд, хийсвэр үзэл санааны тухайд “хишиг” хэмээх ойлголтыг нэгтгэн дүгнэхэд хэцүү ажээ. Янз бүрийн түвшинд, харилцан адилгүй байдлаар ойлгогдох боломжтой тул “хөдөлгөөнт” мөн чанартай хэмээн судлаачид үзэж байна.

Бидний танин мэдсэнээр “хишиг” хэмээх ерөнхий ойлголт нь нийгмийн амьдралын маш олон талбарт хамаатай. Тиймээс түүнийг бүлэглэн ангилж үзвэл, монголчуудын идээ ундааны соёлд хамаарахыг нь “Амны хишиг” хэмээн үзэж

³² Empson, 73.

³³ Мэтэ Мэри Хай, *Аюултай хишиг: Монголын албан бус алтны уурхайн эдийн засаг дахь хөрөнгө ба эцэгчлэл* (Улаанбаатар, 2012), <https://research-repository.st-andrews.ac.uk/bitstream/handle/10023/5510/high2010AyultaiKhishig.pdf>.

болох юм. Харин мал аж ахуйн соёлд хамаарах хэсгийг “малын буян хишиг” хэмээн үзэж болмоор байна. Энэ мэт байдлаар бусад зүйлд хамаарах хишгийн тухай ойлголтыг лавшруулан судлах нь чухал хэмээн бид үзэж байна. Хишиг гэдэг бол үл үзэгдэх зүйл.³⁴ Энэ утгаараа “малын буян хишиг” ч мөн үл үзэгдэх мөн чанартай. Хайрлах, эсвэл дурлах нь бас үл үзэгдэх зүйл болно. Үл үзэгдэх зүйлс таныг зовоодог ч басхүү аз жаргалыг авчирдаг. Хайраас ялгаатай нь хишиг амьдралд шаардлагатай зүйлс (өдөр тутмын хоол хүнс, мал, үр хүүхэд) болж харагдана. Гэвч тэр хөдөлгөөнт шинж чанартай учир хүмүүс үүнийг алдахгүйн тулд өдөр бүр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байдаг. Тухайлбал, малчны хотонд гэрийн эзэгтэй өглөө эрт босож, цайгаа чанаад, хамгийн түрүүн уул усандаа сүүн сацлаа өргөж, дараа нь бурхан тахилдаа цайныхаа дээжийг хийж тавиад, түүний дараа гэрийн эзэнд цайныхаа дээжийг хийж өгч, зочид, үр хүүхдүүд, өөртөө цай аягалах зэргээр бүхэлдээ тогтсон дэг журмыг дагаж байдаг. Энэ үйл явц нэг талаар цайны дээж (буянт сүргийн хишиг)-ээ уул ус, хайрхад, бурхан шүтээндээ өргөж, дараа нь өөрсдөө цайгаа хүртэж буй хэлбэр болох боловч нөгөө талаараа “амны хишиг”-ээ бусадтай хуваалцаж, талархлаа илэрхийлж буй хэлбэр болно. Энэ мэт байдлаар бид өдөр тутмын амьдралд зан үйлээр дамжуулан хишигтэй байнга харилцаж байдаг.

Ямаа буяны аргамж болох тухай

“Мал дагавал ам тосдоно” гэдэг үг Монголчуудын хувьд мал сүрэг нь амьдралын эх ундарга болохыг сургасан хэрэг байж болох юм. Яг энэ үгтэй ойролцоо утгатай хэллэг буй нь “малын буян” хэмээх үзэл санаа юм.

Мал маллах гэдэг бол олон үеийн өвгөдийн мэдлэг, нэг насны туршлага юм шүү дээ. Аав, ээж нь малчин бус айлын хүүхдүүд малчин болоод явна гэдэг хялбар зүйл биш. Хашир туршлагатай малчдаас сайн асууж, заавар зөвлөгөө авах л чухал юм. Дагаж, харж сурдаг л мэдлэг юм шиг. Байгалийн араншин, малыг аяыг дагуулах гэж их мэдрэмж шаардсан зүйл

³⁴ Rebecca Empson, “Reproducing People and Prophecy in Mongolia”, *Cambridge Anthropology* 25, no 3 (2005): 52–60, <https://www.jstor.org/uwinnipeg.idm.oclc.org/stable/23820771>.

байна. Цаашилбал, хэдэн мал маллах ч нэг хэрэг. Харин малыг малласан юм шиг маллах гэдэг чинь бас өөр хэрэг шүү. *“Хүсэлтэйгээрээ баян болдоггүй, хүчтэйгээрээ ноён болдоггүй”* гэдэг ч үг бий. Дээр үед малтай хүнийг “баян” гэдэг байж. “Малын буян дагах” гэж ч юм бий. Ухаандаа “малын нөмөрт мал өсгөх” гэдэг нь тэр юм уу даа. Малтай хүнийг дагаж л мал маллах аргад суралцдаг юм шүү дээ...³⁵

Энэ бол мал сүрэг зөвхөн өвс, ус, бэлчээр, маллагаагаар өсдөг юм биш гэсэн үг бөгөөд өөр ямар нэгэн зүйлийн нөлөөгөөр эрүүл энх, бүрэн бүтэн өсөж, үрждэг гэсэн ойлголт юм. Тийм ч учраас малчны хотонд бид “малын буян хишиг”, “буянт сүрэг”, “буянаа барсан” гэх мэт үг хэллэг төвөггүй олж сонсож болно (Мижид, С 2023, 15). Тэдгээр үгс нь энэ бүхний цаана мал сүргийн эдийн засаг, хүнс, аж ахуйн үр нөлөөг тодотгож буй “малын буян” хэмээх ойлголттой шууд холбогдож байгааг танин мэдэх боломжтой юм. Мөн малчид ямааг зөвхөн ноолуурынх үр ашигт шүтэж өсгөдөггүй бололтой.

Үхэр дагнан өсгөж буй хүнийг “үхэрчин”, адуун сүрэг маллаж буй хүнийг адуучин гэж нэрлэдэг. Харин бог мал буюу хонь ямаа нийлүүлэн маллаж буй хүнийг хоньчин гэж шууд нэрлэнэ. Зарим тохиолдолд 700-800 ямаа, цөөхөн хэдэн хоньтой сүрэг хариулж яваа хүнийг мөн “хоньчин” эсвэл “малчин” хэмээн нэрлэж байна. Бид “ямаачин” гэж нэрлэж буй хүмүүстэй тааралдсангүй. Монгол хүний чихэнд энэ нэршил тийм ч танил биш бололтой. Бидний цуглуулсан хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнд дулдуйдан өгүүлэхэд говийн сумын малчид ямаа голлон өсгөх боловч их бага хэмжээнд тэмээ эсвэл адуутай байна. Тохиолдлоор дан ямаа малладаг өрх байлаа ч түүнийг малчин өрх хэмээн нэрлэхээс бус “ямаачин” өрх хэмээн нэрлэхгүй юм. Энэ нь Монгол улсад ноолуурын ашгийн төлөө дан ганц ямааг олон тоогоор дагнан өсгөх үзэл санаа харьцангуй бага хэмээн үзэж болмоор байна...³⁶

³⁵ Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

³⁶ Хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Биднийг хээрийн судалгааны ажлаар Архангай аймгийн Ихтамир суманд ажиллах үеэр Архангай аймгийн Өндөр-улаан сумын Хануй багийн уугуул Найман овогт Тогтохын Оюунчимэгтэй хийсэн ярилцлагын үеэр тэрээр энэ үгийг ашигласан юм. Малын буянтай холбоотой үзэл санаа монголчуудын дунд нийтлэг тохиолдох хэдий ч бөгөөд тэрээр “ямаа бол буяны аргамж” юм хэмээн тодотгож буй нэн сонирхолтой байв. Тэрээр,

Ямаа чинь бас чоно боохойд хамгийн соргог амьтан. Тэгэхээр хэрэгтэй. Тэгээд ч дээр үеийн хүмүүс ямааг буяны аргамж гэдэг байсан. Тийм учраас бүр мөсөн арилгахгүй...³⁷

Дээрх өгүүлэмжид тулгуурлан бид дараах тус саналыг дэвшүүлж болмоор байна. Үүнд, нэгдүгээрт, ямаа маш соргог амьтан гэдгийг олон малчид онцолж байв. Тухайлбал,

Бэлчээр их голно, хонио уруу татаж хяр уулаар их явна, гүймтгий. Мөн соргог учир хээрийн амьтны үнэрийг хамгийн түрүүнд авч бусдадаа дохио чимээ өгдөг. Ямааны хамар ч час хийхэд бүх мал бөөгнөрдөг...³⁸

Тиймээс ямаа нь хонин сүргийг соргог бэлчээр хүргэдэг, хээрийн ан амьтан, болзошгүй аюулыг урьдчилан мэдэж, дохио өгөх зэрэг үйлдлээрээ бог малд тун чиг тус хүргэдэг аж. Мөн гэрсэг мал тул орой хот, хэвтэр лүгээ яардаг зэрэг чанар нь “ямаа бол буяны аргамж” гэх хэллэгийн анхдагч илэрхийлэл бололтой. Ер нь малчид мал сүрэг өсөж үржихийг буян тогтлоо хэмээн үзэхээс биш эрийн сайнд өсгөлөө хэмээн үздэггүй. Энэ тохиолдолд малын буяныг аргамжиж байдаг зүйл нь ямаа болох ажээ. Өөрөөр хэлбэл, малчдын орлогын 30-аас дээш хувийг бүрдүүлж буй ноолуурын орлого гэдэг бол “малын буян” хэмээх ойлголтын нүдэнд харагдаж, гарт баригдах хэсэг нь юм. Иймд, малын буян гэдэг нь мал өсөж үржих таатай бүс нутгаас эхлүүлээд мал, малчин хоёрт хамаарах бүхий л зүйлийг хамаатуулан ойлгоно гэсэн үг. Энэ тохиолдолд, Монголчуудын үзэл санааны үүднээс бол ноолууран хувцас өмсөж буй хүн “малын буян” эдэлж буй хэлбэр болно. Хамгийн

³⁷ Т. Оюунчимэг, Ямаа-буяны аргамж. Архангай аймаг, Ихтамир сум, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/676RL3M4>.

³⁸ Баянхонгор аймгийн Баянговь суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

сонирхолтой нь энэ “буян” хөдөлгөөнт шинжтэй тул түүнийг тогтоон барих, арвижуулахын төлөө хийгдэх үйл хөдлөл, ёс горимууд нь хүн малын хоорондын харилцаа, хүн байгалийн харилцааг зохицуулж, тэнцвэрт хэм хэмжээ буюу олон улсын нэр томъёогоор “тогтвортой хөгжил”-ийн үзэл санааг бүтээж байдаг. Өөрөөр хэлбэл, ноолуурын үйлдвэрлэлийн орон зайд үйлчлэх ёс зүйн хэм хэмжээг зохицуулж байдаг хэмээн үзэж болох юм. Иймд, бид малын буян, түүнд хамаарах ойлголтууд нь тогтвортой ноолуурын үзэл санааны ёс зүйн хэм хэмжүүр болох тухай тус тайланд өгүүлэх болно.

Сэтэр: Малын буян хишиг тогтоогч

Дээр дурдсанчлан монголчуудын хувьд мал өсөж үржих, хорогдож, хомсдох нь хишиг буян хэмээх далдын хүчнээс хамааралтай хэмээн үзэх хандлага бий. Тийм ч учраас малчны хотонд бид “малын буян хишиг”, “буянт сүрэг”, “буянаа барсан” гэх мэт үг хэллэг төвөггүй олж сонсож болно. Тэдгээр үгс нь энэ бүхний цаана мал сүргийн эдийн засаг, хүнс, аж ахуйн үр нөлөөг тодотгож буй “малын буян хишиг” хэмээх ойлголттой шууд холбогдож байгааг танин мэдэх боломж юм. Нөгөө талаараа, Хөдөө нутагт бүх малчин биш ч ихэнх нь малаа зодох, муу үг хэлэх зэргээс зайлсхийдэг. Тэр ч байтугай “мал алах” гэж хэлэхийг ч цээрлэнэ. Эдгээр нь мал сүргийн буян заяа, хишгийг даагч гомдохоос болгоомжилсон ойлголт, үзэл санаа юм. Тэд тэгж л итгэдэг. Өөрөөр хэлбэл, малтай харилцахдаа ямар нэг зүйлээс болгоомжилж, сэрэмжлэх байдлаар харилцана. Дээрх ойлголттой холбогдох нэгэн хууч яриа дор өгүүлье!

Эрт цагт нэгэн ядуу айл байж. Тэднийх “чаа гэх ямаагүй, туу гэх нохойгүй” юм гэнэ. Тэрээр айл, амьтанд зарагдаж хоногийн хоол олж иддэг юм байж. Нэг өдөр хүрээний (Баядын Дэжайлин хүрээ) Сид гага гэдгийнд очиж, аахар шаахар ажилд туслаад гэрийнхэн үүдээр эргэлдэхэд “хмхм... чиний гуйланчилж амьдрах хоногийн чинь тоо гүйцэх болоогүй юу? “байхаас би (бие), бэлчихээс бөөсөн” гэгчээр ... алив өөк хувхай таягаа наар ац (наашаа өг)...” гэж хэлээд таягийн авч, бариулынх нь орчмыг бага зэрэг хутгаар засаж, малын дүр оруулаад хэдэн ном уншиж, тарни шившээд буцаагаад өгч. Май хувхай таягаа шүтэж яв... харь гэж ээ.

Ингээд нөгөө ядуу эр гэртээ очоод болсон явдлыг эхнэртээ хэлж, таягаа хоймортоо тавиад орхиж гэнэ. Гуравдах өдөр дээр нь баруун хаа нь өтөж, гуриатсан жингэр гүйж ирж гэнэ. Тогооны угаадас өгч, дасгаж байгаад өтөнд нь хүүхдийн баас чихээд орхиж гэнэ. Хэд хоногийн дараа гуриатсан жингэрийн өтөн эдгэж гэнэ. Гэтэл жингэр нь тарвага, зурам барьж өгөх болж гэнэ. Жингэрээ дагуулаад тарваганы дош эргүүлээд явж байтал нэгэн өтөндөө янтсан ямаа хар эргийн унгад хэвтэж байна гэнэ. Түүнийг гэртээ авч хариад өтийн цэвэрлэж, эмнэж авчээ. Ингээд “туу гэх нохойтой, чаа гэх ямаатай” болж, нутгийн түмний тусаар “ганцаас газар дүүрэн” гэгчээр малын захтай болж гэнэ...³⁹

Дээрх өгүүлэмжид тулгуурлан хэдэн санал дэвшүүлж болмоор байна. Монголчуудын хувьд үгээгүй ядуу айлыг “чаа гэх ямаагүй, туу гэх нохойгүй” хэмээн дүрсэлдэг. Ийм хэмжээнд амьдрал доройтоно гэдэг нь буян хишгээ барсан хэрэг хэмээн үзэх нь бий. Иймд, түүний буян, хишгийг сэргээх, тогтооход чиглэсэн бурхны шашны зан үйл, ардын зан дадал, ном засал тэргүүтнийг хийдэг. Түүний нэг нь малын буян хишгийг дуудах, оршоох тухай мал сэтэрлэх зан үйл юм. Дээрх өгүүлэмжид үндэслэн үзвэл “Сид хөгшин: ядуу эрийн хувхай таягийн толгойд малын дүрс сийлж, сэтэрлэж өгсөн” байх магадлалтай юм. Эдүгээ цагт ч малын дүрийг модонд буулган сийлж, сэтэрлүүлсэн малчид цөөнгүй бий. Энэ нь заавал ядуу хүн сэтэр бурхнаа сийлүүлдэг гэсэн санаа биш юм. Малын буян хишиг хэмээх үзэл санаа монголчуудын дунд бий бөгөөд тэр нь бурхны шашны дэг горимд шингэж, монгол ахуй сэтгэлгээтэй сүлэлдсэнийг илтгэх ийм нэгэн зан үйл оршсоор байна. Тухайлбал, улаан ямааны өвчүүгээр гал тахих, улаан, орог шар, хөх зүсмийн ямааг сэтэрлэх бурхны шашны зан үйлийг зарим малчид хэрэглэж байна. Мал сэтэрлэх зан үйлийн тухайд бурханч лам Г. Пүрэвбат дараах тайлбар өгөв.

Лусын эзний үүднээс хөх ямаа, Галын тэнгэрийн үүднээс орог шар ямаа, улаан ямаа, Улаан сахиус, тангарагтны үүднээс улаан сэрх сэтэрлэдэг гэнэ. Сэтэр хэмээх нь Цэтар буюу насан гэтэлгэх хэмээх энэ насан туршид нь амь насыг нь дархлах, эдэлж хэрэглэх, үс ноосыг нь ашиглахаас үүрд дархлах зан үйл юм. Хэдий тийм боловч тухайн сэтэрлэсэн мал

³⁹ Хяргас суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2023

хөгширч зөнөх үед сүргийн дотроос идэр залуу, хүч чадал сайтай, ижил зүсмийн малыг сонгон сэтрийг шилжүүлэх, эсвээс хөгширч нүд аниваас “эзэн шүтээн мордов” хэмээн сэтэр шилжүүлдэг байна. Энэ мэтчилэн хүч чадал, өгөөж шим ихтэй малаа овоо тахилгын үед уул усны эзэн савдагт “онголон өргөх” адуу малын буян хишгийг дэлгэрүүлэн, айл өрхийн амар амгалан, цог хийморийг бадруулах зорилгоор бурхан шүтээндээ өргөж, сэтэрлэх зан үйлийг үйлддэг. Энэ бүхэн нь бүгд бурхны шашны үүднээс үйлдэж буй зан үйлүүд юм. Овоо тахилгын үед сэтэр татах бөгөөд таван өнгийн хив бөсийг тарни тогтоол, даатгал, уншлага бүхий сахиусны хамтаар цагаан хонины юм уу цагаан тэмээний ноосон утсаар жилбэлэн уг малын зөв талын далан дээрх ноосонд эсвээс дэлэнд батлан уяж, тарни шившлэгээр амилуулан сэтэрлэнэ. Түүнчлэн айл өрхүүд сар шинийн дараа сахиус бурхнаа тахин, хишиг даллага авах үед сэтэртэй малынхаа сэтрийг сэргээдэг. Мөн айл өрхүүд зурмал, сийлбэрлэн бүтээж бурхан шүтээнийхээ ойр залсан нь элбэг. Энэ мэт онголон сэтэрлэх мал нь эр, эм аль нь ч байж болох бөгөөд тухайн сахиус шүтээнээс хамаарч өнгө зүсийг нь ихэд чухалчилна. Говийн лха буюу Заягч таван тэнгэрийн үүднээс хөх, бор зүсмийн морь, шар халзан буюу шар түрүүт хонь, улаан ямаа, Улаан сахиус, тангарагтны үүднээс улаан сэрх, Цагаан өвгөний үүднээс цагаан зүсмийн үхрийг Гүнжи лхамо буюу өвлийн охин тэнгэрийн үүднээс тэмээ, Эрлэг Номун хааны өмнөөс хөхвөр хуц Махагала бурхны үүднээс хар бараан зүсмийн морь, Балдан лхам бурхны үүднээс хонгор халиун, толин сартай шарга морь, Долоон бурхны үүднээс шар халзан хонь зэрэг малын хүйс, төрөл зүсийг сонгохдоо урьдаас уламжилж ирсэн ёс заншлыг дагаж мөрддөг...⁴⁰

⁴⁰ Бурханч лам Пүрэвбат, “#МАЛ СЭТЭРЛЭХ #занүйл”, Facebook, 18 Долдугаар сар 2020, <https://www.facebook.com/photo.php?fbid=2780440188895227&id=1784885881784001&set=a.1814605292145393>.

Цугласан эх хэрэглэгдэхүүний хүрээнд дүгнэж үзэхэд ямаа сэтэрлэх зан үйл монголчуудын дунд түгээмэл биш боловч сум бүрд ямаан сэтэртэй айл байгаа тухай мэдээ бий. Харин адуу, хониор сэтэр татуулах хандлага өргөн дэлгэр байна.



Зураг 7. Зураг 03, Ямаан сэтэр, Г. Пүрэвбат, Бурханч лам

Улаан ямааны өвчүүгээр гал тахиx зан үйл

Монголчууд эртнээс гал голомтоо тахиж байсан уламжлалтай. Ердийн хөнхөлд гал ариусгах олон төрлийн ардын мэдлэг, зан дадал бий. Үүний нэг нь улаан ямааны өвчүүгээр гал ариусгах, тахиx ёс юм.

Гал тахиxдаа эхний ээлжинд дөрөлж, зуух, яндангаа цэвэрлэнэ. Түүний дараа аргал, түлээ (мод)-гээ зуухандаа зэрэглэнэ. Дараа нь зэрэглэсэн түлш дээрээ шар тос түрхэж, галаа асаана. Гал ассаны дараа зуухны дөрвөн өнцөгт бага зэрэг шар тос түрхэнэ. Тус шар тос нь үхрийн сүүнээс гаргаж авсан байж болно. Эсвэл бог малын сүүгээр ч айраг хийж шар тос гаргаж авах нь бий. Зуухны дөрвөн өнцөг дээр түрхсэн шар тос дээрээ арц, ганга тэргүүт анхилам үнэртнийг уугиулна. Энэ нь гэрийн доторх

энергийг ариутгах зориулалттай. Тус анхилам үнэрийг үнэртэх төдийд хүний сэтгэл тайвширч, тогтуун дөлгөөн болж байв. Гал дэгжрээд ирэхийн цагт өвчүү, сүүлээ өргөж байна. Үүнийг галын тахилга сэргээх хэмээн нэрлэж байна. Гал сэвтэхээс хамгаалах, галын сэвийг засах үндсэн зорилготой үйлдэл аж...⁴¹

Дээрх өгүүлэмжээс бид “гал сэвтэх” хэмээх үзэл санаанд анхаарал хандуулах шаардлага байна. Учир нь гал сэвтсэнээр айл өрхийн аз, хийморь доройтож, гарз гарах нигууртай хэмээн үздэг. Мөн ажил нь бүтэхгүй байх зэрэг азгүйдэх үйлдлүүд тохиодог хэмээн үзнэ. Тиймээс малчид галаа сэвтүүлэхгүйн төлөө дараах зүйлсээс болгоомжилно. Үүнд, галдаа “бузар” оруулахгүй байх. Бузар хэмээх нь хулгай, чоно хазсан зэрэг малын махыг гэрт оруулах, галд ойртуулахыг цээрлэж байна. Тухайлбал, шүүс хуваахаасаа өмнө гал голомтоо заавал мялаадаг. Богино хавиргаар үйлс бүтэх, бүдэрхийгээр бүх юм бүтэмжтэй сайхан болох, булуу чөмгөөр баяжихыг бэлгэддэг. Энэ бүхэн нь Монголчуудын хувьд гал голомт гэдэг маш чухал ойлголт болохыг нотолно. Тэр эрхэм хүндтэй зүйлээ ямааны өвчүүгээр тахиx, ариусгаж байгаа нь ямаанд хандах монголчуудын хандлага нэн гүн гүнзгий болохыг илтгэнэ.

Галаа ерөөхдөө “...Болж яваг гэж богино хавиргаа... Бүтэж яваг гэж бүдэрхийгээ... Баяжиг гэж булуугаа өргөө...”⁴² гэж ерөөн хэлдэг. Мөн зарим тохиолдолд гал асахгүй бол

Хөгж хөгж

Хөх ямааны өөх өргөнө

Улалз улалз

Улаан ямааны өөх өргөнө

Ас ас

Алаг ямааны өөх өргөнө...⁴³

⁴¹ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁴² М.Пагдадулам, Эмэгтэй, Хэнтий аймгийн Бэрх сумын уугуул, 2022 оны хээрийн судалгааны ажлаар Архангай аймгийн Ихтамир сумын Борт багт хонины гэдэс арилгаж байхдаа хэлснийг тэмдэглэн авав. 2022.07.25

⁴³ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

гэж хэлээд сууж буй хоёр жаахан охинтой бид Өмнөговь аймгийн Номгон суманд судалгааны ажлаар явж байхдаа таарсан юм.

Учрыг нь лавлаж асуухад тэднийх тэмээ, ямаа зэрэг хоёр төрлийн мал малладаг айл байв. Учир нь Номгон сум бол говь нутаг юм. Үхэр, хонь өсгөхөд тохиромжгүй гэнэ. Зуны аагим халуунд хонь өвс идэхгүй хорж зогссоор байгаад олигтой тарга хүч авч чаддаггүй ажээ. Иймд, говь нутгийн малчдын гол амь зуулга, хөрөнгө, амьдралын эх ундраг нь ямаа, тэмээ хоёр гэнэ. Иймд, тэд галаа ямааныхаа өөхөөр мялаадаг аж. Тиймээс гал асаахдаа тийнхүү дуулж байжээ. Хэрхэн мялаадаг тухай асуухад *“... галд түүхий зүйл өргөж болдоггүй гэж ээж хэлсэн. Чанасан өөхнөөсөө л өргөдөг. Энэ жил гантай жил болохоор манайд төдийлөн их өөх байхгүй байна...”*(Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл) хэмээн ярьж байв. Энэ мэт гал тахих, асаах үйл хэрэгтэй холбоотой зан үйлүүд ажиглагдаж байна.

Ямааны бөөрний өөх нь тосон урлалын түүхий эд болох тухай



Зураг 8. Ямааны бөөрний өөхөөр хийсэн тосон урлал, Монголын бурхан шашны төв Гандантэгчинлэн хийдийн лам нар бүтээжээ.

Бурханы шашны таван ухааны нэг урлахуйн ухааны сод бүтээл болох тосон урлалын түүхий эдэнд ямааны бөөрний өөх ордог. Тосон урланд Монголын аж ахуйгаас хамгийн шилдэг төгс зохицол бүхий түүхий эд бол ямааны бөөрний өөх гэнэ. Жилийн дөрвөн улирлын эрс, тэрс уур амьсгалд зохицсон ямааны бөөрний өөхөөр хийсэн тосон балин нь зуны аагим халуун, өвлийн тэсгим хүйтнийг ажрахгүйгээр оршиход төгс зохицсон түүхий эд гэнэ. Энэ тухай Гандантэгчэнлин хийдийн лам Т.Цэрэнпүрэв хэмээснээр,

Хог шороо, түүнээс гарах судас, шөрмөс, хялгас зэргийг урт хугацаанд гар аргаар цэвэрлэдэг. Самнах цэвэрлэнэ. Сойно, түүнийг нүдэж, бяцална. Мухар хутга, иргүй хутгаар алхам тутамдаа үечилж түүж авдаг. Тэгсний үндсэн дээр цэвцийсэн цагаан өөх бий болно. Түүгээр шууд хийхэд хэцүү шүү дээ. Энэ үедээ царцмаг байгаа. Хатуу төлөвийн болоод ирж байгаа. Тийм болохоор аль боох зөөлөн төлөвт оруулахын улд монгол аргаар шар тосноос цохиж гаргасан мааслыг 3/1 хэмжээтэй хольдог. Ийнхүү зөөлөн төлөвт орсны дараа тосон урлалын үндсэн хэрэглэгдэхүүн бэлэн болдог. Балин урлана гэдэг хамгийн амттай шимтэй

бүхнээ бурханд өргөж буй хэрэг юм. Бурхан бүр өөр өөрийн утга агуулга, нарийн хийц бүхий балинтай байдаг. Жишээлбэл Лхам, Чойжоо бурхдын балин гаднаасаа төстэй харагддаг ч жижигхэн чимхлүүр ажил, дагалдах зүйлсээр ялгардаг...⁴⁴

Ийнхүү бурхны шашны бурхны дүрийг бүтээх үйл хэрэгт ямааны бөөрний өөх хэрэглэгдэж байна. Гандантэгчэнлин хийдийн Очирдарь бурхны өмнө 60 жил болсон тосон балин заларч байна. Уг балин нь тусгай орчин шаардахгүйгээр халуунд халж, хүйтэнд хөрж 60 жилийг туулжээ.

Ямааны махны тухай

Ямааны махны уураг хялбар шингэдэг, хүний бие махбодиос шингэнийг хөөх өвөрмөц бүтэцтэй, өөх нь өндөр молекулт, ханасан хүчлүүдээс бүрддэг, царцамтгай, сэрүүн чанартай гэж үздэг тул түүнийг зөвхөн дулааны улиралд хэрэглэх нь илүү тохиромжтой юм. Ямаа зуны эхэн сард цэцэг дэлгэрсэн үед түүгээр хооллож дээд ургамлын биологийн идэвхт бүх бодисыг энэ үед биедээ шингээдэг тул эмчилгээ сувилгааны чанартай бөгөөд ахимаг насны болон сул дорой хүмүүст “Цэцгийн ямааны шөл” уулгадаг нь үүнтэй холбоотой гэнэ. Ямааны махны шимт чанарыг тухай Хүсэхүй хэмээн монгол түшмэлийн 1330 онд хятад хэлээр бичсэн “Идээ ундааны жинхэнэ товч” хэмээх алдарт зохиолд,

амтлаг амтгай, тэгш чанартай бөгөөд хүний бие махбодыг шимжүүлнэ...

Ухнын мах Амтлаг амтгай, тэгш чанартай. Энэ нь таван зүдүүрэл ба долоон гэмийг сэлбэж, савыг бүлээтгэн тамирыг тэтгэнэ. Түүний мах шивтэртэй⁴⁵

хэмээн тэмдэглэжээ.

Дээрх сурвалжийн мэдээнд үндэслэн дүгнэвэл ямааны мах нь шим тэжээл өндөртэй, эрүүл зөв амьдрахад шим тэжээл болж байсан эдүгээ цаг үед ч ард

⁴⁴ Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁴⁵ Хүсэхүй, *Идээ ундааны жинхэнэ товч 1330 он*, Монгол анагаах ухааны сурвалж бичиг судлалын цуврал (Арвай бархан, 2021).

түмний дунд зуны улиралд ямааны махыг өргөн хэрэглэж байна. Ямааны махыг мөн борц болгон зун хаврын улиралд хүнсэнд хэрэглэж байна.

Энэ хэсэгт ямааны үүлдэр угсаа болон ямаатай холбогдох зарим зан үйлийн тухай авч үзлээ. Таван хошуу малтай харьцуулахад ямааг хүйтэн хошуутай мал хэмээн бэлгэдэл талаасаа онцгойлон үзэх зүйл бага байна. Гэвч галын тахилга, мал сэтэрлэх үйл, бурхны шашны тосон урлал зэрэг ямааг оролцуулж буй нь түүнийг үнэлэх үнэлэмж тийм муу биш хэмээн үзэж болмоор байна. Ялангуяа говь нутгийн малчдын хувьд ямаа бол амьдралынх нь гол эх үүсвэр тул хүндлэх, өхөөрдөх байдал ажиглагдаж байв. Ерөнхий утгаараа малчид ямааг бог мал хэмээн хонины нэгэн адил үзэх хандлага байна.

Ноолуурын шууд бус оролцоотой мал аж ахуйн соёлын өвд үзүүлж буй хувь нэмэр

Дээр дурдсанчлан малчид ямаанаас гадна хэд хэдэн төрлийн мал малладаг. Энэ хүрээнд мал аж ахуйн соёлын нөлөөг таван хошуу малын үр ашигт тэгш хуваан авч үзэх нь зөв юм. Тухайлбал, дээр дурдсанчлан хурдан морины хүүхдийн гийнгоо, шинэ гэр барих зан үйл, мал хөнгөлөх зан үйл, гүүний үрс гаргах зан үйл, унага тавих зан үйл, адуу тамгалах зан үйл, мал сэтэрлэх зан үйл, айраг сархдын холбогдолтой зан үйл, шагай харвах зан үйл, шагайгаар наадах зан үйл, монгол нүүдлийн зан үйл, тэмээн поло, тэмээн уралдаан, мал аж ахуйн ач холбогдолтой уриа дуудлага гэх мэт. Эдгээрээс бид Архангай аймгийн онцлог бүхий үхэр тэргээр нүүх нүүдлийн тухай жишээ болгон өгүүлье. Энд бид тус асуудлыг авч үзэж байгаа нь бүдүүлгээр хэлэхэд “ямаа мал малладаг малчин нь ингэж нүүдэг” юм гэсэн санаа юм. Хэдийгээр орчин үед бүх малчин машин тэргээр нүүж буй боловч зарим нэг айл шар хөллөн нүүж байна.

Монголын мал аж ахуй орчин үед тодорхой хэмжээнд өөрчлөлт, хөдөлгөөнд орж байна. Тээвэр эрчимжиж, хөдөлмөр хөнгөвчлөгдөхийн хирээр уламжлалт мал аж ахуйн зарим нэг зүйл хэрэглээнээс шахагдаж байна. Нэгдлийн үед зарим айл машин, трактороор нүүж байсан ч үхэр тэргээр нүүх айлууд байсан. Нэгдэл тарсны дараа үхэр тэргээр нүүх явдал эрчимжсэн аж.

Тэр үед машинтай хүн цөөхөн, мал ханшгүй, малчид мөнгө муутай хэцүү байлаа шүү дээ. Тэр үед л бүгд үхрээ тэргэнд сургаад, үхэр тэргээр нүүж эхэлсэн шүү. Гэвч 2005 оноос шараа зарж ачааны машин авах явдалд гайхамшигтай эрчимжсэн. Азарга багт би л ганцаараа үхэр тэргээр нүүж байх шиг байна. Надаас хойшоо яах юм байгаа юм.⁴⁶

Машинаар нүүх болсон нь хөдөлмөрөө хөнгөвчлөх, техник технологийн дэвшлийг ашиглах үйл явц хэмээн үзэж болохоор байна. Нэгэн цаг үед Ихтамир суманд “хөөг, хөөг”, “дүр, дүр”, “хаа, хаа” гэх авиа цуурайтан сонсогддог байсан байх. Бид энэ хэсэгт шар тэрэг эдэлгээнд сургах тухай, үхэр тэрэгний тухай, үхэр тэргээр нүүх гэсэн гурван зүйлийг хураангуйлан авч үзнэ.

Б.Бямбасүрэнгийн халзан давааны хойд сугт өвөлждөг. Өвөлжөөндөө хүүгийнхээ хамт өвөлжих ба Отгоо гэдэг хүр дүү (эхнэрийнх нь дүү) нь мөн хамт өвөлждөг. Б.Бямбасүрэнгийн хүүгийнхээ хамт шар тэргээр нүүдэг бөгөөд энэ үед бэр нь жаахан сэтгэл дундуур байдаг. Учир нь шар тэргээр нүүхэд хоёр айл, хоёр өдрийг зарцуулдаг. Харин Отгоогийнх хоёр гэрээ нэг өдөр машинаар ачаад нүүчихдэг байна. Мөн машинаар нүүхэд ганцаараа ч гэрээ ачаад нүүж болдгоороо давуу талтай. Гэтэл шар тэргээр нүүхэд хамгийн багадаа хоёр эрэгтэй хүн байх ёстой бөгөөд мөн үхэр тэрэг барьж зогсох нэг хүн бас хэрэгтэй болно. Мөн үхэр тэргээ хөтөлж явах хүн мөн хэрэг болно. Ингээд тооцвол хамгийн багадаа 4 хүн шаардагдана. Онцлог нь Бямбасүрэнгийн хүн хүч ихтэй. Бямбасүрэнгийн эхнэр Өсөхбаяр, түүний хүү, бэр зэргээс гадна нас бие гүйцсэн нэг охин, 18 орчим настай нэг залуу мөн тэднийд амьдардаг. Нийт 6 том хүнтэй. Хажуу айлын Отгоо ах болон түүний хүү бас нүүдэлд туслав. Ингээд нийт 8 том хүний бүрэлдэхүүнтэйгээр өглөө 5 цагаас өдрийн 12 цагийн хооронд нүүдэл хийв. Нүүдэл хоорондын зай 3 км. Бид, өвөлжөөнөөсөө хаваржаанд буусан үхэр тэрэгний нүүдлийг сонирхон судалсан юм. Тэд зуслангаасаа намаржаанд 3 орчим км газар нүүж буудаг. Намаржаанаас 5

⁴⁶ Архангай аймгийн Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

км орчим зам туулан өвөлжөөндөө бууна. Ийнхүү жилдээ 3 удаагийн нийт 10-12 орчим км нүүдэл хийдэг аж...⁴⁷

Б.Бямбасүрэн үхэр тэргээр нүүдэл хийхээс гадна уулнаас түлшнийхээ модыг ачиж авдаг байна. Нас гүйцсэн олон шар нь чоно, нохой гэх мэт араатнаас үхэр сүргийг найдвартай хамгаалдаг ач тустай гэнэ.



Зураг 9. Үхэр тэргээр нүүж буй нь


Шар эдэлгээнд сургах тухай

Б.Бямбасүрэнгийн шар үхэр тэргэнд сургах аргыг дор сийрүүлэн хүргэе.

4 настайгаас нь эр үхэр (сарлаг, хайнаг)-ийг эдэлгээнд сургана. Манайх 7 тэрэгт хөллөх шартай. Эдэлгээнд сургаж буй соёолон 1 шар байна. Мөн

⁴⁷ Архангай аймгийн Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

дахиад 5 эдэлгээнд сургаж буй шар бий. Нийтдээ тэргэнд хөллөх 12 шар манайд байна. Энэ нүүдлээр би 7 тэрэг шарын хамгийн сүүлд нэг соёолон шар тэрэг дагуулж сургаж байна. Ер нь би дагуулж сургах аргыг түлхүү хэрэглэдэг. Шар сургахад хэд хэдэн явцтай. Үүнд, Нэгдүгээрт, төлөв даруу болгох. Энэ үйл явц тугал байхаас эхэлдэг. Эхийн саальд оруулснаар тугал хүнтэй харилцаж сурдаг. Саальд орж, уяулж сурсан тугал ядаж цочоод байх нь бага байдаг. Аливаа зүйлээс үргэх, айх, үргэх нь бага болдог. Хоёрт, хамарт сургах-хамрын мэдүүлэх. “Дөргүй шар” дийлдэхгүй шүү дээ. Эмнэг шарыг барьж аваад хамрын нүхэлж дөрлөнө. Үхэр хамартаа их уян амьтан. Дөрлөчихсөн байхад сайхан шүү дээ. Хамрын сэтлэхээс болгоомжлох ёстой. Хамар сэтэрлэчихвэл тэгээд л эдэлгээнд сургах өнгөрч байх нь тэр. Дөрлөсний дараа номхон шарт холбож хамарт нь дасгадаг. Хамарт дассаны дараа нүүдэл дагуулж сургана. Өөрөөр хэлбэл, бидний өнөөдрийн нүүдэлд энэ соёолон шар тэрэг дагаж сурч байгаа юм. Нүүдэл дагаж сурсны дараа тэрэгт хөллөж сургана. Дөнгөж тэрэгт хөллөсөн шарыг нүүдлийн хамгийн хойд талд хөллөдөг. 4 тэргийг нэг цуваагаар явахад энэ нутагт тохиромжтой байна. Тэгш тал газарт бол хэдийг ч ар араас л холбосон болно оо. Эдэлгээнд сургах шарыг сонгохдоо төлөв даруугаас нь сонгодог. Их цочимтгой шар эдэлгээнд сурсан ч гэмтэй. Хүн бэртээх, ачаа, тэрэг эвдэх магадлалтай. Хамарт нь буйг чөрх (дөр), толгойнд хийснийг нь ногт, урт уяаг нь цулбуур хэмээн нэрлэнэ.



Зураг 10. Үхэр тэрэгний бүрэлдэхүүн хэсэг

Үхэр тэрэгний тухай

Тэргийг ямар мал хөллөснөөр нь үхэр, морь, тэмээн тэрэг гэж ялгадаг. Хийх эдээр нь хар, хусан, төмөр хэмээн нэрлэнэ. Хийцээр нь зүймэл, матмал, мөөртэй гэж хэд хэд ангилдаг. Тэргэнд арлын гуя хосоор, арлын чихний чагт хосоор, данз буюу хөндлөвч 8-9 ширхэг, мөөр зургаа, тэрэгний голын чихний чагт, голоороо эргэдэг хусан бул, цон хосоор, хусан хигээс, модон мөөр нэг нэг байна.

Арлын гуяны урт нь 4 м 23 см, өргөн нь 10 см, хоёр гуяа хоорондын зай нь 88 см, үхэрт хөллөх хэсгээрээ 88 см, хойд талаараа 90 см зайтай.

Хөндлөвч (данз) нь нийт 8 ш байна. Нэг хөндлөвчний урт 90 см, хөндлөвчний зузаан нь 2,5 см, өргөн нь голоороо 9 см, углуургадаа өргөн нь 6,5 см, зузаан нь 2,3см, углуургын урт 9,5 см. Хөндлөвч хоорондын зай 18 см байна.

1



Тэрэгний
чих

Тэрэгний чих нь хоёр гуяны урд үзүүрт буюу үхэрт хөллөх хэсэгт нэг нэг чих байдаг. Үхэрт хөллөсөн бугалгын уяаг бэхлэх үүрэгтэй. Чихний урт 20 см, өргөн нь 4 см, зузаан нь 2,5 см. Хажуу талд нь чихийг гуятай бэхэлж чангалсан жижиг шаантаг буй. Уг шаантгийн хэмжээ нь голоороо 0,8 см, хоёр хажуу талаараа 0,2 см, өргөн нь 2,5 см.

2



Тэрэгний
яшиг

Тэрэгний арлыг цонотой бэхлэх үүргийг яшиг гүйцэтгэнэ. Яшигны дээд үзүүрийн орой нь 8 тал маягтай, өргөн нь 5 см, зузаан нь 3 см. Яшигны доод үзүүрийн өргөн 5 см, зузаан нь 2 см. Яшигны дунд биеийн өргөн дээд хэсгээрээ 9 см өргөн, зузаан нь 3 см, дунд биеийн өргөн доод хэсгээрээ 7 см. Яшигны дээд үзүүрээс доод үзүүр хүртэлх урт нь 38 см. Тэрэгний аралаас дээшээ гарсан яшигны өндөр 14 см тус тус хэмжээтэй байна.

3 Үүнийг “цоно” гэдэг голоороо эргэдэг булыг тэрэгний аралтай холбож буй

хэсэг. Нийт урт нь 100 см, цоногийн нь хоёр үзүүрийн өргөн нь 11 см, зузаан нь 8 см, цоногийн дунд биеийн өргөн нь 18 см, зузаан нь 8 см. Тэрэг нь хос цонотой. Цоногийн хоёр тал нэг нэг яшиг, нийт 4 яшигаар бэхэлдэг.



Тэрэгний дугуй: тархи, мөөр, гол, пайшин гэсэн үндсэн дөрвөн эд ангитай. Тэрэгний гол нь дугуйтайгаа хамт эргэдэг. Дугуйны нийт өндөр нь 78 см.



Тархи

Мөөр

Тэрэгний гол

Пайшин

Зураг 11. Тэрэгний дугуй

Дугуйны тархины зузаан нь 9,5 см, хэсгийн зузаан нь 4,75 см, өргөн нь 20 см бөгөөд хоёр тархийг углуургадаж угсардаг байна.

Мөөр: мөөрийн өргөн нь 10 см, урт нь 37 см, зузаан нь 10 см.



Зураг 12. Тэрэгний гол

Пайшин: уг эд нь тэрэгний гол, дугуй хоёрыг бэхлэх үүрэгтэй эд. Голны хоёр талаас хавчиж байдаг. Пайшигний дээд талын өргөн нь 7 см, зузаан нь 4 см, дунд талын өргөн 6,8 см, зузаан нь 3 см. Пайшигны араас голыг “чагтан чих”-ээр чангалдаг байна.

Тэрэгний гол: зузаан нь 13 см, урт нь 114 см, цоно эргэх хэсгээрээ 10 см зузаан, Пингүү нь бүдүүн хэсгээрээ 16,5 см, нарийн хэсгээрээ 14 см тус тус хэмжээтэй байна.

Үхэр тэрэгний хэрэглээ: Бидний дээр өгүүлж буй тэрэг нь Бямбасүрэн ахынд ашиглагдаж буй 7 тэрэгний нэг нь юм. Бусад тэрэг нь бүгд хоорондоо ижил хэмжээтэй байв. Азарга багт ах Бат-эрдэнэ үхэр тэрэг хийж чадна хэмээн ярьж байв. Энэ бүс нутагт үхэр тэрэгний хэрэглээ хумигдаж, айл айлын өрхний оосорт тэрэгний дугуй уяатай эсвэл өвөлжөөний газар эвдэрхий ганц нэг тэрэг байх, түүнээс нохойгоо уячихсан үзэгдэх нь цөөнгүй аж. Зарим айлууд үхэр тэргээ эргээд сэргээх оролдлого хийж байв.

Үхэр тэрэг ачих тухай

Тэрэгт хөллөх шараа хоёр гурван хоног уяж хөнгөрүүлж байгаад тэргэнд хөллөдөг (н.Бямбасүрэн). Эхний тэргэнд гэрийн яс мод буюу хаалга, хана, унь, тооно, багана гэх мэтийг. Хоёр, гуравдах тэргэнд авдар, дөрөв, тав дахь тэргэнд ор шүүгээ гэх мэт модон эдлэл, зургаа долоо дох тэргэнд сав суулга гэх мэт гэрийн бусад эдлэл ачдаг. Сүүлийн тэргэнд нохойныхоо идүүрийг ачиж байв.

Нүүдэл хийхдээ өдрийн сайныг үзэж, билигтэй сайн өдөр нүүнэ (Б.Өсөхбаяр). Тэргэнд хөллөх шараа барьж, уяна. Үүнийг “хөнгөрүүлэх” хэмээн нэрлэдэг (н.Бямбасүрэн). Нүүдэл эхлэхээс өмнө хот хэвтэртээ арцаар “сан” тавина. Өглөө цагаан гэгээ татахын алдад босож цайгаа чанаад, идээгээ идэж, тэргээ нэг нэгээр авч ирж эгнүүлж байгаад ачна. Тэрэгнийхээ арлыг туураг дээвэр гэх мэтээр бүтээж илүү гаргана. Илүү гаргасан зүйлсээ ачаагаа ороож татаж баглах зорилготой. Гэрийн яс мод нэг тэргэндээ багтана. Тэр тэрэг бүр нэг ижил хэмжээтэй. Авдар, шүүгээ ч мөн адил. Тэрэгний зай нь манай бүх авдар таардаг. Таардаг гэдэг нь тэрэгний арлаа эсгийгээр цуглаад авдар ачихад хөдөлгөөнгүй ороод таардаг. Тэргээ ачаалж дуусаад цайгаа уучихаад жаахан амарч байгаад шараа хөтөлж ирээд тэргэндээ хөллөөд хөдөлнө. Үхрийг хөдөлгөхдөө “хөөг, хөөг”, гэдэг. Харин зогсоохдоо “дүр, дүр” хэмээн хэлнэ. Үхэр их ухаантай амьтан “дүр, дүр” гэхэд л зогсчихно шүү дээ. Тэрэгний нүүдлийн хамгийн түрүүнд яваа үхрийг “Тэргүү” гэдэг. Тус үхэр хамгийн номхон, аажуухан л алхдаг үхэр байх ёстой. “Тэргүү”-гийн араас шаруудаа арлаас нь холбочихдог. Тал газар бол хэдэн ч шар тэрэг холбож болно. Манайх жаахан бартаатай болохоор дөрвөөр нэг, гурван шар тэрэг нэг нүүдэл дагаж буй шартай дөрвөөр нэг болгож, хоёр тусад нь холбож байна.⁴⁸

Бямбасүрэн ахын нүүдлийг ажиглаж байхад олон шар тэргээр нүүж буй байдал, “хөөг, хөөг” хэмээн нэгэн зэрэг дуугаар хөдөлгөх байдал үнэнхүү сүртэй, сайхан санагдаж байв. Буу үүрсэн морьтой хүн шар тэргээ хөтлөөд явах нь үнэнхүү сүртэй

⁴⁸ Архангай аймгийн Ихтамир суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

байв. Монголын тал нутгийн чимэг болсон шар тэргээр нүүх нүүдлийн чимээ алсарсаар байна. Үхэр тэргээр нүүх үйл явц ховордсоноор тэрэгтэй холбоотой үг хэллэг, нэрлэлтийг мэддэг хүн хуруу дарам цөөхөн болж байна.

Ноолуур бэлтгэх

Ямааны ноолуур бэлтгэхэд дараах зүйлсийг урьдчилан бэлтгэсэн байна. Үүнд, Нэгт, Ямаа самнах талбарт хог шорооноос хамгаалсан дэвсгэр, Хоёрт, ямааны хөл боох уяа, Гуравт, ямааны сам, Дөрөвт, ноолуур хийх шуудай зэргийг хангадаг байна. Мөн нэмэлтээр ямааны ямар нэг шарх, сорив тэргүүтэнд түрхэх тос, түрхлэг, эм тариа зэргийг бэлтгэж болно. Ямаа самнах нь ямааны бүтэнд биед үзлэг хийх боломж олгодог тул өвөр туурай, шүд, дэлэн зэрэгт үзлэг хийдэг байна. Хэрэв ямаа дэлэн алдсан, хөгширсөн, ямар нэг эмгэгтэй нь илэрвэл тэмдэглэж, нүдэлдэг аж.

Нэг ямааг 30 орчим минут самнаж байна. Энэ хугацаанд ноолуур самнахаас гадна тухайн ямааны ноолуурын гарц, шүд, өвөр туурай зэргийг сайн ажиглах боломж бүрддэг байна. Өнөөдөр бид, нэг хөх ямааны өвөр хэт шовх, хурц байсан тул засаж янзлав. Мөн бүдүүн саарал сэрхийн нүд өвджээ. Түүний нүдэнд амицилин (амоксициллин) нунтаглаж хийлээ. Малын өвдсөн нүдэнд амицилин хийхээр эдгэдэг гэнэ. Дорж гуай ингэж ярьж байна. Хэрэв эвэр нь хурц байвал тайрч болно. Зарим ямааны туурай муруй ургасан байдаг. Түүнийг засаж болно. Эсвэл дэлэнд нь айсан (үрэвссэн), шүд нь элэгдэж, дарагдсан байвал анзаарч тэмдэглэх хэрэгтэй. ингэж тэмдэглэсэн малаа намар жаазалдаг юм. Ингэж үзвэл, ямаа самнах гэдэг бол нэг талаар малдаа хийж буй бүрэн үзлэг болдог аж.⁴⁹

Дээрх тэмдэглэлээс үзэхэд ямаа самнах нь зөвхөн ноолуур авахын төлөө ажиллагаа бус ямааны бүтэн биед хийх үзлэг хэмээн нэрлэж болмоор байна. Ер нь малчид гэдэг бол малдаа айхтар гярхай хүмүүс шүү. Иймд, малчин хүн өөрөө ямаагаа самнах үйл хэрэгт заавал оролцох нь чухал байдаг байна.

⁴⁹ Хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Ямаа самнах хугацаа

Монголчууд бүс нутгийн онцлогоос хамаарч, ямааны ноолуурыг харилцан адилгүй цаг үед хөөрөх нь бий. Тухайлбал, говийн бүсийн ямааны ноолуур гуравдугаар сарын 30 орчмоос эхэлж, дөрөвдүгээр сарын дунд хүртэл үргэлжилнэ. Энэ хугацаанд ямаа самнах нь тохиромжтой ч жил бүрийн өнгө харилцан адилгүй өөр өөр байх явдал байна. Гиймээс уламжлалт байгаль шинжих арга ухааныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж буй цаг агаарын мэдээтэй уялдуулан ямаа самнах хугацааг малчид тодорхойлж байна.

Цагийн байдлыг харж байгаад ямаагаа самнана. Хаврын сар яаж гарахаас бас их зүйл шалтгаална. Ямаа самнахад анхаарах хамгийн гол зүйл бол ямааны хөл боох зүйл уяа юм. Одоо хүмүүс янз бүрийн зүйлээр боогоод байна. Угтаа хонины ноос, тэмээний бие ноосоор томсон уяа л хөлд нь их эвтэй байдаг юм. Эсвэл муу хувцас (цамц, өмд г.м)-ыг өргөн сайхан хайчилж уяа тааруулж болно. Нарийн мяндсаар л уяж болохгүй. Хөл нь гэмтчихдэг юм. Малчдад хөлийн уяа бий л дээ. Жил бүр хэрэглэх юм чинь хадгалчихдаг юм...⁵⁰

Дээр дурдсанчлан ямаа самнахад хөлийн боолтоос гадна хамгийн чухал зүйл бол ямаа самнах талбар бэлтгэх явдал юм. Манайх (судлаач) Адсага (үхэр адууны дэлгэж хатаасан шир) дэвсээд ямаа самнадаг байсан. Тэр үед хэд хэдэн давуу талтай байлаа. Нэгт, Ямаа самнаж буй хүн хавар чийгтдэггүй. Мөн доороос нухдаггүй. Хоёрт, Адсагат хог, шороо наалддаггүй. Гуравт, самнаж буй ямааны шээвэл шээс нь шингэхгүйгээр дагаж урсаад газар луу асгарчихдаг байв. Дөрөв, хуниралдаад байдаггүй. Тавд, ямааны өвөрт барагтай бол цоордоггүй гэх мэт давуу талууд ажиглагддаг байсан. Харин хээрийн судалгааны ажлаар цугласан мэдээнээс үзэхэд үхэр, адууны шир дэвсэж самнах байдал түгээмэл биш байна. Харин хог шороо бага татах ямар нэг зүйлс дэвсэж самнах нь түгээмэл аж.

⁵⁰ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Ямааны сам

Ямааг самнахдаа стандартын шаардлага хангасан самыг хэрэглэх нь тухайн малын биед элдэв гэмтэл учруулдаггүй, самнагчийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх зэрэг эерэг нөлөөтэй. Ноолуурыг бүрэн авах, хялгас багатай бэлтгэх нь самнаас хамааралтай. Ямаа самнахдаа 3 төрлийн сам хэрэглэнэ.

Хүснэгт 4. Ямааны самны төрөл

| № | Самны төрөл | Үүрэг |
|---|--|---|
| 1 | Даахины сам (хол шүдтэй) шүд хоорондын зай 6-7 мм | Ямааны ноолуурыг эхлээд хол шүдтэй самаар самнаж хялгасны орооцолдоог гаргаж, түүн дэх гаднын бохирдуулагч зүйлсийг цэвэрлэнэ. |
| 2 | Ноолуурын сам (ойр шүдтэй) шүд хоорондын зай 4-5 мм | Эхлээд хүзүү, дараа нь цээж, дал, биеийн хажуу хойд хэсгийг үсний ургалтын чигийн дагуу дээрээс нь доош, нуруунаас гэдэс хэвлий чиглэл рүү ойр шүдтэй самаар самнана. |
| 3 | Шүүр сам (шигүү шүдтэй) шүд хоорондын зай 2-3 мм | Шигүү шүдтэй самаар шанаа, дагз, эвэр, чих орчмын ноолуурыг самнана. |



Зураг 13. Ноолуурын сам

Ноолуурын самны шүд хоорондын зайг чүдэнзний модоор барагцаалж болно.

Хол шүдтэй буюу стандартад зааснаар даахины сам шүд хоорондын зай нь 3 чүдэнзний мод, ойр шүдтэй буюу стандартад зааснаар ноолуурын сам шүд хоорондын зай нь 2 чүдэнзний мод, шигүү шүдтэй буюу стандартад зааснаар шүүр сам шүд хоорондын зай нь 2 чүдэнзний мод...⁵¹

Ямаа самнах

Ямаа болон бусад малын ноос, ноолуур, хөөврийг хэдий хугацаанд авч ашиглах тухай саналууд эртнээс гарч байжээ. Тухайлбал, 1931 онд монгол бичгээр гарсан “Ухуулагч нарын өврийн дэвтэр”-т мал хяргах тухай тусгайлан оруулж, зааварлажээ. Түүнээс хойш өнөөг хүртэл малын үс ноос, тэр дундаа ноолуурыг зөв самнаж авах, ялгах, ангилах, тээвэрлэх үйл явцыг судалж, сүүлийн үед техникийн дэвшлийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн болгох үедээ ямар ямар технологийг хэрэглэж болох талаар илүүтэй туршилт судалгааны ажил хийгдэж байна.

Ноолуурыг хэрхэн самнаж авах ажлыг 1930-аад оноос эхлэн малчин ардуудад гэлтгүй төр засгийн эрх баригчид, хүүхэд багачуудад заан сургаж, ингэхдээ ноос, ноолуурыг өчүүхэн хэмжээгээр ч үнэгүйдүүлэлгүй, бүрэн дүүрэн авч ашиглах талаар олон ажил явуулж байжээ. 1940-өөд он гарахад Намын Төв Хорооны өндөр албан тушаалтнууд хөдөө орон нутгаар явж, өөрсдийн биеэр ямаа самнаж үзүүлж байсны дотор Ю. Цэдэнбал багтаж, Хэнтий аймагт ажилласан тухай баримт үлджээ. Ямааны сам болон шуудай сав бэлтгэх ажилд тухайн үеийн төмрийн заводууд, засан хүмүүжүүлэх газруудыг хамруулдаг байсан байна. Ямаа самнах самны хэмжээ, материал зэргийг чухалчилж, шуудайг том хийх тусам сайн гэж үздэг байжээ. Жишээлбэл, ноосыг 70 кг гурилын шуудайд заавар зөвлөмжийн дагуу чихэж савлахад 90 кг болох ёстой гэсэн зааврыг өгдөг байв. Энэ нь малчдад гарын арын арьс ханзрахаас эхлээд хэцүү байсныг бичсэн байдаг.

Ноос, ноолуурын ашиг шимийг авах тухай Ж. Самбуу, Д. Шаарийбуу, Х. Чойжилжав, Ц. Сахьяа, Г. Маналжав нар, Ч. Сонгино, Н. Эрдэнэцогт нар бүтээлүүддээ дурджээ.⁵² Х. Чойжилжавын бичсэнээр 1978 онд ямааны ноолуурыг

⁵¹ Ё.Загдсүрэн et al., *Ямаачдын өврийн ном* (Улаанбаатар, 2000).

⁵² Ж.Самбуу, *Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга* (Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр, 1945); Х. Чойжилжав, *Малын үс ноосыг зөв авъя. Альбом* (Улаанбаатар: Д.

35-60, 60-80, 80-аас дээш хувийн ноолуур гэж 3 ангилан, мөн дээр нь ямааны хялгас, ямааны сүүл, сахал зэргийг үнэлэн авдаг (хуудас 9) байж.

Малын түүхий эдийг авахдаа олон төрлийн гэмтэл, буруу ажиллагааны хохирол учирч байна гэж Ц. Сахьяа, Г. Маналжав нар үзжээ. Жишээ нь, ноолуур авах замыг хөнгөн цагааны хайлшаар цутгаж хийсэн иштэй байх бөгөөд самны шүдийг зэврэлтээс хамгаалсан бүрхүүлтэй, зориулалтаар нь том, жижиг гэж 2 ангилаад, шүдний үзүүр $3 \times 45^\circ$ -аар налуу ирлэсэн байна (хуудас 84) гэжээ. Ямааны сам, ноос, ноолуурын сав шуудайг бэлтгэн нийлүүлэх талаар гэвэл, 1942 онд ямааны сам 73055, хөөврийн сам 5338, сав шуудай 1.973.015 ширхгийг Хоршоодын төв холбоо бэлтгэжээ. Эдгээрийг Төмрийн завод, засан хүмүүжүүлэх газруудад бэлтгэж байв.

Д. Эрдэнэбатын бичсэнээр, ноос, ноолуур нь социалист эдийн засгийн чухал хэрэгцээт бүтээгдэхүүн тул НТХ-ны дарга, эрхлэгч нар өөрсдийн биеэр ямаа самнах, хонь ноослохыг үлгэрлэн үзүүлдэг байжээ.⁵³ Хэнтий аймгийн Батноров суманд НТХ-ны ЕНБД Ю. Цэдэнбал 1941 оны 5 дугаар сард өөрийн биеэр үзүүлэх сургууль зааж, тус сумын Дондог гэдэг айлаас ямаа авчруулан өөрөө самнаж, зөвлөгөө өгсөн явдал бол малын ноосыг нэг ч грамм гээхгүйгээр цуглуулан авах зорилгын үүднээс юм.

Мал өвөлжилтийн ажлыг зохион байгуулах улсын онцгой комиссоос 1978 онд эрхлэн гаргасан “Малчдын санамж бичиг”-т малын үс ноосыг авах талаар дурдсанаас “Ямааны ноолуурыг хөөрсөн үеэс эхлэн самнана. Эхлээд чихний ар, дагз, шанаа, хүзүү, бөөрний ноолуур хөөрөх ба хөөрөхгүй үед хялгас холбогыг авч, нэг удаа үснийх нь үзүүрийг самнаад орхивол цаашид хурдан хөөрч, хаягдалгүй авч болдог” (хуудас 240) хэмээн сануулжээ.

1989 онд ЕБС-ийн сурагчдад зориулж хэвлэсэн “Мал аж ахуйн үндэс” 6 дугаар ангийн сурах бичигт гэхэд ямааны ноолуур болон түүний хялгасыг ялгах тухай

Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинат, 1978); Ц. Сахьяа & Г. Маналжав, *Түүхий эд бэлтгэлийн ажиллагаа: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж* (Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1985); Ч.Сонгино, *Монголын бэлчээрийн мал маллагааны уламжлал* (Улаанбаатар: Соёмбо, 1991); Н. Эрдэнэцогт, *Монголын нүүдлийн мал аж ахуй* (Улаанбаатар: Урлах эрдэм, 1998).

⁵³ Д. Эрдэнэбат, *Монгол улсын эдийн засаг дэлхийн хоёрдугаар дайны үед* (Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2018).

зааж, “Самнахын өмнө урт хялгасны ээдрээг гаргавал ноолуурт хялгас холилдох нь бага болно. Нэг гараар хялгасыг ярж, самтай гараар үсний ширхэг дагуу зөөлөн, тууш татаж самнана. Сам дүүрэхээр ноолуурыг авч, бэлтгэсэн савандаа хийнэ. Гэхдээ ноолуурын хялгасыг саманд байхад нь урьдчилан ялгах ашигтай” (хуудас 82) гэхчилэн бичсэн нь мал аж ахуйд туслагч хүүхэд багачуудыг багаас нь малын ашиг шимийг зөв, үр дүнтэй авахад анхаарч байсны илрэл байна. ямаа самнах аргачлалыг дараах байдлаар тэмдэглэжээ.

Самыг барихдаа баруун гараараа самны бариулаас атгаж эрхий хуруугаараа самны шүдний уг дээр дарна. Сам барьсан гарын тохой нь нэлээд доош, үзүүр нь самтайгаа хамт дээшээ чиглэсэн маягтай байх нь тохиромжтой...⁵⁴

Ноолуурыг малчид 50 кг-ын гурилын уутанд голдуу савлаж байна.

Ноолуурын салбарт “ченж” нар худалдан борлуулах үйл ажиллагаа явуулж байсан бол дахиад нэг шинэ үйлчилгээ нэмэгдсэн нь “ямаа самнах үйлчилгээ” юм. Нутгийнхан “халтуурчид” хэмээн нэрлэнэ. Хөлсний ажилчид авч ямаагаа самнуулах дараах хэд хэдэн шалтгаан байна.

Хавар бүх малын үе сулдаж, хүч тэнхээ муудсан байдаг. Иймд, байнга анхаарал хандуулж байх шаардлага гардаг. Үе нь сулдсан хаврын шар усанд унаж үхэх магадлалтай. Мөн зарим тамир тэнхээ сул мал хэвтчихээд босож чаддаггүй. Эрс газраас гулсаж хөлөө бэртээх магадлалтай. Иймд, байнга гярхай анхаарч байх шаардлагатай болдог.

Мал төллөх, шинэ төл хүлээж авах үе буюу хамгийн чухал, ачаалалтай цаг үе юм.

Хаврын цас, мөс хайлж байх үе тул мал ус, мөсөнд унаж үхэх аюултай.

Хараа, хяналтгүй орхисон төл мал, төллөж буй малын нүдийг хэрээ, шаазгай зэрэг шувуу нүдийг нь тоншдог бол зарим уулархаг нутагт бүргэд мэт жигүүртэн шувуу төл мал шүүрч бэртээх аюултай. Харин үнэг, чоно мэт араатан нялх төл барьж, идэх аюултай.

Ямаа самнах үеэр малчдын хүүхдүүд хичээлтэй байдаг. Иймд, ямаа самнах оролцож чаддаггүй.

⁵⁴ Д. Чойжил, “Ноос судлал” (Улаанбаатар, 2014).

Дээрх шалтгаануудын улмаас гэр бүлийн малчдаас 1-2 хүн заавал малдаа өндөр сонор сэрэмжтэйгээр анхаарах болдог. Ийнхүү оргил ачааллын үе тул богино хугацаанд олны хүчээр ямаагаа самнах шаардлага гардаг. Ноолуурын үеэр хөдөө нутагт бүх хүн завгүй болдог. Иймд, ямаа нэг бүрийг тодорхой тарифаар самнуулах болдог аж. Иймд, суурин газраас залуучууд нэг ямааг 6000-10000 төгрөгийн хөлсөөр самнаж байна. Үүнийг “ноолуурын халтуур” хэмээн нэрлэх болжээ. Тухайлбал, Архангай аймгийн Ихтамир сумын Борт багийн малчин Наранцэцэгийн 700 гаруй бог, 200 гаруй бодтой. Тэднийх 300 орчим ямаатай бөгөөд 96 орчим кг ноолуур авчжээ. Энэ айлын ямааны гарц дунджаар 300 орчим грамм байна. Тус өрх 300 ямааныхаа 50 хувийг хөлсөлж самнуулсан гэж бодъё! Энэ тохиолдолд 2022 оны байдлаар Их тамир суманд нэг ямааг 10,000 төгрөгөөр самнаж байжээ. Иймд ямаа самнах зардалд Наранцэцэгийнх 1,500,000 төгрөг зарцуулсан байна. Тэрээр 96 кг ноолуурыг 50%-ийг нь 135,000 төгрөгөөр, 25 %-ийг нь 95,000 төгрөгөөр, 25 %-ийн 90,000 төгрөгөөр тус тус арилжжээ. Дээрх өрх айл ноолуурын орлого нь 11 орчим сая төгрөг болж байна. Харин ямаа самнах зардалд 1500,000 орчим мянган төгрөг зарцуулжээ. Хэрэв бүх ямаагаа хөлсөөр самнуулсан гэж үзвэл 3,000,000 төгрөгийг зөвхөн ноолуур бэлтгэхэд зарцуулах байж. Гэвч тэд талыг нь л хөлсөөр самнуулсан байна. Энэ тохиолдолд яагаад бүгдийг нь хөлсөөр самнуулж болсонгүй вэ гэх асуудал гарч ирнэ. Ямаа самнах залуучууд хөдөө орон нутагт түгээмэл биш. Ихэнх тохиолдолд саахалт, хөрш айлынхныг гуйж самнуулах тохиолдол бүхий л газарт элбэг байна. Мөн дээр өгүүлсэнчлэн, Монголын хавар бол хүйтэн. Бас мал төллөх цаг учраас хүн бүр завгүй байх энгийн үзэгдэл болдог. Ийм үед малын ажилд туслах хүн гэдэг ёстой өдрийн од мэт ховор болдог. Дээр нь ямаа самнахад арга зүй туршлага хэрэгтэй тул хүн бүр хийгээд байх боломж ховор юм. Малчдын ярьж байгаар ямаа самнах амархан ажил биш ажээ.



Зураг 14. Ноолуур савлаж, тээвэрлэж буй байдал, 2022 он.



Зураг 15. Ноолуур ченжид тушаасан байдал, 2022 он.

Дээр дурдсанчлан сүүлийн жилүүдэд суурин газрын залуучууд хөлсөөр ямаа самнахаар хэсэг хэсгээрээ “бүлэг” болж самнаж буй гэнэ. Ийм залуучууд нэг айлаас нөгөөд уригдан самнадаг гэнэ. Гэвч ихэнх тохиолдолд малчид гол ус, хөрш, хот айлаар ээлжлэн нэг нэгнийдээ ямаа самнах нь түгээмэл байна. Ямаа самнах үед хоол, цайгаар хангах үйлчилгээг тухайн өрх хариуцдаг аж. Ийнхүү ноолуурын салбар нэг шинэ үйлчилгээ бий болж байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйд ямаа самнах төрөлжсөн үйлчилгээ бий болох магадлал байна.

Ноолуурын ченж

Монголын хөдөө аж ахуйн салбарт Ченж хэмээх нэр нэн танил ойлголт юм. Ченжүүдэд Монголчууд нийтээрээ таагүй ханддаг. Гэвч сумын төвийн амьдралд Ченж нарын оролцоо өндөр байсаар байна. Малчны хотноос мал аж ахуйн түүхий эд ченж дамжихгүйгээр хэрэглэгчийн гарт эсвэл үйлдвэрт хүрвэл бүх зүйл сайхан болно гэх ойлголт нийтлэг байна. Гэвч, “ченж” дамжлагагүй түүхий эдийн худалдаа гэж Монголд байхгүй байна. Тэд машиныг ч бас “ченж” дамжуулалгүй өөрсдөө импортолбол сайн машин хямд үнээр авч чадна л гэж ихэнх нь итгэдэг. Гэвч ченжүүд эдийн засгийн эргэлтийн ихэнхийг нь нуруундаа үүрч, зах зээл, бизнесүүдийнхээ залуур нь болж, төрийн зохицуулалт, түшмэлийн гар хөлөөс хол “үл үзэгдэх гарын”-ын дүрмээр өсөж, хөгжсөөр, үлэмж том үүргийг эдийн засагт гүйцэтгэсээр явна. Бүгдийг өөрөө хийгээд, малчны хотноос малаа ачаад 22-ын товчоонд арьс ширээ тушаагаад, дэнжийн мянгад махаа өгч чадвал малчинд ч ашиг өндөртэй, хэрэглэгчид үнэ багатай байна гэж малчин ч, иргэд ч, төр засаг ч тайлбарлаж байна. Гэвч бодит байдалд асуудал өөр байна. Тухайлбал, ноолуурын зах зээлд хэдийгээр үйлдвэр, хоршоо гэх мэт оролцогч нар байгаа боловч ченж буюу зуучлагч нар оршоор байна. Энэ нь тэдний менежментийн орон зай, бодит хэрэгцээ зах зээлд байгаагийнх юм. Хээрийн судалгааны цугласан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан тоймлож үзэхэд ченжтэй холбоотой хоёр төрлийн ойлголт байна. Нэгт, Ченж нар ноолуурын үнийг байнга савлуулж, дундаас нь ашиг хүртдэг гэх ойлголт байна. Хоёрт, Ченжийн нугалааг арилгавал ноолуурын үнэ тогтвортой, илүү үнэтэй болно гэх ойлголт юм. Дээрх хоёр ойлголт нь хоёулаа ченж баялаг бүтээдэггүй хэмээн шүүмжлэх байр суурьтай байна.

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй малчид үйлдвэр, зах зээлтэйгээ шууд харилцах бололцоо харьцангуй бага. Иймд, малчдын зах зээлтэй холбогдох хэрэгцээг хангаж өгч буй менежер бол Ченж юм. Тиймээс тэдний хэрэгцээ шаардлага ямагт байсаар байх бололтой. Ер нь малчид зах зээлд жилд дээд тал нь 300-400 орчим кг ноолуур тушааж буй бол дундаж 80 орчим кг ноолуур байна. Зарим малчид харьцангуй бага ноолуур зах зээлд нийлүүлэх нь бий. Энэ тохиолдолд малчин нэг бүр үйлдвэртэй харьцах бололцоогүй. Мөн малчид өөрсдөө ноолуурын зах зээлд шууд оролцож, төвлөрсөн зохион байгуулалтад орох бололцоо хязгаарлагдмал байна. Учир нь, тэд багадаа 3-4 төрлийн мал адгуулах тул бүх анхаарлаа мал сүрэгтээ хандуулдаг. Энэ тохиолдолд малчны хотноос өсөж өндийсөн ченж нар ноолуурын зах зээлд оролцож байгаа нь зах зээлийн бодит хэрэгцээнээс үүдсэн жам ёсны зүйл хэмээн үзэж болмоор байна. Ихэнх ченж цөөхөн тооны малтай байх нь түгээмэл байна. Бид доор Архангай аймгийн төвийн нэгэн ченжийн амьдралын түүхийг товч авч үзье!

Түүнийг Т.Долгоржав гэдэг. Тэрээр Архангай аймгийн Эрдэнэбулган суманд төрж өссөн. Түүний аав малчин хүн байжээ. Тэрээр цэрэгт явж ирээд ажил олдохгүй байсан тул 100,000 төгрөгөөр арьс ширний худалдаа эрхэлж эхэлсэн байна. Тухайн үед машин унаагүй байсан тул арьсаа үүрээд харьдаг байжээ. Ийнхүү бага багаар хуримтлуулсан мөнгөөрөө ченжийн ажил тасралтгүй хийсээр 22 жилийг ардаа үджээ. Тэрээр малчдын зах зээлийн тухай ийнхүү ярьж байна.

Төр засгаас ченж нарыг дэмжихгүй байгаа. Тэдний санаа нь малчид, үйлдвэрлэгчдийг холбох. Бид нарыг шахах санаатай. Ер нь малчид үйлдвэрлэгчтэй шууд холбогдох боломжгүй юм байна лээ. Заавал тохирсон зүйлийг нь тохирсон үнээр нь авч өгдөг зуучлагч хэрэг болдог. Нэг үйлдвэр малчдын сайн, муу зүйлийг нэг ижил үнээр авна гэж байхгүй шүү дээ. Малчид ч тэр үйлдвэртэй байнга харьцах боломжгүй. Ямар ч үед завсрын ченж устахгүй юм байна лээ. Энийг хүмүүс ойлгохгүй

л яваад байна. Хөдөө орон нутагт ганц бэлэн мөнгө авч ирж байгаа хүмүүс нь бид нар шүү дээ...⁵⁵

Дээрх өгүүлэмжээс үзэхэд Ноолуурын салбараас гадна мал аж ахуйн түүхий эдийн худалдааг Ченж нар монголд явуулж байна. Архангай аймагт ноолуурын үед буюу 4 сарын 1-нээс 6 сарын 15-ны хооронд 20 орчим ченж тогтмол үйл ажиллагаа явуулдаг бөгөөд яг оргил үед нь 200 орчим ченж цуглардаг байна.

Ноолуурын оргил үеэр хотоос ченжүүд нэмэгдэж ирнэ. Энэ жил 200 орчим ченж ирэх шиг боллоо...Аймгийн төв дээр бол 20 орчим ченж тогтвортой ажилладаг...⁵⁶

Ийнхүү олон газрын ченж нар ноолуур бэлтгэх бөгөөд яг энэ үед ноолуурын ханш өсөж, ченж нарын өрсөлдөөн намжихтай зэрэгцэн ноолуурын ханш буурдаг байна. Энэ жилийн тухайд ноолуурын үнийн савлалт нэн өндөртэй жил болжээ.

Энэ жилийн ноолуур түүхэнд байгаагүй хол уналттай, огцом савалттай жил байлаа. 164 мянгаас 85 мянга хүртэл 2 дахин буусан...⁵⁷

Ер нь ченж нар хэд хэдээрээ баг болж ажиллах байна. Ерөнхий ажиллах зарчим нь сумын ченж нар цуглуулсан ноолуураа аймгийн ченж нар өгнө. Аймгийн ченж нар дотоодын үйлдвэр, гадаад ченж нартай холбогдож борлуулдаг аж.

Бид сумын ченж нараас ноолуур татан төвлөрүүлдэг. Ченж нарын мөнгөний эргэлтийн хэмжээ нь өөр өөр байна. Хотын ченж гэхэд л зөвхөн манай аймгийн ченжтэй харьцахгүй 21 аймаг, 330 сумын ченж нартай харьцана. Аймгийн ченж нар сумуудынхаа ченжтэй харьцана гээд л ялгаа их бий.⁵⁸

⁵⁵ Т. Долгоржав, Ямаа амьдын үнийнхээ 50%-ийг жил бүр өгдөг. Архангай аймаг, Ихтамир сум, ярилцлага авсан Пагмадулам Мэндмаа, 2022,

<http://zotero.org/groups/4737731/items/FN44RANK>.

⁵⁶ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁵⁷ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁵⁸ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Гэвч зарим сумын ченж нар шууд үйлдвэр, гадаад (хятад)-ын ченжтэй холбогдох тохиолдол байдаг гэнэ. Хэрэв тийм харилцаа холбоо үүсгэж чадсан ченж богино хугацаанд “томорч” их хэмжээгээр ноолуур бэлтгэх болдог аж.

Энэ жил би 3 найзтайгаа нийлж 30-40 орчим тонн ноолуур бэлдсэн... Нэг хүн 10 орчим саяын ашигтай ажиллах шиг боллоо. Бид дотоодын үйлдвэр болон гадаад зах зээлд ноолуураа нийлүүлдэг. Ер нь тэгээд гадаадууд нь арай илүү байдаг юм. Ер нь гадаад харилцаа байхгүй бол болохгүй л дээ.⁵⁹

Ноолуурын салбарт олон оролцогч нар байх тусам ноолуурын үнэ илүү өндөр байх бололцоотой бололтой.

гадаадуудтай хамтарч ажиллахаар валют урсаж байгаа л гээд байна. Валют эцсийн бүтээгдэхүүн болно гэвэл малчдын амьдрал доройтох юм байна лээ. Гадагш нь түүхий эдээ гаргахгүй 100% дотооддоо өгнө гэвэл нөгөөдүүл нь хоорондоо ярилцаж байгаад хямд аваад малчид дээр очих мөнгө нь багасаж байгаа байхгүй юу. Хямдхан байсан ч, үнэтэй байсан ч бид нартай харьцана шүү дээ. Яагаад гэвэл жилийн 4-н улирал бид нартай ойр байж, хэрэг болбол бид нараас зээлчихнэ шүү дээ. Жишээ нь цагаан сар боллоо гэхэд хавар ноолуураа аваарай гээд 1 сая төгрөг зээлэх тохиолдол гарна...⁶⁰

Ингэж үзвэл, ченж нарын ноолуурын салбарт үзүүлж буй үүрэг оролцоо өндөр байгааг тодорхой байна. Тэд ямааг хамгийн үр ашиг өндөртэй мал хэмээн үзэж байна.

Ямаа бол таван хошуу малаас хамгийн өндөр ашиг шимтэй мал. Жилд өөрийнхөө үнэний 50%-ийг өөрөө өгдөг. Тийм учраас эр, эмгүй хамгийн өндөр ашиг шимтэй амьтан. Социализмын үеэс хойш ямаа бол харьцангуй их өссөн.⁶¹

⁵⁹ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁶⁰ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁶¹ Т. Долгоржав, Ямаа амьдын үнийнхээ 50%-ийг жил бүр өгдөг. Архангай аймаг, Ихтамир сум.

Аймгийн төвийн ченжүүд хөдөө сумаар тойрдоггүй аж. Тэд сумын ченж, хамтран зүтгэгч нартаа мөнгө бэлдэж өгөөд өөрсдөө аймагтаа сууж, их хэмжээгээр ноолуур бэлтгэдэг аж. Аймгийн ченж нарын гол онцлог бол сумын ханшаас ариа өндрөөр авах, дээр өөрийн ашгаа нэмж түнш нартаа нийлүүлэх үүрэг хүлээдэг аж.

Би Хөдөөгөөр тойрох ямар ч бололцоо байхгүй. Өөрөө төв дээрээ зогсож, сумын ченж нарт мөнгө өгч авахуулна. Би Цэнхэр, Батцэнгэл, Тариат зэрэг сумын ченжүүдтэй хамтарч ажилладаг⁶²

Ченж нараас малчид мөнгө зээлэх тохиолдол их аж. Тэд ноолуур болон түүхий эдээ тогтмол тушаах болзолтойгоор мөнгө зээлэлдэг байна. Гэвч энэ нь тийм ч түгээмэл биш бололтой.

Жишээ нь 5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний ноолуур бэлтгэх нөөцтэй хүн урьдчилж 1 сая төгрөг зээлэх тохиолдол бий. Дараа нь 5 сая төгрөгийн ноолуураа авч ирээд л сая төгрөгөө суутгуулаад үлдсэн мөнгөө аваад л явна...⁶³

Тэд монголын ноолуурын үйлдвэрлэл Дэлхийн ноолуурын түүхий эдийн 40-50%-ийг дангаараа бэлддэг гэх боловч олон улсад сурталчлах тал дээр үйл ажиллагаа дутмаг санагддаг. Иймд, баримтат кино хийж, олон улсад сурталчлах ажил чухал байгааг онцолж байв.

Нэгдүгээр бүлгийн дүгнэлт

Бид “цагаан алт” хэмээх ойлголтын хүрээнд малчдын ахуй амьдрал ноолуур өргөн хүрээнд хоёр төрлийн үр ашиг бий болгож буй тухай өгүүлэхийг хичээллээ. Нэгд, эдийн засгийн үр ашиг бүтээж буй тухай. Эдийн засгийн үр ашгийг тухайн өрхийн орлогын бүхий л эх үүсвэрийг тооцож үзэж байж тодорхойлох шаардлага байна. Учир нь малчид нэг жилээс хэдэн арван жилээр эдийн засгийнхаа тооцоолол хийж, үе шаттайгаар амьдрал ахуйдаа хөрөнгө оруулалт хийдгийг бодолцох шаардлага байна. Тэгэхгүй бол ноолуур зөвхөн банкны зээл төлөх хэрэгсэл төдий харагдаж

⁶² Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

⁶³ Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

байна. Ингэж харагдаж буй нь ноолуураас авах ашиг малчдын эдийн засаг, санхүүд үзүүлэх нөлөө өндөр гэдэг ойлгомжтой байна. Малчид орлогоороо Улаанбаатар, аймгийн төвд үл хөдлөх хөрөнгө худалдаж авах болжээ. Энэ мэт томоохон хөрөнгө оруулалтанд зориулж банкны зээл авах байдал их ажиглагдаж байна. Ямар ч атугай эдийн засгийн үр өгөөжийн хувьд малчин өрхийн 30-50 орчим хувийг ноолуурын орлого бүрдүүлж байна.

Хоёрт, Ноолуур нь мал аж ахуйн соёл оршин тогтнох суурь үзүүлэлтүүдийн нэг болж байна. Малчид хэдийгээр 5 төрлийн мал сүргээс харилцан адилгүй бүтэцтэй өсгөж байгаа ч ямааны буй болгож буй соёлын үр ашиг бага биш юм. Тухайлбал, Ямааг шууд оролцоотойгоор “буян хишгийн аргамж” хэмээн үзэх тохиолдол ч байна. Ямаа сэтэрлэх зан үйл дадал буй бөгөөд ямааны бөөрний өөхийг бурхны шашны тосон урлалд өргөн ашиглаж байна. Ямааны бөөрний өөхөөр урласан 70 жилийн настай тосон урлал Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж байна. Шууд бус утгаараа Монголын мал аж ахуйн соёлд үзүүлж буй нөлөө өндөр байна.

Хоёрдугаар бүлэг: өмнөговь аймгийн номгон суманд хийсэн хээрийн судалгааны тайлан

Удиртгал

Тогтвортой ноолуурын ёс зүйг тайлах нь төслийн судалгааны багийнхан ямааны өлгий нутаг болох Өмнөговь аймгийг Номгон суманд хээрийн судалгааны ажлыг 2022 оны 9 сарын 19 ний өдрөөс 9 сарын 29 өдөр хүртэл 10 хоногийн хугацаатай хийсэн билээ. Бидний зорьсон Өмнөговь аймгийн Номгон сум нь зүүн талаараа БНХАУ-тай хил залгаа нутаг ба энэ зун хур бороо багатай гандуухан зуссан тул нутгийн малчин айлууд хилийн дагуух устай газар бараадан отроор нүүсэн талаар Улаанбаатар хотоос гарахдаа нутгийн хүнээс сонссон юм. Номгон сум нь Улаанбаатар хотоос 670 км, аймгийн төвөөс 106 км зайд байрладаг ба судалгааны баг замдаа бүтэн өдөр зарцуулж Даланзадгад хотод нэг хоноод маргааш өглөө Номгон суманд ирлээ.

Захын сум болоод ч тэр үү Номгон сумын зам тааруу бартаа ихтэйн дээр энэ жил зуншлага тааруу гандуу болсон тул отроор яваагүй үлдсэн Хармагтай, Төхөм, Дэрсэнэ-Ус багийн айлуудаар орох боллоо. Говийн айлууд ганц гэрээрээ буудаг тэмээ, морь хөлсөлдөг үе ард үлжээ. Айлууд хоорондоо дунджаар 9 км зайтай, орчин үеийн чингэлэг сууцтай голдуу үүдэндээ машин, мотоцикл харагдана. Номгон сум маань 1924 онд Дэлгэрхангай уулын хошууны Булган сум, мөн онд Гашуун боомд Мандал сум байгуулагдаж, одоогийн Номгон сумын нутаг дэвсгэр дээр 2 сум зэрэгцэн байгуулагдсан түүхтэй ба 300 гаруй өрхтэй, 1200 хүн амтай, 110 мянган малтайгаар байгуулагдаж байсан⁶⁴ бол одоо 5 багтай нийт 1557 хүн амтай 19470 км газар нутагтай бөгөөд сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй

⁶⁴<http://www.omnogovi.gov.mn/nomgon>

юм. Сумын эдийн засгийн гол бааз суурь нь 128,0 мянган ямаатай бөгөөд жилдээ дунджаар 50.0 тонн ноолуур авч 1.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг байна⁶⁵.

Энэ нутгийн иргэд эртнээс ямаа, тэмээ голлон өсгөж ирсэн бөгөөд баримт сөхвөөс нийгэм журмын үед Номгон сумын Сангийн далай нэгдэл нь 1977 оноос эхлэн 3 сая төгрөгийн орлоготой болсон бөгөөд үүний 92 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс орно. 1979 оны байдлаар нийт малын 14.6 тэмээ 8.9 нь адуу, 0.5 хувь үхэр, 20.6 хувь хонь 55.6 хувь нь ямаа байна. Сангийн далай нэгдлийн ашиг орлогын ихэнх хувийг тэмээ, ямааны аж ахуйгаас олдог тул энэ чиглэлийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримталж байжээ. Түүнчлэн мал сүргийн үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 1979 онд говь гурван сайхан үүлдрийн ямаагаар ямаан сүргээ сайжруулж 23000 толгой ямаатай болсон 6-р таван жилийн төлөвлөгөөг малын төрөл бүр дээр 103-113 хувь давуулан биелүүлсэн⁶⁶ нэгдэл бөгөөд 1942 онд БНМАУ-ын 25 дугаар баг хурал дээр Номгон сум нь ноос бэлтгэлийн уралдаанд 2 дугаар байранд улсад 66331-124130 кг малын ноос тушаан шалгарч Маршал Чойбалсангийн хайр хүндэтгэлийг хүлээж, улсаас 100,000 төгрөгийн шагнал хүлээн авч байжээ.⁶⁷ Улмаар 1934 онд Номгон сум гэгдэх болсон үе, 1959 онд Сангийн далай нэгдэл байгуулсан үеэс хойш мал сүргийн бүтцийн голлох хэсэг бол ямаан сүрэг малын ноолуур самнах, ноос ноолуур авах, бэлтгэх арга технологийн хувьд социализмын үед ч гарамгай сайн байжээ.

Улаанбаатар хот; – 2 Өмнөговь аймаг Даланзадгад хот; – 3 Өмнөговь Номгон сумын төв; – 4 Хармагтай багийн нутаг; – 5 Дэрсэнэ-Ус багийн нутаг; – 6 Төхөм багийн нутаг; – 7 Номгон сумын төв; – 8 Даланзадгад хот; – 9 Улаанбаатар хот; нийтдээ машинаар 31 цаг явсан байна.

Хээрийн судалгааны багийн зохион байгуулалт

- Ахлагч судлаач С.Мижид
- Судлаач Г.Содбаяр
- Судлаач Д.Наранбаатар
- Судлаач Ц.Баяртогтох

⁶⁵<http://www.omnogovi.gov.mn/nomgon>

⁶⁶Номгон сумын танин мэдэхүй толь 2016 он хуудас 23 сангийн далай нэгдэл

⁶⁷Номгон сумын танин мэдэхүй толь 2016 он хуудас 19 албан захидлын хөрвүүлэг

Судлаач З.Бадамсүрэн гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй ба Хармагтай баг очоод Батдэлгэр гуатай танилцаж багтаа элсүүлж 2 чиглэлд хуваагдаж явах болов.

Чиглэл баруун зүгт-Мижид Наранбаатар Хармагтай айлуудаар явах

Чиглэл зүүн зүг- Содбаяр, Баяртогтох, Бадамсүрэн нар Батдэлгэр гуай хамт Дэрсэнэ-Ус- Дөхөмөөр нутаглах айлуудаас ярилцлага авахаар хөдлөв.

Батдэлгэр гуай бол хуучин хармагтай багийн дарга байсан Дэлгэртогтох гуайн ах, нийгэм журмын үед сум нэгдлийн худгийн моторчин байсан, дараа нь Сангийн далай нэгдэлд тэмээн сүрэг голдуу маллаж байжээ. Одоо хүү бэрийн хамт Номгон сумын Хармагтай багт мал аж ахуй (тэмээ, ямаа хонь) эрхэлж байна. Батдэлгэр гуай ярихдаа “Бог бол гарын дор мал юм. хэн ч өсгөж чадна. Харин говь нутагт тэмээн сүрэг өсгөнө гэдэг бол эр хүний хийх ажил юм” хэмээн хэлж байв. Тэрээр хүүгээ тэмээчин болгох хүсэлтэй байгаа гэнэ. Тэрээр бидний хээрийн судалгааны орон нутгийн зөвлөх, малчдын байр байдал, нутаглаж буй газар орныг зааж өгсөн ачтан юм.



Зураг 16. Судалгаанд оролцсон хүмүүсийн эзлэх хувь

Судалгаанд хамрагдсан малчдын ерөнхий мэдээлэл

- Хоршооны дарга Баттогтох
- Хөдөө аж ахуйн мэргэжилтэн
- Соёлын төвийн эрхлэгч Нарангэрэл
- Хармагтай багийн дарга асан Дэлгэртогтох
- Хармагтай, Төхөм, Дэрсэнэ-Ус багийн нийт 19 малчин айл өрхүүд судалгаанд оролцсон байна

Номгон сумын бэлчээр, түүнд хандах малчдын хандлага

Нийгэм эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран ямаа өсгөх үржүүлэх хандлагатай Номгон сумын малчид нэгдлийн үеэс тэмээ, ямаа голдуу өсгөж ирсэн бөгөөд ноолуурын үнэ эдийн засгийн ач холбогдлоос үл хамааран ямаан сүрэг өсгөн үржүүлэх хандлагатай байна. Гэвч ган, зудтай холбоотойгоор малчдын сэтгэл санаа онцгүй байв. Тухайлбал,

Манайх энэ жил мал төллүүлэхгүй. Би энэ Хятадын эрхэнд ч ормооргүй байна. Манай нутаг чинь гандахаараа нэг гандаж, гундахаараа нэг гундаж байна. Уур хүрч харсан хүн болгоноо зодчихмоор байна шүү. Би энэ хавар ямаагаа амьд байх эсэхийг мэдэхгүй байгаа болохоор ноолуурынхаа тухай ярмааргүй байна...⁶⁸

Дээр дурдсанчлан тус суманд ган болсноос үүдэлтэй малчид малаа хэд дахин цөөлжээ. Зарим мал нь халуун намраар турж үхэж байв. Бид Номгон сумын төвөөс хоолны мах авах гэж дэлгүүрээр нь ороход нойтон мах байхгүй байлаа. Тиймээс сумын соёлын төвийн даргаар яриулж байж, жаахан адууны мах олж авсан юм. Ган болоход малын махнаас гадна сүү цагаан идээ зэрэг бүх зүйл хомсддог аж. Энэ нутагт цагаан идээ хийж буй айл бараг байхгүй байсан хэмээн хэлж болохоор байлаа. Ямааг эрхэмлэх хандлага говь нутагт өндөр байна. Ноолуурын ханш ноос шиг унасан тохиолдолд ч ямаа өсгөх хандлагатай байна.

⁶⁸ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Учир нь малын ашиг шил бол зөвхөн ноос, ноолуураар ч хэмжигдэхгүй ажээ. Байгалийн нөөцийг зохистой ашиглахад ямаан сүрэг сөрөг нөлөөтэй хэмээх ойлголт бий. Энэ тухай 1990-1995 онуудад өндөр уулын бүсэд монгол ямааны бэлчээрээс идэх өвсний хэмжээг Ж. Тогтох, Ц. Цэвээн нар тогтоожээ. Нас гүйцсэн нэг ямаа зуны улиралд өдөрт 1.7 кг, өвөл, хавар 0.9-1.0 кг өвс иддэг гэсэн бол, Д. Даваасамбуу цөлөрхөг бүсэд уг судалгааг хийж, өвөл, хавар 1.1-1.2 кг, зун, намар 1.2-1.4 кг өвс иддэг” хэмээн үзсэн байна гэж тогтоожээ.⁶⁹ Эцэст нь судлаачид ямаа бэлчээрлүүлэх бэлчээрийг хэрхэн арилгах гамнах тухай зөвлөмж гаргаж байжээ. Тус зөвлөмжид,

Ямаа ургамлын үржлийн ба усгал эрхтнийг сорчилон идэхээс гадна сэргэн ургалтын үед хөрсийг малтаж, ургамлын үндсийг сугалан иддэгээс ургамал бүрэн мөхөж, хөрс эвдрэх аюултай байдаг. Иймээс өвөлжөөний бэлчээрийг 4.10-10 сарын дунд үе хүртэл бүрэн чөлөөлж, хавар нялх ургамал гарахаас өмнө тэндээс нүүж байх хэрэгтэй. Ямааг дангаар бэлчээвэл ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөө их тул хонь ба ямааны харьцааг 1:1, бүр сайн гэвэл 3:1 харьцаатай байлгах хэрэгтэй.⁷⁰

Харин Номгон сумын малчид байгалийн нөөцийг зохистой ашиглалтанд ямаан сүрэг сөрөг нөлөөтэй, бэлчээр тахалдаг гэсэн ойлголтод эсрэг байр суурь баримталж байна.

Говь нутаг бол угаас хангай нутгаас өвс ургамлын хувьд тарчиг таана хөмөөл голдуу ургадаг бөгөөд ямаа өсгөхөд тохиромжтой, хангай нутаг шиг өвсний шим үндсээр нь түрүүлж идээд бэлчээрт сөрөг нөлөө үзүүлэх нь нөхцөлгүй. Бороо ордог юм бол говьд ямаа, тэмээ хоёрыг хэд ч хүртэл өсгөж болно. Бороо орохгүй бол говь нутаг ямаатай ямаагүй юу ч ургахгүй...⁷¹

⁶⁹ Ё. Загдсүрэн, ред., *Монголын ямаа судлал: 80 жилд* (Улаанбаатар: Сэлэнгэ пресс, 2011), 251.

⁷⁰ Загдсүрэн, 257.

⁷¹ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Дээрх хандлагаас гадна ямаанд оногдуулж буй малын хөлийн татварыг бусад малтай харьцуулахад өндөр байна хэмээн малчид үзэж байна. Өмнөговь аймгийн Номгон сумын малчин Батжаргалын Норов,

Ямааг ад үзээд байхаар л миний дургүй хүрээд, сонин санагдаад байдаг юм. Би бол тэрийг буруу л гэж бодоод байдаг юм. Би ядаж ноолууран бүтээгдэхүүн гаргадаг тэгэхэд хонь бараг ашиг байхгүй ш дээ. Бас ямааны татварыг өндөр тавиад байгаад миний дургүй хүрээд байгаа юм. Ямаанд 800 төгрөг тогтоочихсон. Хамаг бэлчээрийн дайсан гээд байна ш дээ, уг нь хамгийн хэрэгтэй ноолуур, сүү, арьс, мах гээд бүх зүйлийг нь авч байна.⁷²

Тус сумын малчид бол ган, зудын аюулыг уул уурхайтай холбон тайлбарлаж байна.

Энэ хужаа нарыг албал ган зуд тайлагдах байх даа. Говь нутаг бол бүхэлдээ хятадуудын мэдэлд байна ш дээ. Машинтай давхиж очоод бороо оруулна гэж үүл буудаад шороо тавиулаад байна ш дээ. Ямааг ер нь яасан юм бэ, ад үзээд байдаг. Өмнө нь ингээд байгаад болоод байсан гэнэт л 2, 3 жилийн өмнөөс ямаа бэлчээрийн дайсан болчихсон...⁷³

Бэлчээрийн тухайд Өмнөговь сумын малчид цаг уурын өөрчлөлтөөс бүх зүйл шалтгаална хэмээн үзэж байна.

Байгалиараа биш бол нэмэргүй дээ, байгалийн дайтай усалгаа хийж чадахгүйгээс хойш нэмэргүй л гэж би бодож байна даа. Тэнгэр, газрыг захирч чаддаггүй л юм бол хэцүү л байна даа. Бас тэр төрийн түшээд яана гэж гарсан. Одоо яагаа ч үгүй. Байхгүй дээ...⁷⁴

Мөн ган, гачгийг үүл буудах үйл явцтай холбон тайлбарлаж байна. Номгон сумын залуу малчин Батжаргалын Наранбат ийнхүү тайлбарлаж байна.

⁷² Өмнөговь аймгийн хээрийн судалгааны тэмдэглэл. 2022 он

⁷³ Өмнөговь аймгийн хээрийн судалгааны тэмдэглэл. 2022 он

⁷⁴ Өмнөговь аймгийн хээрийн судалгааны тэмдэглэл. 2022 он

Манай энд уул уурхайн чиглэлээр боомт руу зам тавина гээд үүлийг нь буудаад байгаа учраас Хүрмэний малчид ихээхэн дургүй. Бэлчээрээ хамгаалж тэмцэж байна... үл бөөгнөрөөд огт тэнгэр дуугарахгүй байхад 3 удаа тэнгэр дуугарна тэгээд л тараад алга болчихдог. Үүл буудах нь тэр дээ. Буудсан газраас 100 км зайд ордог юм билээ. Манай энд бол хангалттай бороо орохоор үүл зөндөө гарсан даанч тэгээд буудаад оруулахгүй юм даа...

Бид Номгон сумын малчдын үзэл санаанд тулгуурлан дараах хэдэн гаргалгаа хийж болмоор байна.

- Байгалийн давагдашгүй хүчин зүйл эсвэл цаг уурын өөрчлөлт нь бэлчээрийн даацад шууд нөлөөлж байна.
- Ган, зуд болохоор малчид дайжиж нүүх, эсвэл уг газар орондоо малаа цөөлж амьдрах хоёр сонголт л үлддэг аж.
- Тус сумын малчдын тал нь шилжиж нүүх, отор хийх сонголт хийсжээ. Ийнхүү шилжилт хийсэн малчид нь гадаад харилцаа холбоо сайн, унаа хөсөг, нүүдлийн зардал даах чадвартай хүмүүс нь нүүжээ. Харин ар гэрийн шалтгаан, хүн хүч, машин техник зэргийн улмаас зарим хэсэг нь үлдэж хоцорсон байна.
- Нутагтаа үлдсэн малчдыг орон нутгаас хилийн бүс рүү нутаглуулах шийдвэр гаргажээ. Хилийн бүс нь Номгон сумаас 200 гаруй км орших бүс нутаг байна. Тэнд бартаа саад ихтэй. Өндөр тэнхлэгтэй машин л явж чадахаар газар орон байх бөгөөд зам бартаа саад ихтэй, чоно элбэгтэй газар гэнэ.

Хураангуйлан дүгнэж үзвэл таван хошуу малын зохисыг үзэж, бэлчээрээ сонгон нутаглавал бэлчээр талхалдаг мал гэж байдаггүй бололтой. Гагцхүү тэнгэрээс буух хур борооноос бүх зүйл шалтгаалах мэт.

Номгон суман дахь ямааны үүлдэр, түүнийг маллах арга ажиллагаа

Номгон сумын судалгаанд оролцсон малчдын ярьж буйгаар Говь гурван сайхан угшлын ямаа өсгөж байгаа аж. Гэвч бидний ажиглалтаар айл бүр хэдэн үүлдрийн

ямаа өсгөж байгаа юм шиг санагдсан. Тухайлбал, Монгол үүлдрийн ямаа, говь гурван сайхан угшил гэх мэт.

Говь гурван сайхан (ГГС) ямаа нь Донын хавийн үүлдрээр монгол нутгийн ямааг 2-р үе хүртэл нь эрлийзжүүлж, тохиромжтой үр төлийг “өөр дотор нь” хэд хэдэн үе үржүүлэх аргаар гарган авсан, арвин их ноолууртай, монгол оронд дасан зохицох чадвартай, ноолуурын технологийн чанар, нарийн зөөлөн шинжийг сайн хадгалсан ямаа юм. Эрдэмтэн Д. Дөнгө “*Говь гурван сайхан ямааны ноолуурын ашиг шимийг сайжруулж, батжуулах арга зам*” судалгааны ажилдаа,

Говь гурван сайхан үүлдрийн ямаа говийн бүсийн бэлчээрийн маллагааны нөхцөлд зохицсон, чийрэг бие цогцостой, галбирын согоггүй, дунд зэргийн биетэй, үндсэн зүс нь хар, харин ноолуур хялгасаа давж ургасан үед бор шарга, бор, сааралдуу болдог, эм ямаа дунд зэргийн эвэртэй, толгой харьцангуй хөнгөн, ялимгүй шонтгор хоншоортой, хүзүү богиновтор, дэлэн хөхний хөгжил сайтай, ухнын эвэр, хүзүү, сээр, хавирганы яс хөгжилт сайтай, сэрвээ өндөр, товхгор, цээж өргөх, бэлгийн хоёрдогч шинж тод илэрсэн, аль ч хүйсийн ямаа ноолууржилт сайтай, тухайлбал урд хөлийн өвдөг, хойд хөлийн борви, толгойн хэсэгт чихний ар хүртэл ноолууртай, хэвлийн хэсэгт богино боловч ноолуур, хялгас жигд ургасан байна. Энэ ямааны 80 гаруй хувь хар зүстэй, бараан цайвар саарал өнгийн ноолууртай⁷⁵

хэмээн тодорхойлжээ.

“Говь гурван сайхан” үүлдрийн ямааг ижил төстэй бусад үүлдэр, омогтой харьцуулахад биеийн өндрийн хувьд нутгийн шилмэл монгол ямаанаас дутуугүй боловч биеийн ташуу урт, цээжний гүн, бүслүүр, шилбэ, бүслүүрийн хэмжээгээр ялимгүй дутуу, амьдын жингээр дунд зэрэг юм. Ашиг шим нь бусад төрлийн ямааны үүлдэртэй харьцуулахад ноолуурын чиглэлийн ашиг шим өндөртэй бөгөөд бүх сумдад үндсэн сайжруулагчаар ашиглаж ирсэн. Монгол ямаанаас ноолуурын гарцаар 2 дахин их, сүүгээр 32%, амьдын жингээр 13%, ихэрлэхлээр 6% давуу

⁷⁵ Д. Дөнгө, “Говь гурван сайхан ямааны ноолуурын ашиг шимийг сайжруулж, батжуулах арга зам. Хөдөө аж ахуйн амьтдын үржүүлэг, селекци” (Ph.D зэрэг горилсон диссертаци., 1995).

байдаг. Арьсны таваар технологийн чанар нутгийн ямааныхаас дутуугүй, түүгээр сайн чанарын шевро боловсруулж төрөл бүрийн савхин эдлэл хийдэг. Энэ үүлдрийн ямааг манай орны говь, өндөр уул, тал хээрийн бүсэд хамаарах Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн зарим сумын нутгийн ямааны ноолуурын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор үндсэн сайруулагчаар эрчимтэй ашиглаж байна.⁷⁶

Бидний таамаглалаар Номгон сумын малчид өөр өөрсдийн сонирхлоор ямаагаа өсгөж байна. Зарим айл Эдрэнгийн цагаан ямаа буюу залаа жинстийн цагаан ямааны үүлдрийн тэхээр ямаагаа сайжруулж буй бол зарим нь Говь гурван сайхан (Улаан, хар) зэрэг сайн үүлдрийн тэхээр ямаагаа сайжруулж байна. Харин нөгөө нэг хэсэг нь нутгийн монгол ямааг өөр хооронд нь үржүүлж байна.

Ямааг өсгөж үржүүлэхэд жаахан ажиллагаатай хэмээн үзэж байна.

Ишиг сайхан гарна. Гэхдээ нялх хүүхэд шиг цус шүү. Хүйтэнд бол нойтон ишиг чинь хөөрхөн асаргаа авна даа. Цаг сайн бол сэргэлэн, дажгүй. Яг гардаж асруулдаггүй амьтан чинь тэмээ, үхэр, адуу бас хонь их сайхан шүү хүйтэнд нойтон гаараад, үс нь хөлдчихсэн байхад эхийгээ хөхөөд зогсож байдаг...⁷⁷

Ямааны сүү, ноолуур хоёр сайжраад ирэхээр яс чанар мууддаг байж магадгүй гэх болгоомжлол байна.

Ноолуур муутай ямаа байхаа байчихсан. Дандаа энд тэндээс ухна авчраад тавьчихсан. Баянхонгорын цагаан ямаа, Сүхбаатар бас хаа байгаа Алтайн уулын борыг ч авчраад тавьчихсан байгаа юм чинь ноос нь сайжрахгүй яах вэ дээ. Гэхдээ нэг гэм бий ноос, сүү нь сайжраад ирэхээр малын чанар, яс мууддаг байх шиг байна. яс нь муудаад 10 нас хүрдэг байсан бол 2 ишиглээд 5, 6 настайдаа шүдгүй болчихож байна...⁷⁸

энэ тухай лавшруулан үзэх шаардлага байна.

⁷⁶ <https://www.goviinoyu.mn/project/26>

⁷⁷ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгаа, 2022 он

⁷⁸ Өмнөговь аймгийн Номгон суманд хийсэн хээрийн судалгаа, 2022 он

Номгон сумын хоршоо

Хоршооны үйл ажиллагааг малчид төдийлөн сайн мэдэхгүй байв. Тэд Лусын сэрчим, Хөрхийн наран гэдэг хоршоо байгаа тухай мэдэж байв. Дээрх хоёр хоршооны дарга, тэргүүлэгч нартай холбогдоход “Хөрхийн наран” хоршооны дарга Улаанбаатар хотод ажилтай явж байсан тул уулзаж чадаагүй. Лусын сэрчим хоршооны дарга Р.Баттогтохтой уулзаж, мэдээлэл авав. Лусын Сэрчим хоршооны бизнес үйл ажиллагааг хариуцдаг хүн Бат-эрин, түүний эхнэр Амгалан нар хариуцдаг гэнэ. Харин хоршооны бичиг, хэргийн ажлыг хоршооны дарга хариуцдаг гэнэ.

манай сумын малчид өргөн уудам нутагт тарж байршиж байна. Малчдын ерөнхий байдлыг ажиглахад 40-өөс дээш насныхан үндсэн цөмийг бүрдүүлж байна. Тэдгээр малчид маань олон жил бичгийн ажлаас хол хөндий байсан. Иймээс бичиг баримт боловсруулалтын ажилд оролцох нь бага юм. Мөн хоршоо бол тэдгээр малчиддаа үйлчлэх ёстой шүү дээ. Иймд, бичиг цаасны ажил, удирдлага зохион байгуулалтын ажилд нэмэртэй юм гээд намайг сонгож, энэ албанд зүтгүүлсэн. Би хичээж ажиллаж байна. Энэ жил их хүнд нөхцөл байдалтай байна. Хадлан, өвс, гэжээл бэлтгэх ажил ид явагдаж байна. Холоос татаж хуримтлуулах ёстой. Малчдын тал нь бусад аймаг, сумын нутгаар отор хийж явж байна. Малчидаа малаа их нядалж, борлуулж байна. Ирэх жил ноолуурын гарц маш багасах тодорхой. Хоршооны хувьд их хүнд жил болох гэж байна...⁷⁹

Лусын сэрчим хоршоо 2022 оны хавар 100 тн ноолуур бэлтгэж Ханбогд Кашмерт нийлүүлжээ. Тус хоршооны гишүүд ноолуураа бэлтгэж нийлүүлдэг. Бүх гишүүдийн хурлаар Хоршооны дарга, Хоршооны 9 тэргүүлэгч сонгож батламжилдаг. Тэргүүлэгч гишүүд улиралд нэг удаа хуралдах ёстой, бүх гишүүдийн хурал жилд хоёр удаа болох ёстой. Дээрх дүрмийн хүрээнд тус хоршоо ажиллаж байгаа тухай хоршооны дарга танилцууллаа. Энэ жил гантай байгаа учраас хурлаа хийж чадаагүй байна. Үндэсний үйлдвэрлэгч нартаа ноолуур тушаах үндсэн зорилготой. Ханбогд кашмерээс 10 малгай, хүзүүний ороолт авч ирж гишүүддээ

⁷⁹ Р.Баттогтох, Лусын сэрчим хоршооны дарга, 2022 он

бэлэглэсэн. Тогтвортой ноос ноолуурын эвсэлтэй хамтарч ажилладаг. Энэ жил мөнгөн батламжтай болсон. Тогтвортой ноос ноолуурын эвслээс гаргасан шаардлагуудын заримыг нь хангаж чадахгүй байна. Малчидад сургалт явуулж “мэргэшсэн малчин” батламж гардуулж байгаа. Тогтвортой хөгжлийн үзэл санааг нутагшуулах гээд үзэж л байна. 203 гишүүнтэй болсон. Хоршооны 7 гишүүн нас барсан. Өв, хөрөнгө шилжүүлэх тухай баталгаа хийж чадаагүйн улмаас хасаж чадахгүй байна. Манай хоршоо ноогдол ашиг олгож чадахгүй байна. Малчидадаа бид орон нутгийн ханшаас арай хямдаар гурил, будаа нийлүүлж байна. Сум, орон нутгийн эзэмшлийн агуулахад тэжээл, өвсний нөөц бүрдүүлэн малчидадаа хөнгөлөлттэй үнээр нийлүүлж байна. “Тогтвортой ноос ноолуурын эвсэл”-ээс шилдэг хоршоогоор шалгарч 20 сая төгрөгийн дэмжлэг авсан. Тус 20 сая төгрөгийн 10 саяар малчидын чадамжийг дээшлүүлэх, 10 сая төгрөгөөр малын үүлдэр угсааг сайжруулах ёстой. Манай хоршооны түрүүчийн өвс, тэжээл ирчихсэн байна. Удахгүй хадгалах байр савандаа буулгаж, малчидадаа олгож эхэлнээ. 2013 оноос уг хоршоо байгуулагдсан.

Малчидадаа 1 сая төгрөг хүртэлх хэрэглээний зээл олгодог. Манай хоршооны эзэн тодорхой хэмжээнд сум орон нутагтаа танигдсан ченж хүн бий. Ноолуур худалдаж авах болон бизнесийн үйл ажиллагааг Бат-эрин хариуцан ажиллаж байна.

Манай хоршооны гишүүд социализмын үед ажиллаж байсан өвсний фондыг засаж янзалж авчээ. Хоршооноос 40 орчим сая төгрөг гаргаж зассан гэнэ. Дотор өвс ачсан шланз машин дотор ороод өвсөө буулгаад гарах боломжтой том агуулах бэлдсэн.⁸⁰

Хоршооны үйл ажиллагааг малчид ноолуур авдаг гэдгээр нь мэддэг юм байна. Ноолуураа хаана нийлүүлдэг, ноолуур үйлдвэрлэх үйл явц хэрхэн өрнөдөг тухай сайн мэдэхгүй байв. Зарим малчид хоршооны үйл ажиллагааг шүүмжлэх байр суурьтай байв.

⁸⁰ Рулам Батгогтох, Лусын Сэрчим хошооны дарга, ЕБС-ийн насан туршийн боловсролын багш. Өмнөговь аймаг, Номгон сум, ярилцлага авсан Мижид Сайнбуян & Наранбаатар, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/5N448UA7>.

Үгүй ээ ямар нэгэн хоршоонд байдаггүй, би бол дэмий гэж бодоод орохгүй байгаа юм. Хоршооны гишүүнд хоршооноос ямар нэгэн тусламж үзүүлдэг юм болов уу? Нэг уут тэжээл л өгдөг юм билээ, тэрийгээ ер нь хэдэн мал тэжээх вэ дээ. Ямар ч хэрэггүй юм. Цагаан сарын үеэр 2,3 хувийн хүүтэй мөнгө авлаа гэж хүмүүс ярьдаг юм билээ. Гэхдээ тэгж ихээр нь зээлдэггүй байх даа. Манай энд Дундговь, Өмнөговийн гээд ер нь 2,3 газраас ирж авдаг даа. Би бол Бат-Эринд өгдөг нутгийн юм болохоор арай нэг дээр юм уу даа гэж боддог.⁸¹

Малчид ноолуурын ханш харж байгаад арай илүү үнэтэй авъя гэсэн Ченжид зардаг гэнэ. Ноолуурын үнийг хятад ченж, эсвэл хятад ченжийн мөнгө авсан ченжүүд тогтоож байна хэмээн үзэх хандлага байна.

Сүүл рүүгээ ноолуур нь их болчихоор үнэ нь буучихдаг. Хятад руу л явуулаад байна, тэгээд эндээ буугаад л энд дагаад буудаг байх. Хятадууд л барьчихаж байгаа юм даа. Тэд нар чин үнэн ч хэлээд байгаа юм уу худлаа ч хэлээд байгаа юм уу бүү мэд...⁸²

Дүгнэлт: Байгаль, нийгэм соёлын үнэ цэнэ

Судалгаанд хамрагдсан иргэдийн 60– аас дээш хувь нь үйлдвэрлэлийн үе шатыг огт сонирхож судалж байгаагүй. Мөн ноолууран бүтээгдэхүүн малчдын өдөр тутмын хэрэглээнд зохицдоггүй гарын аяа даахгүй гэсэн хандлага өндөр байна. Үүнтэй холбоотойгоор ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шатыг гадаадынханд үзүүлж танилцуулах шаардлагатай хэмээн тэд үзэж байна. Малчидад аж ахуйн соёлын үнэ цэнэ, ямаа өсгөх, үржүүлэх, эмнэх арга ажиллагааны нь нэн чухал өв, соёл болох тухайд итгэл үнэмшил олгох шаардлага байна. Зарим талаараа өөрсдийнхөө үнэ цэнэ, ач холбогдлыг үл тоох, хот суурин газрынхан сайхан амьдарч байна. Бидний байгаа байдал хэцүү байна гэж үзэх хандлага бага зэрэг

⁸¹ Батжаргал Норов, ямаа бол амьдралын эх булаг. ямаа бэлчээр талхалдаггүй., ярилцлага авсан Мижид Сайнбуян, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/EV2U3HZJ>.

⁸² Ням-адьяа, ноолуур ангилж авдаг. Өмнөговь аймаг, Номгон сум, ярилцлага авсан Баяртогтох, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/8EEQU2AX>.

ажиглагдаж байлаа. Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцыг гаднынханд үзүүлэх нь илүү ач холбогдолтой гэж бодож байгаа малчид цөөнгүй байна. Харин мал маллах үржүүлэх арга технологи, ямаа самнах арга ажиллагааг гаднынханд танилцуулах хэрэгцээ байна уу гэж үзэх хандлага бас ажиглагдаж байв.



Зураг 17. Лусын Сэрчим хоршооны ноолуурт бэлтгэх талбай, 2022 он

Гуравдугаар бүлэг: баянхонгор аймгийн шинэжинст, баянговь суманд хийсэн хээрийн судалгааны тайлан

Удиртгал

Өмнийн говийн их шүтээн болсон Ихбогд уулын араар Жинст сумынхан суурьшдаг бол өвөр хэсгээр Баянговь сумынхан нутаглаж байна. Энэ сум Баянтолгой, Баянхонгор, Баян-овоо, Их баян зэрэг “баян” гэх тодотголтой олон газар буй тул Баянговь хэмээн нэрлэсэн хэмээх нутгийнхан ярьж байна. Тэд нутгаа ийнхүү тодорхойлж байна.

арсгар барсгар хад чулуутай, армаг тармаг өвс ургамалтай, энгэр нөөлөг толгодтой, ихэмсэг дүр нь ухаарал тэлсэн сүмбэр уулстай, Хулангийн давхиа цуцаам говийн уудам тал хоолойтой, Гоёмсог дүр төрх бүхий соёлын олон дурсгалтай Баянговь сум...⁸³

Энэ нутаг нь хуучнаар Эрдэнэ бандида хутагт ламын гэгээний их шавийн нутаг аж. Баянговь сумын ойрын түүх бол гэгээн шавийн хошуу, ламын гэгээнүүд, Баянзүрхийн хийд буюу ламын гэгээний хийдийн түүх хэмээн үзэж болмоор байна. Энэ тухай Ламын гэгээний хийдийн хамба лам Б.Баянжаргал ийнхүү дурсав.

Ламын гэгээний хүрээ нь Баянхонгор аймгийн төвөөс зүүн тийш 45 км-т Баянзүрхийн хонхорт анх 1745 сууриа тавьснаас хойш Ламын гэгээний үе үеийн дүрүүдийн үед өргөжин тэлсээр 7000 гаруй шавьтай, 40 гаруй тооны дугантай, 8 дацантай, 4 талдаа их хаалгатай Халхын томоохон хийд болсон түүх 1930-аад оны их хэлмэгдүүлэлтийн үед устаж үгүй болсон гашуун түүхтэй. 1990-ээд оноос ардчилал өөрчлөлт эхэлж, шашин

⁸³ Баянхонгор аймгийн Баянговь суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

бурхнаа чөлөөтэй шүтэх эрх чөлөөтэй болсон үед Баянхонгор хотын хоймор хэсэгт Гон ган Дэдлин хийдийг сэргээн босгож, Баянзүрхийн хонхорт Ламын гэгээний хийдийг сэргээсэн...⁸⁴

Ламын гэгээний шавь ардын нутаг тул айл бүр бурхан тахилтай, түүндээ гүн сүсэг бишрэлтэй ханддаг нь ажиглагдаж байлаа. Баянговь сумын 4-р багийн нутагт “Ишгэний эвэр” хэмээх нэртэй нэгэн хайрхан буй. Тус уул эртний тахилгатай бөгөөд далайн түвшнээс дээш 2200 м өндөр оршино.

Эрт цагт гэгээнтнүүд тус уулыг тахиж байжээ. Ламын гэгээн Заяын гэгээний урьж, залж авч ирж, энэ уулыг шүншиглүүлсэн юм гэдийм. Энэ өвөрт нь байх рашааныг уухдаа улаан ухан ишигний хүзүүнд хадаг зүүж, тавиад гэгээнтнүүд рашаан хүртдэг байж гэнэ. Анх аргалын шанд гэдэг нэртэй задгай ус байж. яагаад аргалийн шанд вэ гэхээр шархтай, сорвитой аргал ирж, усыг нь ууж тэнхэрдэг гэнэ. Хөгшчүүд “Ишгэний эвэр” уулын рашааныг хуучны эмчилгээний сударт тэмдэглэгдсэн гэж ярдаг юм шүү...⁸⁵

Энэ мэт олон үеийн түүх, домгийн илтгэх түүх, соёлын олон өв тус суманд оршоор байна. Нутгийн зах руу ороход алсаас сайран харагдаж их сүргийг бид хонин сүрэг бэлчиж байна хэмээн бодов. Гэвч яваад очих үед дан цав цагаан ямаан сүрэг бэлчиж байлаа. Их говьд эгэлгүй, гайхширал төрүүлсэн олон зүйлийн эхнийх нь алдарт Залаа Жинстийн цагааны ямаа байв. Хэдийгээр энэ нутаг цагаан ямаатай гэдгийг мэдэж байсан. Зүс ижилсүүлсэн мянган ямаа бэлчээр идээшилж байна хэмээн төсөөлөөгүй байсан юм. Ингээд бид Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст суманд хийсэн хээрийн судалгааны ажлын хүрээнд дараах асуудлыг хөндөн ярилцана. үүнд,

Нэгт, чухам хэрхэн ингэж нэг зүсмийн ямаан сүрэг өсгөж буй тухай дор Баянговь, Шинэжинст сумын ямааны үүлдэр угсаа хэсэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Хоёрт, Баянговь, Шинэжинст сумынхны бэлчээр, түүнд хандах хандлага


⁸⁴ Ламын гэгээний хийдийн хамба лам Б.Баянжаргал хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

⁸⁵ С.Батдорж, Баянхонгор аймгийн Баянговь сумын Малчин, 2022 он

Гуравт, “цагаан ямаат хоршоо”-ны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай

Дээрх гурван сэдвийн хүрээнд бид Баянговь сумын ноолуурын үйлдвэрлэл, түүнийг тойрсон нийгэм, соёлын асуудлыг ярилцах болно.

Цагаан Ямаа



Зураг 18. Залаажинстийн цагаан ямааны цөм сүрэг

Бидний судалгаа хийсэн Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст зэрэг сумын малчид алсаар дуниартан харагдах говь нутагт цагаан сувд шиг цайрах ямаан сүрэг өсгөж байна. Тус ямаан сүргийг “Залаа Жинстийн цагаан ямаа” хэмээн нэрлэдэг аж. Энэ нутгийн ямааг ажиглахад биеийн аль нэг хэсэгт өөр өнгийн толбогүй цагаан зүстэй, ихэвчлэн дунд зэргийн хэмжээний наран, гэдрэгээ хэлбэрийн эвэртэй, нүдний болор тод хар, зовхи бараан, сахлаг хялгастай, нарийн ноолууртай, өндөр, том биетэй, сүрлэг харагдаж байлаа. “Залаа жинст-Эдрэн” үүлдрийн ямааны цөм сүргийг Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр,

Баянговь, Баянлиг, Жинст, Богд, Баацагаан сумдад зонхилон үржүүлдэг. Баянхонгор аймгийн нийт ямааны 61,8%-ийг (2000 онд) эзэлнэ. 1980 оны дунд үеэс цагаан цайвар ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор өсгөж, Шинэжинст суманд нутгийн шилмэл цагаан ямааны сүргийг бий болгожээ. Ноолуур нь уян зөөлөн, торгомсог, хуурайшиж хугардаггүй, хялгас нь цагаан өнгөтэй. Ноолуурыг угаасны дараах цэвэр гарц 70.2-82.2 хувь хүртэл хэлбэлзэж, дундаж нь 78 хувь, ноолуурын урт 4.08-7.62 см-ын хооронд, ноолуурын голч 12.69-19.31 мкм-ийн хооронд хэлбэлзэж байна.⁸⁶

Малчдын Хоршоо

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ (МУ-ын Иргэний тухай хуулийн 36.4). Өргөн уудам газар нутагт аж төрж малчид хоорондоо холбогддог. Хөдөлмөрөө төрөлжүүлж тэндээсээ эдийн болон оюун санааны ашиг хүртэх бүтцийг хоршоо хэмээн тодорхойлж, түүнийг хөгжүүлэхийг МУ олон талаар хичээж байна. Түүний нэг нь малчдын хоршоо юм. Малчид хоршоог дараах байдлаар ойлгож буй бололтой. Тэд тодорхой зүйл дээр л нэгдэх бололцоотой байж болох юм. Тухайлбал, өөр өөрсдийн өвөлжөө бууцанд мал маллаж буй малчид тал талаасаа ноолуураа нийлүүлж, тодорхой стандартын дагуу бэлтгээд, хэн хэн хэдэн кг ноолуур нийлүүлснийг сайн бичиж тэмдэглээд борлуулж болох тийм арга ажиллагаа байж болох тухай малчид ярьж байна. Мөн ганц ноолуур бус хамтдаа малынхаа үүлдэр угсааг сайжруулж, мал маллах арга ажиллагаанд харилцан үр ашигтай байх бололцоог эрэлхийлж буй сайн жишгийн нэг Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст сумд дахь ноолуурын хоршоод юм.

Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Залаа Жинстийн цагаан ямааны омог дээрээ тулгуурласан “Цармын Цагаан Сувд”, “Цагаан ямаат” зэрэг хоёр хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

⁸⁶ Б. Нарантуяа, *Монгол үүлдрийн хэсэг, омгийн ямааны ноолуурын чанарын үзүүлэлт, цахим сан* (Улаанбаатар: ХААИС, 2009), 55–59.

“Цармын цагаан сувд” хоршоо

“Цармын Цагаан Сувд” хоршоо нь 2014 онд “Тогтвортой ноолуур” төсөл эхэлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Баянхонгор аймагт Баацагаан, Шинэжинст, Богд, Бууцагаан гэсэн сумдад үйл ажиллагаа голчлон явагддаг. Төслийн гол зорилго нь “малчидыг нэгтгэж хоршоо байгуулж ажиллавал үр өгөөж нь илүү юм байна” гэсэн үзэл санааны үндсэн дээр 2016 онд байгуулагджээ. Тус хоршоог Франц улсад төвтэй “хил хязгааргүй малын эмч нар ба агрономич” гэх ТББ дэмжиж буй аж. Тэд ноолуурт нэмүү өртөг шингээх, малчдын орлогыг нэмэгдүүлэх, бэлчээр орон нутгаа унаган төрхөөр нь хадгалах зэрэг зорилгыг гол болгон ажилладаг гэнэ. Уг хоршоо нь ногоон алт төслийн хүрээнд байгуулагдсан “Бэлчээр Ашиглагчдын Хэсэг” тулгуурлан байгуулагдсан байна. Энэ тухай Цармын Цагаан Сувд хоршооны дарга З.Амартүвшин,

Хил хязгааргүй малын эмч нар ба агрономич” ТББ маань уг төсөлд анхаарлаа хандуулж, зөвлөж, хамтарч ажиллаж байна. Тэр байгууллагад чинь монгол хүн ч байна, гадаад хүн ч байна. Мөн холбооны маань гүйцэтгэх захирлын зардал, хөрөнгийг шийдэж явдаг. Энэ хэдэн хоршоод маань өөрсдийн гэсэн хөрөнгө санхүүтэй, хөл дээр зогсож байгаа ч гэсэн холбоогоо санхүүжүүлээд явах хэдий болоогүй байгаа болохоор тэр төсөл маань санхүүжүүлж явдаг. Хоршоо байгуулснаас хойш ажилчдын цалинг 100% хариуцаж байгаад 2018 оноос больсон, унаа тэрэгний асуудлыг нь шийдэж өгсөн. Ноолуур түүхий эд хадгалах агуулах савыг нь бэлдэж өгсөн. Мөн дотоод урсгал зардлыг бүгдийг нь хариуцдаг байсан. 2020 оноос яг бие даасан үйл ажиллагаа хоршоод өөрсдөө хариуцаж эхэлсэн. Одоо Шинэ-идэр болон Баян-өндөр гэсэн сумуудтай хамтарч ажиллаж эхэлж байна. Ингээд 7 сум болгон ажиллаж байна. Миний мэдэхээр энэ төсөл маань одоогоор бусад аймгуудын 30 гаруй хоршоотой хамтарч ажиллаж байгаа юм. Мөн дундын хоршоогоо байгуулсан. Энэ хүрээнд үйл ажиллагаа ч жигдэрч байна. Бэлчээр төлөвлөлтийн менежмент эхлээд олон үйл ажиллагаа хамаардаг...⁸⁷

⁸⁷ Баянхонгор аймгийн Шинэжинст суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

хэмээн ярьж байлаа.

Тус хоршооны гол зорилго нь ноолуурт түшиглэсэн дундын аж ахуй, хөдөлмөр зохион байгуулалтын системийг бий болгох, малчидын хамтын ажиллагааг дэмжих зорилготой аж. Тус хоршооны удирдах зөвлөлд нь 7 хүн байдаг. Сумдын хоршооны дарга нар тус хоршооны удирдах зөвлөлд сонгогддог гэнэ. Шинэжинст сумыг төлөөлж хоршооны дарга З.Амартүвшин сонгогдсон гэнэ. Жинстийн дарга Баяр-Өлзий, Богдын дарга Дэмбэрэл, Бөмбөгөр Энхтайван гэх мэт хүмүүс байдаг аж. Аргагүй дэмжлэг үзүүлэх зорилгоор Туяа үйлдвэрийн захирал Бавуудорж гэх хүнийг удирдах зөвлөлдөө авчээ. Тус хоршооны гүйцэтгэх захирлаар Оюунгэрэл гэдэг хүн ажиллаж байна. Мөн ноолуурын үйлдвэрлэл, ямааны үүлдэр угсаа, гарц зэрэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор доктор Доржбатыг зөвлөхөөр удирдах зөвлөлдөө оруулжээ. Цармын Цагаан Сувд хоршоо бол гаднын байгууллагын дэмжлэгтэйгээр Ногоон алт төслийн суурин дээр байгуулагдсан малчидын бүлэг юм. Гэвч энэ хоршоо малчидын төсөөлсөн хэмжээний үр дүн, ашиг тусыг хараахан үзүүлж амжаагүй байна. Тэдний өөрсдийнх нь хэлж буйгаар,

Итали, Франц руу голчлон ноолуураа нийлүүлдэг. Мөн дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Бид бол нэмүү өртөг шингээх үүднээс угааж самнаж, бүтээгдэхүүн болоход нь бэлдэж борлуулна. Энэ бол малчидадаа ноогдол ашгийг олгоход чиглэдэг. Ноолуурын хэмжээгээр ноогдол ашгаа хүртэж байгаагаараа давуу юм... Хүн амын эрүүл мэнд анхаарч жилдээ 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарыг авчирч үзүүлдэг. Урлаг спортын үйл ажиллагааг намар 10 сард зохион байгуулдаг. Хоршооны хурлыг бол улиралд нэг удаа, жилд 2 болно. Тэргүүлэгчдийн хуралд хэд хэдэн удаа хуралдах шаардлага гардаг.⁸⁸

Тус хоршооны ажлын алба нь Улаанбаатар хотод байрладаг. Тэд хоршооны гадаад харилцааны асуудлыг ерөнхийд нь гардаж зохион байгуулдаг байна.

Ер нь малчидын хоршоог чиглүүлэх, гадаад дотоод түүхий эдийг зах зээлд борлуулах, зуучилах, гэрээ хэлэлцэл хийх зорилготой. Одоогийн

⁸⁸ Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Цармын цагаан сувд хоршооны дарга З.Амартүвшинтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

байдлаар 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Удирдах зөвлөлд нь 7 хүн байдаг. Сумдын хоршооны дарга нар байдаг. Шинэжинс дарга нь би, Жинстийн дарга Баяр-Өлзий, Богдын дарга Дэмбэрэл, Бөмбөгөр Энхтайван гэх мэт мөн аргагүй талаасаа гээд Туяа үйлдвэрийн захирал Бавуудорж гэх хүнийг удирдах зөвлөлдөө авсан. Мөн ноолуурын үйлдвэрлэл, ямааны үүлдэр угсаа, гарц зэргийг тодорхойлж гаргахад ажилласан байсан хөдөө аж ахуйн доктор Доржбат гэж хүн байна. Гүйцэтгэх захирал бол Оюунгэрэл гэж хүн бий...⁸⁹

Тогтвортой ноос ноолуур төсөл “цармын цагаан сувд” хоршоонд дараах дэмжлэг туслалцаа үзүүлдэг байна.

Хоршоо байгуулснаас хойш ажилчдын цалинг 100% хариуцаж байгаад 2018 оноос больсон, унаа тэрэгний асуудлыг нь шийдэж өгсөн. Ноолуур түүхий эд хадгалах агуулах савыг нь бэлдэж өгсөн. Мөн дотоод урсгал зардлыг бүгдийг нь хариуцдаг байсан. 2020 оноос хоршоо бие дааж, үйл ажиллагаагаа хариуцаж эхэлсэн. Одоо тус төсөл Шинэ-идэр болон Баян-өндөр гэсэн сумуудтай хамтарч ажиллаж эхэлж байна. Ингээд 7 сум болгон ажиллаж байна. Миний мэдэхээр энэ төсөл маань одоогоор бусад аймгуудын 30 гаруй хоршоотой хамтарч ажиллаж байгаа юм. Мөн дундын хоршоогоо байгуулсан. Энэ хүрээнд үйл ажиллагаа ч жигдэрч байна...⁹⁰

Тус хоршоо нь дүрмийн хүрээнд малчдын нийгмийн эрүүл мэнд, малын эрүүл мэнд рүү чиглэсэн дараах үйл ажиллагааг явуулж байна. Нэгд, малчидыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулдаг. Хоёрт, Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, хөгжүүлэх зорилгоор үзлэг, оношилгоо, үүлдэр угсаа сайжруулах ажил хийдэг аж.

⁸⁹ Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Цармын цагаан сувд хоршооны дарга З.Амартүвшинтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

⁹⁰ Баянхонгор аймгийн Шинэжинст суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он

Хүн амын эрүүл мэнд анхаарч жилдээ 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарыг авчирч үзүүлдэг. Урлаг спортын үйл ажиллагааг намар 10 сард зохион байгуулдаг. Хоршооны хурлыг бол улиралд нэг удаа, жилд 2 болно. Тэргүүлэгчдийн хурал хэд хэдэн удаа хуралдах шаардлага гардаг... (Баянхонгор аймгийн Шинэжинст суманд хийсэн хээрийн судалгааны тэмдэглэл, 2022 он).”

Тус хоршоо нь ноолуур бэлтгэхээс боловсруулах бүхий дамжлага процессыг малчидадаа танилцуулах ажлыг тогтмол хийдэг байна. Жил бүр хоёр тэргүүлэгч гишүүнээ Улаанбаатар хот дахь хоршооныхоо ажлын оффис, үйлдвэрлэлийн үйл явцтай танилцуулдаг байна. Жилийн эцсээр тайлангийн хурлаа хийж ноогдол ашиг олгодог.

Манайх гадаадын зах зээлд ноолуураа цэвэрлэж гаргадаг. Дараах хэд хэдэн шат дамжлага бүхий боловсруулалт хийж байна. Эхний түвшинд ангилан ялгалтад оруулдаг. Хоёрт, Угаана. Гуравт самнана. Би сая дээрх гурван шатны боловсруулалтад хяналтаар яваад ирлээ. Самналт гэдэг нь үйлдвэрийн аргаар хялгас ноолуурын хоёрын ялгадаг юм байна. Ер нь л утас болгоод ээрэхэд бэлэн болгосон гэсэн үг юм. Хялгас бүх юмнаас цэвэрлэхсэн гэсэн үг...⁹¹

Мөн тус хоршоо нь гишүүн малчидаасаа сумын зах зээлийн ханшаар арай өндрөөр ноолуур авна. Дараа нь гадаадад гаргаж борлуулсан цэвэр ашгаасаа тодорхой хувийн хоршооны нөөцийн санд, үлдсэнийг нь гишүүддээ хуваарилдаг. Нэг кг тутамд 10,000-20,000 төгрөг олгодог. Жилийн эцсийн үр дүнгийн хурлаараа гишүүдээ тайлан танилцуулж, ноогдол ашгаа хуваарилдаг. Эргэлтийн сангаасаа ноолуурын урьдчилгаа байдлаар 2 сая хүртэлх төгрөг олгодог. Малчид цагаан сараар, эмчилгээний шаардлагаар, гэнэтийн мөнгөний хэрэгцээ гарвал хоршооноос мөнгө зээлдэг. Хоршооны зээл нь хүүгүй байдаг байна. Хоршоонд элсэх малчин өрхүүдэд дараах үүрэг хүлээх болдог аж. Залаа Жинстийн цагаан ямаа малладаг байх ёстой. Тогтвортой ноос ноолуурын эвслийн 25 шалгуурыг хангаж

⁹¹ Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Цармын цагаан сувд хоршооны Тэргүүлэгч гишүүн Н.Надмидтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

ажиллах болдог. Дэвтэр хөтөлдөг. Тухайн дэвтрийг сайн хөтөлснөөр ногоон гэрчилгээ авдаг. Тус шаардлагыг хангасан малчин өрхөд “Ногоон гэрчилгээ” олгоно. Гэрчилгээтэй малчины ноолуурыг арай өндөр үнээр авдаг.

Хоршооны бүтэц бүрэлдэхүүний тухай тэргүүлэгч гишүүн Нямын Надмид ийнхүү ярих. Манайх чинь уртын багийн 19 бүлэгтэй. Бүлгээс 3 бүлгийг шалгаруулж авсан. Тэр үед би ахлагч байгаагүй. Богд, Бөмбөгөр суманд анх ажиллаж байсан. Сүүлдээ төсөл өргөжөөд манайханд хоршоо байгуулагдсан. Тогтвортой ноос ноолуурын холбоонд нэг тэргүүлэгч гишүүд тойргийн сумуудаас сонгогддог. Хоршоо даргатай нийлээд 5 тэргүүлэгч гишүүнтэй. Дарга нэмэх нь 4 малчин нар хоршооны тэргүүлэгч гишүүн болно. Хяналтын зөвлөлийн гишүүд гэж байна. Хяналтын зөвлөл таван хүнтэй байна. Нягтлан гэж байна. Мэргэжил арга зүйн багийн хүмүүс гэж бий. Тэд гишүүддээ мэргэжил аргазүйн зөвлөгөө өгдөг. Дэвтэр хөтлөлтийн заавар өгдөг туршлагатай хоршооны гишүүн малчид бас байна. Бүгдийн хурлаар хүмүүсээ сонгодог. Хоёр жил болоод ээлжит сонгуулиа явуулдаг.

Би эхлээд 2019 оноос хяналтын зөвлөлийн гишүүн байсан. 2021 оноос тэргүүлэгч гишүүн болсон. Бэлчээр ашиглагчдын хэсэг гэж бий. Би энэ хэсгийнхээ БАХ-ийн ахлагч хийж байна. Бас мэргэжил аргазүйн багийн гишүүнээр ажилладаг. Мэргэжил аргазүйн багийн гишүүдэд жилд хоёр удаа нэг өрх айлд 20,000 төгрөгөөр бодож, манай хэсэг чинь 15 өрхтэй. Надад буюу мэргэжил аргазүйн багийн гишүүнд 300,000 төгрөг бензиний зардал олгодог...⁹²

Хоршооны ноолуур борлуулах үйл явцын тухайд тэд хоршооны малчин өрхүүдээс цуглуулсан ноолуураа эмээлт захад “өгөөж шим” гэдэг боловсруулах үйлдвэрт хагас боловсруулж, гэрээт байгууллага руугаа илгээдэг байна. Самнасан ноолуураа пресс болгоод л гэрээ байгуулсан гадаадын компани руу явуулдаг. Гадаад компанитай гэрээ янз янзаар байгуулагддаг. Тухайлбал, 30 кг ээрсэн ноолуур авах, 30 кг самнасан ноолуур авахаар гэдэг ч юм уу? Гэрээний нөхцөлөөс хамаараад бид боловсруулалтаа хийгээд явуулдаг.

⁹² Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Цармын цагаан сувд хоршооны Тэргүүлэгч гишүүн Н.Надмидтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

Үйлдвэрийн хүмүүс чинь ноолуураа самнаад л байна. Манай хоршооны ноолуур ангилал, угаалт, самналтанд орох үед хянаж ажиллах үүрэгтэй явсан. 800 кг ноолуур орлоо гэхэд өдрийн хоёр ээлжээр ажилладаг юм билээ. Өдөрт хэдэн кг бохир ноолуур орж, хэдэн кг цэвэр ноолуур гарч ирэхийг хянаж байж байсан. Муугаар бодоход үйлдвэрийн ажилчид болон үйлдвэр ноолуураас ямар нэг байдлаар хомсдуулах эсэхийг хянах үүрэгтэй юм даа. Мөн 10 хоног нүдээрээ ноолуур ангилж, угааж, самнахыг л харлаа. Өглөө 07 цагаас орой 17 цаг хүртэл ажилладаг юм билээ. Нэг өдөрт 15 кг самнасан ноолуурыг 14 уугаар гаргадаг юм билээ. Тог энэ тэр тасарвал түүнээс бага гарна. Янз янз л юм байна. Зарим өдөр бол тог тасарвал ажиллахгүй юм билээ.⁹³

Ийнхүү цармын цагаан сувд хоршоо Шинэжинст суманд амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Баянговь сумын хувьд нэг онцлог зүйл бол “цагаан ямаат хоршоо” байв. Тус сумын иргэн Өлзийбодьжав олон жил ноолуурын Ченж хийсэн гэх бөгөөд нутагтаа “Цагаан ямаат” хэмээх хоршоо байгуулжээ. Энэ хоршоо нь орон нутгийн ханшаас арай өндрөөр худалдан ноолуур авч, гадагшаа худалдаалж буйгаараа ихээхэн ач холбогдолтой юм. Мөн сумандаа хоршооны байр барьжээ. Тэд малчидад гурван төрлийн үйл ажиллагаа явуулж буй тухай ярьж байв. Үүнд,

- Малчидын эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ үзүүлж байна. Тэд жил бүр Улаанбаатар хотоос мэргэжлийн эмч нарын баг бүрдүүлэн ирж, үнэгүй оношилгоо, зөвлөгөө өгдөг гэнэ.
- малын эрүүл мэнд, үүлдэр угсааг сайжруулах чиглэсэн үйлчилгээ.

“Цагаан Ямаат” хоршоо

Баянговь сумын төвөөр ороход нэгэн өвөрмөц цэнгэлдэх хүрээлэн байх бөгөөд тус наадмын талбайг тойруулан ногоон байгууламж байгуулж, усжуулалтын системд холбожээ. Тус наадмын талбайг “Наадам” хэмээн нэрлэжээ. Нутгийн

⁹³ Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Цармын цагаан сувд хоршооны Тэргүүлэгч гишүүн Н.Надмидтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он

иргэдээс асуухад “наадам” талбайг Цагаан Ямаат Хоршооны санаачилгаар гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулсан хэмээн ярьж байв.

Ийнхүү бид цагаан ямаат хоршооны үйл ажиллагааг сонирхож, нутгийн иргэд болон хоршооны албан хаагчдаас зарим үйл ажиллагааных нь тухай асууж тодруулав. Тус хоршоо нь “наадам цогцолбор”-ыг барьж байгуулснаас гадна сумын төвийн ундны усны асуудлыг шийджээ. Тэд Баянговь сумын төвд гурван гүний худаг гаргасан байна. Улмаар гурван худгаа цахилгаанд холбож, карттай болгожээ. Мөн гурван худгаасаа шугам татаж, сумын ногоон байгууламжийг услах, усжуулалтын систем бий болгосон гэнэ. Мөн цагаан ямаат хэмээх сүрлэг хаягтай том гэгчийн хоршооны байр барьсан байна. Тус хоршооны ажлын албанд 7 ажилтан ажиллах бөгөөд Улаанбаатар хотын төв оффист нь 3-4 хүн ажилладаг гэнэ.



Зураг 19. “Наадам фарк”, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он



Зураг 20. “Наадам фарк”, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он

Тус хоршоог Баянхонгор аймгийн Баянговь сумын уугуул Ж.Өлзийбодьжав үүсгэн байгуулжээ. Ж.Өлзийбодьжав нь эдүгээ “Баялаг өлзий” ХХК-ны захирлаар ажиллаж байна. Тэрээр 1990 оноос Баянговь сумаас ноос, ноолуур бүхий малын түүхий эдийг худалдан авч, дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэх, гадаад зах зээл (Хятад, Европ)- д гаргах ажлыг хийжээ. Тэр туршлага дээр тулгуурлан ноолуурын салбарт нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл буй болгосон нь “Bodios cashmere” аж.

Малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж дэлхийн зах зээлд гаргана гэдэг нь өөрөө монголчуудын зайлшгүй хийх ёстой бизнесийн нэг. Малчид нь үйлдвэрлээд байдаг үүнийг нь хэн нэгэн нь боловсруулж дэлхийн зах зээл дээр гаргахгүй л юм бол хятадуудын түүхий эд болж хувирна. Иймээс өөрсдөө л түүхий эдээ ашиглах ёстой гэдэг үүднээс бизнесээ эхлүүлсэн. Эхэндээ малчидаас түүхий эд авч, дотоодын үйлдвэрүүд, Хятад, Европын зах зээлд нийлүүлдэг байлаа. Энэ туршлага дээрээ тулгуурлаж нэмүү өртөг шингээж бүтээгдэхүүн үйлдвэрлэе гэж шийдсэн.⁹⁴

⁹⁴ Ж. Өлзийбодьжав, breaking news.mn сайтад өгсөн ярилцлага, 2017 он.
<http://www.breakingnews.mn/c/r/56400.htm>

Тэрээр нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхлэхээр зорьсон үйл хэрэг нь Баянхонгор аймгийн зарим сумдад хэрэгжиж буй “Цагаан Ямаат” Хоршоо юм. Тус хоршооны үйл хэргийг тухай дор дэлгэрүүлэн өгүүлье!



Зураг 21. Цагаан Ямаат Хоршооны Баянговь сум дахь байр, 2022 он

Цагаан ямаат хоршооны бүтэц бүрэлдэхүүн

Тус хоршоо 2019 онд байгуулагджээ. Тухайн үед 180 өрх айл гишүүнээр элссэн байна. Улмаар 2020 онд 300 гаруй гишүүн малчин өрхтэй болж, үйл ажиллагааны хүрээ нь улам өргөжин тэлжээ. 2021-2022 оны хооронд гишүүдийн тоо 500 орчим болж өргөжсөн байна. Тэд хоршоондоо 200--аас дээш малтай хүнийг хоршооны гишүүнээр авдаг бол 1000--аас дээш малтай малчидыг гишүүнчлэлээр авдаггүй гэнэ. Хоршооны гишүүдийн хурлаар хоршооны даргыг сонгодог бөгөөд хоршооны төв оффисоос батламжилна. Хоршооны ажлын алба нь 7 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Хоршооны дарга ажлын албыг шууд удирдлагаар хангаж ажиллах, дээд удирдлагын баг, хоршооны гишүүн өрхүүдийн хооронд холбогч гүүр болж ажилладаг байна.

Хоршооны ажлын алба нь Баянговь суманд байнгын долоон хүний орон тоотой ажиллаж байна. Би өнгөрсөн 2021 оны 12-р сард сонгогдсон. Өмнө нь Гантулга гэж хүн байсан. Манай хоршооны нягтлан бодогч Алтантуул гээд хүн энд сууж байна. Үйлчилгээний ажилтан хоёр (эрэгтэй, эмэгтэй) байдаг. Нэг жолооч, нэг малын их эмч, нэг мал зүйчтэй. Манай хоршооны төв Улаанбаатар хотод байрладаг. Манайх гадаад руу ноос, ноолуураа экспортолдог. Улаанбаатар хотод 4 хүн ажилладаг. Манай гадаад харилцааны асуудал, ноолуурын үйлдвэрлэлийг хариуцан ажиллаж байна. Манай малын эмч нар тарилга туулга хийгээд дууссан. Одоо угаалгын ажилтай явж байна. Манай хоршоо дөрвөн сумын 500 гаруй өрхтэй. Залаа Жинстийн Цагаан ямааг голлон өсгөж буй сумуудад гишүүдтэй...⁹⁵

Дээрх өгүүлэмжид дурдсанаар тэд дөрвөн сумын 500 орчим гишүүн өрхтэй. Тэдгээр гишүүн өрхөө бүлгийн зохион байгуулалтад оруулжээ. Нийт 12 бүлэг ажиллаж байгаа аж. Нэг бүлэгт 40-60 орчим гишүүн өрхтэй.

Нэг бүлэг 40-60 өрхтэй байна. Баян-өндөр сум гэхэд л хоёр бүлэгтэй. Шинэжинст рүү хоёр бүлэгтэй. Баянговь сумандаа 7 бүлэгтэй. Баяндэлгэр суманд нэг бүлэгтэй. Бүлгийн ахлагч руу мэдээллээ өгчихнө. Тэр хүн бүлгийнхээ зохион байгуулаад үйл ажиллагаандаа оролцуулна даа. Ийм үйл ажиллагаа явагдах нь байна шүү. Идэвхтэй хамрагдаарай гээд боллоо...⁹⁶

Бүлгийн ахлагч нар тодорхой үүрэг хариуцлага хүлээх тул жилдээ нэг удаа 1500,000 төгрөгийн урамшуулал олгодог байна. Хоршооноос зохион байгуулсан сургалт, уулзалт, зөвлөгөөнд бүлгийн ахлагч малчин өрхүүдээ зохион байгуулалтаар хангаж, оролцоог хангах үүрэг хүлээдэг аж. Шаардлагатай бензин, бусад зардлыг хоршоо гаргаж өгдөг гэнэ. Малчидад мэдээлэл хүргэх хамгийн шуурхай арга бол дамжуулж мэдээлэх аж.

⁹⁵ Цагаан ямаат хоршооны дарга Ариунсантай хийсэн ярилцлагын тэмдэглэл, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он

⁹⁶ Цагаан ямаат хоршооны дарга Ариунсантай хийсэн ярилцлагын тэмдэглэл, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он

Ямар нэг ажил зохион байгуулах үед бензиний зардлын тооцож олгодог. Айлуудаар явж зар түгээх бол шаардлагатай зардлыг хоршооноос олгодог. Зарим тохиолдолд бүлгийн ахлагч нартаа сургалт өгнө. Бүлгийн ахлагч цаашаагаа малчидадаа мэдээллээ дамжуулдаг. Ийм байдлаар үйл ажиллагаа их явдаг. Малчидын онцлог бол цуглахдаа муу шүү дээ. Энэ нь хүмүүс идэвхгүй дээ биш юм. Мал аж ахуй өөрөө тийм боломж олгодоггүй онцлогтой.⁹⁷

Хоршооны бүлгийн зохион байгуулалтаар үйл ажиллагааныхаа зар мэдээллийг түгээх бөгөөд хоршооны гишүүдэд чиглэсэн дараах үйл ажиллагаа, урамшуулалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Малчидын эрүүл мэндийн үзлэг, оношилгоо

Малын үзлэг оношилгоо, угаалга, тарилга, туулга үнэгүй хийж байна.

Цагаан сараар гишүүн өрхүүддээ цагаан сарын тавгийн бооцог бэлэглэдэг.

1 сая хүртэлх төгрөг ноолуур гарах хүртэл урьдчилгаа болгож өгдөг.

Тус хоршооноос санаачилан зохион байгуулж малчидын эрүүл мэндийн үзлэг ихээхэн үр дүнтэй ажил болсон байна. 500 орчим өрх айлын 1000 орчим хүнд эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийжээ.

Өнгөрсөн жилийн эрүүл мэндийн үзлэгээр 10 гаруй малчин хорт хавдрын эхэн үед дээрээ оношлогдож эмчлэгджээ. 1 дүгээр үе, 2 дугаар үе дээрээ байгаа хүмүүс нь эмчлэгдэж байна. Хүнд шатандаа орчихсон хоёр хүн байжээ. Тэр хоёр л харамсалтай өнгөрчихлөө. 8 дугаар сард үзүүлээд анх онош нь тодорлоо. Тэгээд явсаар байгаад л 1 сард бурхан боллоо. Малчид маань тэрийгээ ч мэдэхгүй явж байсан байна шүү дээ. Эрт тийм үзлэг хийсэн бол бага дээр дараад авах байсан юм. Малчдыгаа эрүүл байлгах. Жилд нэг удаа заавал үзлэг хийж байя гэсэн тууштай бодлого баримталж байна. Бид нар хэсгийн ахлагч нарт хэлж байгаа юм. Заавал өрх бүрээс хоёр хүн хамруулаарай. Ноднин жил гайгүй байсан хүмүүс өөрийнхөө оронд хүүхдээ ч юм уу? Ах дүү нараа хамруулж болно шүү гэж хэлээд байгаа юм. Хоршооны гишүүн өрхөөс хоёр нь хүн л гэж байгаа

⁹⁷ Цагаан ямаат хоршооны дарга Ариунсантай хийсэн ярилцлагын тэмдэглэл, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он

юм. Тэгэхгүй бол бүгдийн гэгчхээр 500 өрхийн бараг 1500 гаруй хүн болчихно шүү дээ. Бид жилд бол 500 өрхийн 1000 хүнийг үзлэг хамруулахаар төлөвлөж ажиллаж байна. Хоршооны гишүүн өрх нэмэгдвэл мэдээж тоо өсөөд явах байх. Эдгээр хүмүүсийг үзлэг хамруулна гэдэг чинь бас их зардал шүү дээ...⁹⁸

Тус үйл хэрэг малчидын эрүүл мэндийг дэмжсэн тустай үйл хэрэг болсон тухай нутгийн иргэд ам сайтай байна. Мөн малчдын эрүүл мэндийг дэмжиж, хот руу эмчилгээнд явж байгаа малчидад тодорхой хэмжээнд санхүүгийн дэмжлэг олгодог тухай хоршооны удирдлага ярьж байлаа.

⁹⁸ Цагаан ямаат хоршооны дарга Ариунсантай хийсэн ярилцлагын тэмдэглэл, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он




Зураг 22. Зураг 11, цагаан ямаат хоршооноос зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэг, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2023 он



Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүрийн 2023 оны шимэгчтэх өвчинөөс урьдчилан сэргийлэх эмчлэх угаалга, туулгалтын арга хэмжээнд хамруулсан малын тоо харьцаа



| № | Үйлчилгээний нэр | Сумын нийт дүн | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн нэрс | | |
|----|------------------|----------------|--|------------|------------------|
| | | | Бодиос кашемир | Шинэ Ололт | Есөн эрдэнэ говь |
| 1. | Угаалга | 54518 | 18383 | 25448 | 10687 |
| 2. | Туулга | 60181 | 46097 | 7895 | 12189 |



Зураг 23. Цагаан ямаат хоршооноос зохион байгуулсан мал эмнэлгийн үйлчилгээний үзүүлэлт, 2023 он

Малын үүлдэр угсаа, эрүүл мэндийн үйлчилгээ

Тэд Залаа Жинстийн Цагаан ямааны угшлыг төгөлдөржүүлж ажиллаж байна. 16,2 микронтой ноолуур бэлтгэхэд анхаарч ажиллаж байгаа гэнэ. Тус хоршоо нь үржлийн ухна өсгөдөг. Хоршооны ухныг ноолуурын микроныг лаборатори шинжлүүлээд шаардлага хангасан ухныг үржилд ашиглаж байна. Хоршооны гишүүн өрхдөө шаардлага хангасан ухнаар хангадаг. Ингэж чанартай ноолуур бэлтгэх бололцоо бүрдэж байна. Ухныхаа эрүүл мэндийг нь мөн бүх талаар анхаарч байгаа. Тарилга, туулга, малчидын өвөлжөө хаваржааны ариутгал, малчидын хүссэн бүх зүйлийг хийх боломжтой байна. Хоршооны жолооч

ковштой. Ковшоороо өвөлжөө бууцны хэрзэн малтах, зам талбай янзлах гээд бүхнийг л хийж байна.

Ноолуурын баяр: Малчидад чиглэсэн урамшуулал

2019 онд гантай жил тохиосон тул 670 сая төгрөгийн өвс тэжээлийг зээлээр тараажээ. Тус өвс тэжээлийн зардлыг малчид ноолуурынхаа орлогоор төлсөн байна. Тэд жилд бид нар өвс тэжээлийн захиалга авдаг. Цаг хэцүү болохоор бол хөнгөлөлттэй нөхцөлөөр өвс тэжээлээр хангана. Тус асуудлыг бүлгийн ахлагч нарын хурлаар ярилцаж байгаад шийддэг гэнэ. Тус хоршооноос малчидын үйл хэргийг урамшуулах зорилгоор хэд хэдэн бодлого хэрэгжиж байна. Үүнд, 2021 оноос жил бүр ноолуурын баяр гэж хийх болжээ. Уг баяраар гурван жил дараалан тушаасан ноолуурын дундаж уялдуулан мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагаа гэнэ. Жишээ нь, малчин Дондогийн гурван жилийн турш хоршоонд тушаасан ноолуурын дундаж 125 кг гэж үзвэл $125 \times 10,000 = 1.250.000$ төгрөгийн урамшуулал олгодог аж.

Бид 3 жилийн турш тушаасан ноолуурын дунджийн гаргадаг. Түүнд 10,000 төгрөгийн урамшууллыг 3 жил тутамд нэг удаа олгодог. Манайх 9 сард ноолуурын баяр гэж хийдэг. Тэр баяр дээрээ урамшуулал олгодог. 2019 онд элссэн өрхүүд урамшууллаа авсан. Энэ жил (2022 он) төсөв хэлэлцсэн 180 орчим сая төгрөг олгохоор байна. Эргэх холбоотой ажиллах зорилгоор урамшууллын бодлого баримталж байна...(Цагаан ямаат хоршооны дарга Ариунсантай хийсэн ярилцлагын тэмдэглэл, Баянхонгор аймгийн Баянговь сум, 2022 он).⁹⁹

Ноолуурын баяраар малчидад урамшуулал олгохоос гадна дараах үйл ажиллагаа болдог гэнэ.

Бэсрэг наадам (морь, бөх, сур харваа)

Урлагийн үзүүлбэр

Болзолт уралдааны шагнал

Шилдэг сүрэгтэй малчин өрх

Шилдэг хашаа, хороотой малчин өрх

⁹⁹ Ариунсан, Цагаан ямаат хоршооны дарга, Баянхонгор аймгийн Баянговь сум, ярилцлага авсан Sainbuyan Mijid, 2022, <http://zotero.org/groups/4737731/items/SVLGDWFW>.

Шилдэг хот айл зэргийг шалгаруулна.

Ийнхүү ноолуурын баяраар урлаг соёлын үйл ажиллагаа болохоос гадна шилдэг малчидын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн мөн болдог аж. Тэд ноолуурын баяраас гадна цагаан сарын баяраар малчидадаа мөн урамшуулал олгодог. Үүнд, нэг өрх айлд 25 ш боорцог, суурь еэвэн, 1 кг чихэр олгодог байна. Мөн ноолуурын урьдчилгаа мөнгө болгож 1 сая төгрөг хүүгүй олгодог аж.

Цагаан сарын баярыг угтаж, Цагаан Ямаат хоршооноос олгодог энэ чинь хүмүүст их нэмэр болдог...¹⁰⁰



Зураг 24. Цагаан сарын баярыг угтан малчдад олгож буй урамшуулал, 2023 он

¹⁰⁰ Баянхонгор аймгийн Баянговь сумын малчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2022 он



Зураг 25. Цагаан сарын баярыг угтан малчдад олгож буй урамшуулал, 2023 он

Ийнхүү Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь сумуудад Олон Улсын байгууллагын дэмжлэгтэй “Тогтвортой ноолуур” хэмээх үзэл санааны хүрээнд дээрх хоёр хоршоо амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Цагаан ямаат хоршооны нэг онцлог бол явуулж буй үйл ажиллагаа нь хөзрийн хоёр тал шиг тайлбар бүхий үзэл санааг бий болгож байна. Хачирхалтай нь “Naadam” брэндийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Монгол улсын Баянхонгор аймгийн Баянговь суманд хэрэгжүүлж буй төсөл мэтээр олон улсад танилцуулагджээ. Тэд монголын өргөн уудам тал нутагт “Наадам” брэнд тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлж, бэлчээрийн зохистой ашиглалтыг дэмжиж буй тухай мэдээлэл цацаж байна. Мөн ноолуур үйлдвэрлэгч буюу малчидын ахуй амьдралд таны худалдан авсан ноолууран хувцасны тодорхой хувь хөрөнгө оруулалт байдлаар зарцуулагдаж байна гэх мэт сурталчилгаа олон улсын зах зээлд хийж буй аж. Гэтэл орон нутагт Ж.Өлзийбодьжав хэмээх хүний үүсгэн

байгуулсан “Цагаан Ямаат” хоршоо малчидыг дэмжиж ажиллаж буй мэт ойлголтыг төрүүлж буй ажээ.

Бүлгийн дүгнэлт

Ургамлын бүрхэвч тачир сийрэг, төрөл зүйл нь цөөн хэдий ч тэжээллэг чанар сайтай, урт үндэстэй, ганд тэсвэртэй, үр үндэс нь олон жилийн дараа ч сэргэн ургаж чаддаг онцлогтой говь нутгийн ард түмний амьжиргааны гол эх үүсвэр ямаа, тэмээ хоёр гэдгийг бид мэдэх билээ. Энэ л өргөн уудам бүс нутгийн амьдралын нэг эх булаг ямаа, түүнийг дагасан эдийн засаг, соёлын эх ундраг болсон ноолуур юм. Ямааг тэд бэлчээр сөрөг нөлөөтэй гэж боддоггүй. Говь нутагт *“жилдээ хоёр бороо орчихвол он болно”* гэх итгэл үнэмшилтэй аж төрж байна. Ноолуурын ханш хонины ноосны чинээ болсон ч тэд ямаа, тэмээ хоёроо өсгөсөөр байх төлөвтэй байна. Учир нь, ноолуур бол малчидын амьдралын гол хэд хэдэн эх үүсвэрийн нэг болохоос биш бүх зүйл нь биш аж. Яг үнэндээ тэд ноолуурын төлөө ч ямаагаа өсгөөд байгаа юм биш аж. Говийн бүс нутагт адгуулахад ямаа л хамгийн тохиромжтой сүрэг болохоор ямаа өсгөж байна.

ДүГНЭЛТ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ын хүрээнд аж үйлдвэрийн салбарт ч тогтвортой, байгаль орчинд ээлтэй байх үзэл санаа орж ирсэн. Үүний нэг нь хөдөө аж ахуй, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний салбар дахь тогтвортой ноолуур хэмээх ойлголт юм. “Тогтвортой ноолуур” гэсэн нэр томъёо нь тогтвортой хөгжлийн шалгуурыг хангасан ноолуур буюу байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох гэсэн утгатай юм. Энэ нэр томъёог Монгол Улс төдийгүй олон улсын хэмжээнд өргөн хэрэглэдэг болж байна. Тогтвортой ноолуурын үйлдвэрлэлийн үйл явц нь түүхий эд бий болгох буюу ямаа маллах, өсгөж үржүүлэхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгчийн гар дээр очих хүртэлх цогц үйл юм.

Энэхүү судалгаанд бид тогтвортой ноолуурын үйлдвэрлэлийн эхний үе шатууд болох малчны хот дахь ямаа маллах, өсгөж үржүүлэх, ноолуур самнах зэрэг үйл явц дахь соёлын тайлбар, ёсзүйн тайлбаруудыг судлан шинжиллээ.

Ямаа маллах, өсгөж үржүүлэх нь монголын бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин малчидын мал маллах арга ухааны нэг хэсэг юм. Тиймээс энэ нь “нүүдэлчдийн зан үйл, мал маллах арга ухаан” хэмээх соёлын биет бус өвийн нэг хэсэг болохыг бид энд онцолмоор байна. Гэвч тогтвортой хөгжилтэй холбоотойгоор бэлчээрийн доройтол, цаг уурын өөрчлөлт, цөлжилт зэрэг байгалийн доройтолд бэлчээрийн мал аж ахуй, тэр дундаа ямааны аж ахуйг буруутгах хандлага байна. Харин нүүдлийн мал аж ахуйн уламжлалт арга ухааныг орчин үеийн нөхцөлтэй нийцэхгүй гэж үзэхийн оронд өнөөгийн нийгэм, эдийн засгийн тогтолцоо, нөхцөл байдал нь малчдын уламжлалт арга ухаанд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхлэх чадвартай хэр зэрэг зохицож буй эсэхийг судалж шинжлэх нь үр ашигтай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг экологи, эдийн засгийн хувьд тогтвортой буюу байгаль орчинд ээлтэй, гэхдээ энэ үйлдвэрлэлийн тогтолцооны тогтвортой байдалд малчидын өөрсдийнх нь шууд хяналтаас гадуур гадаад хүчин зүйлс буйг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Бидний хээрийн судалгаа явуулсан Өмнөговь, Баянхонгор аймгийн говийн бүс нутаг нь ургамлын бүрхэвч тачир сийрэг, төрөл зүйл нь цөөн хэдий ч тэжээллэг чанар сайтай, урт үндэстэй, ганд тэсвэртэй, үр үндэс нь олон жилийн дараа ч сэргэн ургах чадвартай байдаг онцлогтой. Говь нутгийн энэхүү байгаль, цаг уурын онцлогт ямаа, тэмээ хоёр зүйлийн мал ард түмний амьжиргааны гол эх үүсвэр болж ирсэн. Судалгаанд оролцогчид бэлчээрийн доройтол, байгаль орчны доройтлын үндсэн шалтгаан нь зөвхөн ямаа өсгөн үржүүлэхтэй холбож үзэхгүй байна. Үүнд, олон хүчин зүйлс нөлөөлж буйг харгалзан үзэх хэрэгтэй юм. Ноолуурын эдийн засгийн ханш хонины ноос шиг бага үнэлгээтэй болсон ч судалгаанд оролцогчид ямаа, тэмээ хоёроо өсгөсөөр байна гэж үзэж байна. Учир нь, ноолуур бол малчидын амьдралын хэд хэдэн эх үүсвэрийн нэг болохоос биш цор ганц эх үүсвэр нь биш юм. Малчид зөвхөн ноолуурын төлөө ямаа өсгөж, маллаж байна гэж үзэхээс илүүтэй говийн бүс нутагт маллахад хамгийн тохиромжтой сүрэг учраас ямааг маллаж буйг ойлгох хэрэгтэй юм.

Мөн бид соёлын үүднээс тогтвортой бүтээгдэхүүнийг тодорхойлохдоо соёлын олон төрлийн үйл ажиллагааг дэмжсэн бүтээгдэхүүн гэж үзэж байна. Гадаад харилцагчид монгол малчидыг “ноолуур нийлүүлэгч” төдийхнөөр харж байна. Өөрөөр хэлбэл малчид ноолуураас орлого олохын тулд ямаа өсгөдөг гэсэн дан ганц эдийн засгийн өнцгөөс харж байна. Гэвч үнэн хэрэгтээ ямаа нь нүүдэлчдийн зан үйлийн олон талт тогтолцооны нэг чухал хэсэг болж байна. Нүүдлийн соёлын амьд байдал нь малчид зөвхөн ямаа өсгөн, маллагч биш, харин цагаан идээ үйлдвэрлэгч, айраг үйлдвэрлэгч, эсгий үйлдвэрлэгч, байгалийн баялаг хураагч, уул, ус, овооны харуул, уяачид гэх мэт олон ажил үүрэгтэй, өргөн мэдлэг, арга ухаантай байдгаас шалтгаална. Тиймээс ноолуур зэрэг бүтээгдэхүүний эдийн засгийн үнэ цэнэ нь зөвхөн материаллаг шинж чанар, тухайлбал, эслэгийн микрон чанараас хамаарахгүй, харин тухайн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгчдэдээ буюу нүүдлийн малчидадаа соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалахад хэр зэрэг тусалж байгааг анхаарах хэрэгтэй.

Бид хээрийн судалгааны үр дүнд үндэслэн малчидын ахуй амьдралд ноолуур хоёр төрлийн үр ашиг бий болгож байна хэмээн үзэж байна. Нэгдүгээрт, эдийн засгийн үр ашиг. Эдийн засгийн үр ашгийг тухайн өрхийн орлогын бүхий л эх үүсвэрийг тооцож үзэж байж тодорхойлох шаардлагатай. Бидний судалгааны

хүрээнд малчин өрхийн жилийн нийт орлогын 30-50 орчим хувийг ноолуурын орлого бүрдүүлж байна. Мөн малчид нэг жилээс хэдэн арван жилээр эдийн засгийнхаа тооцоолол хийж, үе шаттайгаар амьдрал ахуйдаа хөрөнгө оруулалт хийж буйг энд дурдах хэрэгтэй. Зарим тохиолдолд малчид орлогоороо Улаанбаатар хот, аймгийн төвд үл хөдлөх хөрөнгө худалдаж авах болжээ. Энэ мэт томоохон хөрөнгө оруулалтад зориулж банкны зээл авах, зээлийн эргэн төлөлтөө ноолуурын орлогоор бүрдүүлэх байдал ажиглагдаж байна.

Хоёрдугаарт, ноолуур нь бэлчээрийн мал аж ахуйн соёлын салшгүй нэг хэсэг болж байна. Малчид хэдийгээр таван хошуу мал сүргийг харилцан адилгүй бүтэцтэй өсгөж байгаа ч ямааны буй болгож буй соёлын үр ашиг бага биш юм. Тухайлбал, ямааг “буян хишгийн аргамж” хэмээн үзэх тохиолдол ч байна. Мөн ямаа сэтэрлэх зан үйл, ямааны бөөрний өөхийг бурхны шашны тосон урлалд өргөн ашиглах гэх мэтээр ямаатай холбоотой соёлын агууламж их байна. Үүний нэг тод жишээ нь, ямааны бөөрний өөхөөр урласан 70 жилийн настай тосон урлал Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж байна. Мөн малчидын ноолуур үйлдвэрлэх бүхий л үйл явц нь тэдний нийгмийн сүлжээ, харилцаа холбооны олон талт байдлыг үүсгэж байдгийг судалгааны явцад ажиглав. Энэ ямаа маллах, ямаа самнах, ноолуураа худалдаалах гэх мэт үйл явцууд нь малчидын нутаг, гол усныхантайгаа харилцах, цаашлаад Улаанбаатар хот, аймгийн төвийнхөнтэй харилцах, нийгмийн сүлжээний нэг шалтгаан болж байгаа юм. Энэ нь эргээд нийгэм, соёлын солилцоонд хувь нэмэр оруулж байна.

Нөгөөтэйгүүр судалгаанд оролцогчдын жараас дээш хувь нь ноолууран оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шатыг огт сонирхож судалж байгаагүй байна. Мөн ноолууран бүтээгдэхүүн нь өөрөө малчидын өдөр тутмын хэрэглээнд зохицдоггүй, гарын ая даахгүй гэсэн хандлага түгээмэл ажиглагдаж байна. Үүнтэй холбоотойгоор ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шатыг гадаадынханд үзүүлж танилцуулах нь чухал хэмээн судалгаанд оролцогчид үзэж байна. Учир нь малчид тогтвортой ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл явцыг гол төлөв хот дахь үйлдвэр, борлуулалт, түгээлт зэрэг процессоор ойлгож байна. Харин энэхүү үйлдвэрлэлийн үйл явцын нэг хэсэг нь мал маллах, ямаа өсгөж үржүүлэх, эмнэх домнох, түүнтэй холбоотой ёс заншил, соёл уламжлал болох тал дээр судалгаанд оролцогчид бага ач холбогдол өгч байна. Үүнийг харгалзан үзэж

малчидад өөрсдийнх нь эрхэлж буй бэлчээрийн мал аж ахуй, түүний холбогдох соёлын өвүүд, ёс заншил, өв уламжлал зэрэг нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл явцын үнэ цэнтэй чухал хэсэг гэдгийг таниулах, сурталчилах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Ном зүй

- Азаров, С. «животноводческая техника кочевого хозяйства». *“Современная Монголия”*, 1933, 2.
- Ариунсан. Цагаан ямаат хоршооны дарга, Баянхонгор аймгийн Баянговь сум. Ярилцлага авсан Sainbuyan Mijid, 2022.
<http://zotero.org/groups/4737731/items/SVLGDWFW>.
- Баттогтох, Рулам. Лусын Сэрчим хошооны дарга, ЕБС-ийн насан туршийн боловсролын багш. Өмнөговь аймаг, Номгон сум. Ярилцлага авсан Мижид Сайнбуян & Наранбаатар, 2022.
<http://zotero.org/groups/4737731/items/5N448UA7>.
- Баттулга, & Саранцэцэг Баасансүрэн. Ноолуур: "Цагаан алт". Архангай аймаг, Ихтамир сум, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/ZZA2YIUJ>.
- Болодон, И.Б. «К вопросу о хотонах». *“Современная Монголия”*, no 2 (1938): 27.
- БСШУС-ын сайд. Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалын 1-р хавсралт (2019).
<http://ncch.gov.mn>.
- Бурханч лам Пүрэвбат. «#МАЛ СЭТЭРЛЭХ #занүйл». Facebook, 18 Долдугаар сар 2020.
<https://www.facebook.com/photo.php?fbid=2780440188895227&id=1784885881784001&set=a.1814605292145393>.
- Ганболд, И. «Монгол малчдын бэлчээр ашиглах уламжлал ба орчин үе». Түүхийн ухааны докторын зэрэг горилсон судалгааны ажил, МУИС, 2013.
- Гонгор, Д. *Халх товчоон (= Краткая история Халхи)*. Улаанбаатар, 1978.
- Грайворонский, В. *От кочевого образа жизни коседлости, М*, 1979.
- Даваагийн Баасандорж, Жаргалын Доржпүрэв, Волоожийн Шинэнэмэх, & Доржийн Энхтуяа. *Монголын ноос ноолуурын салбарын тогтвортой үйлдвэрлэлийн гарын авлага*. Улаанбаатар: Европын Холбооны Монголын текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко-гэмдэг төсөл, 2020.

- https://cdn.greensoft.mn/uploads/users/2708/files/A_2_1_4%20Sus%20production%20handbook%20MO%20print.pdf.
- Денисов, Н. *Животноводство МНР*. Уб, 1946.
- Дөнгө, Д. «Говь гурван сайхан ямааны ноолуурын ашиг шимийг сайжруулж, батжуулах арга зам. Хөдөө аж ахуйн амьтдын үржүүлэг, селекци», 1995.
- Ё.Загдсүрэн, Б.Мандах, К.Макгуар, & А.Файн. *Ямаачдын өврийн ном*. Улаанбаатар, 2000.
- Жагравал, Н. *Аратство и аратское хозяйство*. Уб, 1974.
- Ж.Самбуу. *Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга*. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр, 1945.
- Загдсүрэн, Ё., ред. *Монголын ямаа судлал: 80 жилд*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс, 2011.
- Ито, К. «Говь нутгийн хот айл, түүний бүтэц ба онцлог». In *Олон улсын монголч эрдэмтэдийн VII хурал, Vol VIII*. Уб: “Чойлжил” ХХК-д хэвлэв, n.d.
- М. Даш. *Монгол орны билчээрийн мал маллагааны арга туршлага*. УБ: УХХЭХ, 1966.
- Майский, ИМ. «современная монголия». Иркутск, 1921.
- Масленников, В. *Монгольская Народная Республика на пути к социализму*. М, 1951.
- Мелешко, А. «Вопросы кочевничества». *Журн соврем монг*, 1935.
- Н. Алтантуяа. Бүх ямаагаа зарсан айлын эзэгтэй. Архангай аймаг, Ихтамир сум, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/WZG8ZNNHR>.
- Нарантуяа, Б. *Монгол үүлдрийн хэсэг, омгийн ямааны ноолуурын чанарын үзүүлэлт, цахим сан*. Улаанбаатар: ХААИС, 2009.
- Норов, Батжаргал. ямаа бол амьдралын эх булаг. ямаа бэлчээр талхалдаггүй. Ярилцлага авсан Мижид Сайнбуян, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/EV2U3HZJ>.
- Ням-адьяа. ноолуур ангилж авдаг. Өмнөговь аймаг, Номгон сум. Ярилцлага авсан Баяртогтох, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/8EEQU2AX>.
- Сахьяа, Ц., & Г. Маналжав. *Түүхий эд бэлтгэлийн ажиллагаа: Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1985.
- Симуков, А. «Хотоны». *“Современная Монголия”*, no 3 (1933).

- Стандарт, хэмжил зүйн газар. «Текстилийн тогтвортой үйлдвэрлэл – Удирдамж», 2021. <https://old.estandart.gov.mn/standart/v/6778>.
- Т. Долгоржав. Ямаа амьдын үнийнхээ 50%-ийг жил бүр өгдөг. Архангай аймаг, Ихтамир сум. Ярилцлага авсан Пагмадулам Мэндмаа, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/FN44RANK>.
- Т. Оюунчимэг. Ямаа-буяны аргамж. Архангай аймаг, Ихтамир сум, 2022. <http://zotero.org/groups/4737731/items/676RL3M4>.
- Тогтвортой ноос ноолуурын эвсэл. *Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал*. SFA, 2022. https://sustainablefibre.mn/wp-content/uploads/2022/05/MN_C001-Animal-Husbandry-and-Cashmere-Fibre-Harvesting-Code-of-Practice-1.pdf.
- Хай, Мэтэ Мэри. *Аюултай хишиг: Монголын албан бус алтны уурхайн эдийн засаг дахь хөрөнгө ба эцэгчлэл*. Улаанбаатар, 2012. <https://research-repository.st-andrews.ac.uk/bitstream/handle/10023/5510/high2010AyultaiKhishig.pdf>.
- Хамфри., Кэролин, & Дэвид Снит. *Нүүдэллэхүйн ёсон эцэслэх үү?, (Өвөр азийн нийгэм, төр, хүрээлэх орчин)*. Улаанбаатар: Интерпресс хэвлэлийн үйлдвэр, 2006.
- Хүсэхүй. *Идээ ундааны жинхэнэ товч 1330 он*. Монгол анагаах ухааны сурвалж бичиг судлалын цуврал. Арвай бархан, 2021.
- Цэвээн, Ц. *Байгалийн бүс бүслүүр дэх хот айлын бүтэц*. Уб, 1999.
- Чойжил, Д. «Ноос судлал». 2014.
- Чойжилжав, Х. *Малын үс ноосыг зөв авъя. Альбом*. Улаанбаатар: Д. Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинат, 1978.
- Ч.Сонгино. *Монголын бэлчээрийн мал маллагааны уламжлал*. Улаанбаатар: Соёмбо, 1991.
- Шульженко, И. *Животноводство Монгольской народной Республики*. Москва, 1953.
- Эрдэнэбат, Д. *Монгол улсын эдийн засаг дэлхийн хоёрдугаар дайны үед*. Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2018.
- Эрдэнэцогт, Н. *Монголын нүүдлийн мал аж ахуй*. Улаанбаатар: Урлах эрдэм, 1998.

- Aid by Trade Foundation. *The Good Cashmere Standard by AbTF*. Version 1.2., 2022.
https://thegoodcashmerestandard.org/wp-content/uploads/2022/03/The-Good-Cashmere-Standard-by-AbTF_v1.2_EN.pdf.
- Bold, Bat-Ochir. «Socio-economic segmentation — „Khot-Ail“ in nomadic livestock keeping of Mongolia». *Nomadic Peoples*, no 39 (1996): 69–86.
<https://www.jstor.org/stable/43123494>.
- Dalton, Matthew. «From H&M to Gucci, Fashion Rethinks Cashmere, Citing Environmental Harm». *The Wall Street Journal*, 13 Тавдугаар сар 2019, sec Business. <https://www.wsj.com/articles/fashion-companies-rethink-cashmere-11557749119>.
- Didier, Tagbata, & Sirieix Lucie. «Measuring consumer’s willingness to pay for organic and Fair Trade products». *International Journal of Consumer Studies* 32, no 5 (2008): 479–90.
- Empson, Rebecca. «Reproducing People and Prophecy in Mongolia». *Cambridge Anthropology* 25, no 3 (2005): 52–60.
<https://www.jstor.org.uwinnipeg.idm.oclc.org/stable/23820771>.
- Empson, Rebecca M. *Harnessing Fortune: Personhood, Memory and Place in Mongolia*. British Academy Postdoctoral Fellowship Monographs. Oxford, New York: Oxford University Press, 2011.
- Fisher, Josh. «In Search of Dignified Work: Gender and the Work Ethic in the Crucible of Fair Trade Production». *American Ethnologist* 45, no 1 (2018): 74–86.
<https://doi.org/10.1111/amet.12600>.
- Hawkes, Jon. *The Fourth Pillar of Sustainability: Culture’s Essential Role in Public Planning*. Common Ground, 2001.
- Howard, P.H., & P. Allen. «Consumer willingness to pay for domestic „fair trade“: Evidence from the United States». *Renewable Agriculture and Food Systems* 23, no 3 (2008): 235–42.
- Konuk, Faruk Anil. «Consumers’ willingness to buy and willingness to pay for fair trade food: The influence of consciousness for fair consumption, environmental concern, trust and innovativeness.» *Food research international (Ottawa, Ont.)* 120 (2019): 141–47. <https://doi.org/10.1016/j.foodres.2019.02.018>.

- Moberg, Mark. «Fair Trade and Social Justice: Global Ethnographies». In *Fair Trade and Social Justice*. New York University Press, 2010.
<https://doi.org/10.18574/nyu/9780814796207.001.0001>.
- Naylor, Lindsay. *Fair Trade Rebels: Coffee Production and Struggles for Autonomy in Chiapas*. U of Minnesota Press, 2019.
- Soini, Katriina, & Joost Dessein. «Culture-Sustainability Relation: Towards a Conceptual Framework». *Sustainability* 8, no 2 (Хоёрдугаар сар 2016): 167.
<https://doi.org/10.3390/su8020167>.
- Stella McCartney. «Recycled cashmere | Stella McCartney US». Stella McCartney, 2022. <https://www.stellamccartney.com/us/en/sustainability/recycled-cashmere.html>.
- United Cities and Local Governments - Committee on culture. «Agenda 21 for culture». Ajuntament de Barcelona, Institut de Cultura, 2008.
https://agenda21culture.net/sites/default/files/files/documents/multi/ag21_en.pdf.
- Wilkin, Shevan, Alicia Ventresca Miller, William T. T. Taylor, Bryan K. Miller, Richard W. Hagan, Madeleine Bleasdale, Ashley Scott, et al. «Dairy Pastoralism Sustained Eastern Eurasian Steppe Populations for 5,000 Years». *Nature Ecology & Evolution* 4, no 3 (Гуравдугаар сар 2020): 346–55.
<https://doi.org/10.1038/s41559-020-1120-y>.
- World Fair Trade Organization. «The WFTO Fair Trade Standard», 2020.
https://wfto.com/sites/default/files/WFTO_Standard_November%202020_print.pdf.